

**ХҮҮХДИЙН ЭРХИЙН ХУУЛЬ ЗҮЙН
ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА**



Санхүүжүүлэгч Европын Холбоо



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР



НҮБ-ын Хүүхдийн Сан



ХҮҮХДИЙН ЭРХИЙН ХУУЛЬ ЗҮЙН ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА

УЛААНБААТАР
2022 ОН

ХҮҮХДИЙН ЭРХИЙН ХУУЛЬ ЗҮЙН ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА



Санхүүжүүлэгч Европын Холбоо

МОНГОЛ УЛСАД ХҮҮХДИЙН ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА АВАХ ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ЗАМААР КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ҮР НӨЛӨӨГ БУУРУУЛАХ ТӨСӨЛ

Европын холбооны санхүүжилтээр Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллагын хэрэгжүүлж буй “Монгол улсад хүүхдийн хууль зүйн туслалцаа авах хүртээмжийг нэмэгдүүлэх замаар Ковид-19 цар тахлын үр нөлөөг бууруулах төсөл”-ийн хүрээнд уг гарын авлагыг бүтээв.

Энэхүү төслийн зорилго нь Монгол улсад хүүхэд хамгааллын тогтолцоог сайжруулан, ялангуяа Ковид 19 цар тахлын үед хууль зөрчсөн, сэжигтэн, гэрч, хохирогч болон эрсдэлт бүлгийн хүүхдэд хүрч үйлчлэх хууль эрх зүйн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд оршино.

ЗОХИОГЧ:

Х. БААВГАЙ доктор (Ph.D), дэд профессор

Зохиогчийн эрх@2022. Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага (ОУХЭЗБ)

Энэ гарын авлагын агуулга, үзэл бодлыг зохиогч бие даан боловсруулсан бөгөөд Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага, түүний гишүүдийн үзэл бодол, байр суурийг илэрхийлэхгүй болно.

Зохиогчийн эрхийн дагуу хамгаалагдсан. Энэхүү гарын авлагыг сургалтын зорилгоор ашиглах бол албан ёсны зөвшөөрөл авч, эх сурвалжийг дурдсаны үндсэн дээр үнэ төлбөргүй ашиглаж болно. Үүнээс өөр шалтгаанаар олшруулах, олон нийтэд хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд түгээхийг хориглоно. Дахин хэвлэх бол Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллагад мэдэгдэж зөвшөөрөл авна.

www.idlo.int

Чингэлтэй дүүрэг, Жигжиджавын гудамж,

Бодь цамхаг, 603 тоот

Улаанбаатар 15160, Монгол улс

ГАРЧИГ

ӨМНӨХ ҮГ	6
----------------	---

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ХҮҮХДИЙН ЭРХИЙН ХУУЛЬ ЗҮЙН ХОРООНЫ ТАЛААРХ ОЙЛГОЛТ, ХАНДЛАГА	7
--	---

1.1. Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо байгуулах үндэслэл, шаардлага:	7
1.2. Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагаагаа явуулах эрх зүйн орчин	8
1.3. Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны зорилго, үйл ажиллагаа	9
1.4. Хууль зүйн хороо төрийн ба төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах арга зам	10
1.5. Хорооны үйл ажиллагаанд жендэрийн эрх тэгш байдлыг хангах нь	11
1.5. Хууль зүйн хороо төрийн ба төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах арга зам	16

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ХЭХЗХ-НЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ШААРДЛАГАТАЙ ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ БА МОНГОЛ УЛСЫН ХУУЛИАС	19
---	----

2.1. Монгол Улсын олон улсын гэрээ	19
2.2. Монгол Улсын зарим хууль, тогтоомж	22

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ГЭМТ ХЭРГИЙН ГЭРЧ, ХОХИРОГЧ ХҮҮХДЭД ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ, ҮЙЛ АЖИЛЛАГАА	27
--	----

3.1. Гэрч, хохирогч хүүхдийн эрх ашгийг хамгаалахад шаардлагатай хууль, тогтоомж	27
3.2. Гэрч, хохирогч хүүхдэд үзүүлэх үйлчилгээ:.....	28
3.3. Ярилцах сэдэв ба хэлэлцэх кейс.....	32

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДСОН ХҮҮХДЭД ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ, ҮЙЛ АЖИЛЛАГАА	33
---	----

4.1. Сэжигтэн яллагдагч хүүхдийн эрх, хамгаалалтай холбогдох хуулиас:	33
4.2. Гэмт хэрэгт холбогдсон, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч хүүхдэд үзүүлэх үйлчилгээ	34
4.3. Мөрдөн шалгах ажиллагаанд тавих прокурорын хяналтын ажлын аргачилсан заавар-аас	39
4.4. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа ба хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ	41
4.5. Хорихоос суллагдсан болон хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээ авагдсан хүүхдийн эрхийг хангах, хамгаалахтай холбоотой хуулиас:	42

- 4.6. Сургалт хүмүүжлийн тусгай төвөөс суллагдсан хүүхдийн асуудлыг тусгайлан авч үзэх нь53
- 4.7. Ярилцах сэдэв ба хэлэлцэх кейс:.....56

ТАВ ДУГААР БҮЛЭГ. ХҮҮХДИЙН ЭРХИЙН ХУУЛЬ ЗҮЙН ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АРГА ЗҮЙ58

- 5.1. Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа58
- 5.2. Нийгэмшихүйн чиглэлээр зохион байгуулах үйл ажиллагааны арга хэлбэр:60
- 5.3. Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны хуралдааны үлгэрчилсэн загвар68

ХАВСРАЛТ.....73

1. ХЭХЗХ-ны шинэчилсэн журам.....73
2. Хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа ба про боно үйлчилгээ.....87
3. Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны талаарх олон улсын туршлага, чиг хандлага /ХЗҮХ-ийн судалгаанаас/:90
4. Хүүхдийн эрх, хамгаалалтай холбогдох нэр томьёо, ухагдахууны тайлбар толиос..92

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ 108

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ГБХЗХГ	Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар
ГБХЗХХ	Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэс
ГХУСАЗЗАА	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба
ОУЭЗХБ	Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага
ХХҮГ	Хөдөлмөр халамж үйлчилгээний газар
ХНХЯ	Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам
ХЗДХЯ	Хууль зүй дотоод хэргийн яам
ХЭХЗХ	Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ХЭССХ	Хүүхдийн эрхийн сургалт, судалгааны хүрээлэн
ТББ	Төрийн бус байгууллага
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
СХД	Сонгинохайрхан дүүрэг
ХЧААХАХ	Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүүхэд
МУЗГ	Монгол Улсын Засгийн Газар
НҮБХЭХ	НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Хороо
БЗД	Баянзүрх дүүрэг
ЦГ	Цагдаагийн газар
ХЭК	Хүүхдийн Эрхийн тухай Конвенц
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ХХША	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа
ХЁТ	Хууль ёсны төлөөлөгч
АХХД	Асран хамгаалагч харгалзан дэмжигч
СХТБ	Сургалт хүмүүжлийн тусгай байгууллага
НЭЗЗ	Нийгэм эдийн засгийн зөвлөл
ЭХХШТХ	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

ӨМНӨХ ҮГ

Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллагын Монгол дахь суурин төлөөлөгчийн газар нь Европын Холбооны санхүүжилтээр “Монгол Улсад хүүхдийн хууль зүйн туслалцаа авах хүртээмжийг нэмэгдүүлэх замаар Ковид-19 цар тахлын үр нөлөөг бууруулах” төслийг хэрэгжүүлж, Монгол улсад хүүхэд хамгааллын тогтолцоог сайжруулан, ялангуяа Ковид 19 цар тахлын үед хууль зөрчсөн, сэжигтэн, гэрч, хохирогч болон эрсдэлт бүлгийн хүүхдэд хүрч үйлчлэх хууль эрх зүйн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхийг зорьж байгаа билээ.

Энэхүү төслийн хүрээнд “Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагаанд зориулсан гарын авлага”-ын төслийг шинэчлэн боловсруулж, холбогдох байгууллагын мэргэжилтэн, алба хаагч, ажлын хэсгийн гишүүд, гарын авлагын эцсийн хэрэглэгчтэй 3-4 удаагийн асуулга, ярилцлага зохион байгуулж, тэдний санал, шүүмжийг тусгасан болно.

Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны гишүүд нь хүүхдийн эрх, хамгааллын талаар хууль, эрх зүйн тодорхой мэдлэгтэй байж, гэмт хэрэгт холбогдсон, гэмт хэргийн гэрч, хохирогч болсон хүүхдэд хамгааллын үйлчилгээг явуулахдаа хуулийг зөв, үр дүнтэй хэрэглэдэг, үйл ажиллагааг оновчтой арга зүйгээр зохион байгуулдаг, жендэрийн мэдрэмжтэй хандлага бүхий чадвар эзэмшсэн байх нь ач холбогдолтой хэмээн үзэж “Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагааны гарын авлага”-ыг боловсруулаа.

Энэхүү гарын авлагаас Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо байгуулах үндэслэл, шаардлага, түүний эрх зүйн орчин, зорилго, чиглэл, хорооны үйл ажиллагаанд жендэрийн эрх тэгш байдлыг хангах асуудал, төрийн ба төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах арга зам, ХЭХЗХ-ны үйл ажиллагаанд шаардагдах олон улсын гэрээ ба монгол улсын хууль тогтоомж, гэрч, хохирогч болон гэмт хэрэгт холбогдсон хүүхдэд үзүүлэх, үйлчилгээ, хорооны үйл ажиллагааны арга зүйн талаар мэдлэг, ойлголтыг авах болно.

Түүнчлэн уг гарын авлагад “Хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа ба про боно үйлчилгээ”, “Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны талаарх олон улсын туршлага, чиг хандлага”, “Хүүхдийн эрх, хамгаалалтай холбогдох нэр томьёо, ухагдахууны тайлбар”-ыг хавсарган оруулсан нь зөвхөн хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны гишүүдэд төдийгүй хүүхэдтэй ажилладаг хүн бүр ашиглаж болох чухал хэрэгцээтэй зүйл гэж үзэж байна.

Энэхүү гарын авлага нь хүүхдийн эрх, хамгааллын асуудалд шинжлэх ухаанчаар хандах, хүүхдийн эрхэд суурилсан чиг хандлагыг эрхэмлэх зарчмыг хослон баримталсан нь онцлогтой болсныг тэмдэглэж байна. Гарын авлагыг бүтээхэд цаг зав, сэтгэл, оюунаа зориулан ажилласан “Ажлын хэсэг”-ийн гишүүд, ХНХЯ, МУГХУСА33-ын Ажлын алба, ЦЕГ, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг ГБХЗХГ, НҮБ-ын Хүүхдийн Сангийн удирдлага, мэргэжилтнүүд, Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллагын Монгол дахь суурин төлөөлөгч Тара Нил, төслийн зохицуулагч Н. Одонтуяа нарт чин сэтгэлийн талархал илэрхийлье.

**Монгол улс дахь Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллагын
суурин төлөөлөгчийн газар**



ХҮҮХДИЙН ЭРХИЙН ХУУЛЬ ЗҮЙН ХОРООНЫ ТАЛААРХ ОЙЛГОЛТ, ХАНДЛАГА

1.1. ХҮҮХДИЙН ЭРХИЙН ХУУЛЬ ЗҮЙН ХОРОО БАЙГУУЛАХ ҮНДЭСЛЭЛ, ШААРДЛАГА:

Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулиуд шинээр хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан 2017 оноос Монгол Улсын аймаг, дүүрэг бүрд Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо байгуулагдан ажиллаж байна.

ХЭК-ийн хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Засгийн газрын Ү дугаар тайланг хэлэлцээд НҮБ-ын ХЭХ-оос ирүүлсэн дүгнэлт зөвлөмж (43)-д Хүний эрхийн төлөв байдлын талаарх ээлжит хэлэлцүүлгийн тайландаа “Насанд хүрээгүй хүний хэргийг хянан шийдвэрлэх, олон улсын стандартад нийцсэн цогц бодлогын хүрээг бүрдүүлнэ гэж амлалтаа нэн даруй биелүүлэхийг шаардаж, өмнөх дүгнэлт зөвлөмжийн 76 параграфийг түүнчлэн эрүүдэн шүүх болон бусад хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын хорооноос 2016 онд өгсөн зөвлөмжийн параграф 24 хэрэгжүүлэхийг зөвлөсөн байна. Тухайлбал: ХЭК-ийн зарчмууд, зүйл заалтуудын талаар зохих сургалтад хамрагдсан хүүхдийн мэргэшсэн шүүгчдийг тусгайлан томилдог байх; Төлбөрийн чадваргүй хүүхдүүдэд үнэ төлбөргүй хуулийн зөвлөгөө өгөх гэх мэт хууль зөрчсөн хүүхдэд хууль зүйн мэргэжлийн, бие даасан, чанартай тусламж үйлчилгээг үзүүлэхэд анхаарах; Эрүүгийн хууль зөрчсөн гэж сэжиглэгдэж байгаа хүүхдийг батлан даалтад өгөх, тэнсэх, эвлэрүүлэн зуучлах, зөвлөгөө өгөх, нийтэд тустай ажил хийлгэх гэх мэтээр шүүхээр оруулахгүйгээр хэргийг нь шийдвэрлэдэг арга барилыг (diversion) бэхжүүлэх, хэрвээ ял шийтгэл оногдуулах бол аль болохоор хорихоос өөр хувилбарыг ашиглах, хорих ялыг хамгийн сүүлчийн арга хэмжээ болгон, байж болох хамгийн бага хугацаагаар хорих гэсэн хувилбараар ашиглах, ийм ял өгсөн бол ялыг цуцлах боломжтой юу гэсэн үндэслэлээр хэргийг тогтмол магадлангаар оруулж байх; Хорих ялыг оноохоос өөр аргагүй үед хүүхдийг насанд хүрэгчидтэй хамт хорихгүй, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ хүртээмжтэй байх гэх мэт олон улсын стандартад хорих газрын нөхцөл байдал нийцсэн байхад анхаарах”¹-ыг шаардсан байдаг.

Хүүхдийн хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөр (2017-2021) ийг МУЗГ-ын 270 дугаар тогтоолоор баталсан. Уг хөтөлбөрийн 3.4.2.5-д “гэмт хэргийн гэрч, хохирогч болсон, сэжигтэн, мөрдөн шалгагдаж байгаа, ял шийтгүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан, шүүхээр шийтгэгдсэн хүүхдэд хууль зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагааг тогтмолжуулах”-аар тусгажээ.

18 хүртэл насны шүүхээр шийтгэгдсэн хүүхдийн тоо 2019 онд 360, 2020 онд 228 байсан бол гэмт хэргийн хохирогч хүүхдийн тоо 2019 онд 1598, 2020 онд 1181, гэмт хэргийн сэжигтэн хүүхдийн тоо 2019 онд 1068, 2020 онд 811 байна.²

Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо хэмээх нэгжийг олон улсын жишиг стандарт, дүрэм журмуудад улам нийцүүлэн аливаа хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд

1 ХЭК-ийн хэрэгжилтийн талаарх МУЗГ-ын Ү тайланд НҮБХЭХ-ны өгсөн дүгнэлт, зөвлөмж, УБ, 2017, 20-21 дэх тал

2 ЦЕГ-ын статистик. 2021 он.

оролцогч хүүхэд бүрд зохих тусламж үйлчилгээг үзүүлж, анхаарал хандуулж ажиллах шаардлага байна.

Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо нь хүүхэд хамгааллын тогтолцооны чухал институци бөгөөд хүүхэд оролцсон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүхий л явцад тухайн оролцогч хүүхдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйлчилгээ үзүүлэх, тухайн хүүхэдтэй холбоотой нийгэм, эдийн засгийн олон хүчин зүйл, шалтгаан, тулгамдсан асуудлыг судлах төдийгүй хянан шийдвэрлэх ажиллагаа хүүхдэд ээлтэй байх зарчмыг хангах нөхцөлийг бүрдүүлэхэд хувь нэмэртэй юм.

1.2. ХҮҮХДИЙН ЭРХИЙН ХУУЛЬ ЗҮЙН ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААГАА ЯВУУЛАХ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

ХЭХЗХ үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль³, Монгол Улсын нэгдэн орсон, соёрхон баталсан Олон улсын гэрээ⁴, олон улсын стандарт дүрэм, журам⁵, тэдгээрт нийцүүлэн гаргасан Монгол улсын хууль, тогтоомжууд⁶-ыг баримтална. Тухайлбал,



Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомж

Олон улсын гэрээ, конвенцүүд

- Хүүхдийн эрхийн тухай Конвенц[1989]
- Хүүхдийг хамгаалах болон улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай конвенц [1993]
- Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд оролцуулахын эсрэг Хүүхдийн эрхийн тухай конвенцид оруулах нэмэлт протокол[2003]
- Хүүхдийг худалдах, хүүхдийн биенийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг Хүүхдийн эрхийн тухай конвенцид оруулах нэмэлт протокол[2003]
- Мэдээлэл хүргүүлэх журмын тухай НҮБ-ын нэмэлт протокол[2015]
- Хүний эрхийн түгээмэл тунхаглал[1961]
- Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт[1974]
- Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт [1974]
- Хүүхдийн хөдөлмөрийн тэвчигшгүй хэлбэрүүдийг хориглох, нэн даруй устгах тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 182 дугаар конвенц[2000]
- Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэргийг, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц[1974]
- Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц[1981]
- Олон улсын эрүүгийн шүүхийн ромын дүрэм[2002]

Монгол улсын хууль

- 1992 он Монгол Улсын үндсэн хууль
- 2016 он Хүүхэд хамгааллын тухай хууль
- 2016 он Хүүхдийн эрхийн тухай хууль
- 2015 он Хүүхэд харах үйлчилгээний тухай
- 1999 он Гэр бүлийн тухай хууль
- 2016 он Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль
- 2017 он Зөрчлийн тухай хууль/шинэчилсэн найруулга/
- 2017 он Зөрчил шалган шийдвэрлэх тухай
- 2015 он Эрүүгийн хууль/шинэчилсэн найруулга/
- 2017 он Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай/шинэчилсэн найруулга/
- 2013 он Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль
- 2011 он Жэндэрийн эрх тэгш байдлыг хангах тухай
- 2019 он Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай
- 2012 он Нийгмийн халамжийн тухай
- 2019 он Засгийн газрын тусгай сангийн тухай
- 2002 он Бага, дунд боловсролын тухай

ХЭХЗХ нь Хууль зүйн болон хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран баталсан “Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам”⁷ болон оролцогч, хамтрагч талуудын хооронд байгуулсан гэрээ, хамтран гаргасан журам, дүрмүүдийг үйл ажиллагаандаа удирдлага болгоно. Түүнчлэн хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой эрх бүхий байгууллагаас гаргасан журам, зөвлөмж, аргачлал зааварчилгааг мөрдөн ажиллах шаардлагатай.

3 <https://www.legalinfo.mn/law>. Хуулийн нэгдсэн портал сайтаас үз.

4 Гарын авлагын хоёрдугаар бүлгээс дэлгэрэнгүй үзнэ үү.

5 Гарын авлагын хавсралтад буй журам, дүрмийг үз. тал.

6 Гарын авлагын хоёрдугаар бүлгийг үзнэ үү.

7 Журмын эхийг хавсралаас үзнэ үү.

1.3. ХҮҮХДИЙН ЭРХИЙН ХУУЛЬ ЗҮЙН ХОРООНЫ ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо гэж гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэж сэжиглэгдэж, мөрдөн шалгагдаж байгаа, эсхүл гэмт хэргийн гэрч, хохирогч болсон, гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан, зөрчил үйлдэж шийтгэгдсэн хүүхдэд үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллагын төлөөлөл бүхий орон нутгийн нэгж⁸ юм. Өөрөөр хэлбэл дунд шатны салбар дундын зохицуулалт бүхий хуулиар байгуулагдсан нэгж бөгөөд хууль хяналтын байгууллагын хүрээлэлд хамаарагдаж буй хүүхдийн эрх, хамгааллын асуудлыг авч үздэг, хяналт тавьдаг, мэргэжлийн үйлчилгээ үзүүлдэг Хүүхдийн эрхийн хяналтын нэг механизм.

Тус хороо нь эрүүгийн хэргийн оролцогч⁹ хүүхдэд эрх зүйн туслалцаа, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх, боловсролын, эрүүл мэндийн, нийгмийн халамжийн гэх нийгмийн цогц үйлчилгээнд хамруулах, дэмжин туслах, тэдний эрх, ашиг сонирхлыг ханган, хамгаалахад чиглэсэн үйл ажиллааг явуулахаар Хүүхэд хамгааллын тухай хуульд "...гэмт хэрэг үйлдэж шүүхээс ял шийтгүүлсэн, хүмүүжлийн чанартай арга хэмжээ авагдсан хүүхдийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас хүлээн авах, шүүхээс хүүхдэд даалгасан үүргийг биелүүлэхэд зөвлөгөө өгөх, дэмжлэг, туслалцаа үзүүлэх; сургалт, хүмүүжлийн тусгай байгууллагад хүмүүжиж байгаад суллагдсан хүүхдийг нийгэмд хэвийн амьдрахад нь дэмжлэг, туслалцаа үзүүлэх; гэмт хэрэг, зөрчилд холбогдон шалгагдаж байгаа хүүхдийг эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны сөрөг нөлөөллөөс хөндийрүүлэх зорилгоор хууль сахиулах байгууллагатай хамтран ажиллах, хүүхдэд батлан даагч томилуулахаар санал гаргах; хууль зөрчсөн хүүхдийг зөв зохистой хүмүүжил олгох сургалт, хөтөлбөрт хамруулах; эцэг, эх, гэр бүлийн гишүүд, үе тэнгийнхэн, сургууль, хамт олонд нь зөвлөгөө өгөх, тогтмол хугацаанд уулзалт, ярилцлага зохион байгуулж, үр дүнг тооцох; хорт зуршлаас ангижрах эмчилгээнд хамруулах, зөвлөгөө өгөх, ажил, сургууль, мэргэжил олгох сургалтад хамруулах; Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн үйлчлэлд хамаарахгүй хүүхдэд туслалцаа үзүүлэх, зөвлөгөө өгөх, тэдний эрх ашгийг хамгаалах;"¹⁰ гэж тодорхой заасан байна.

Иймд ХЭХЗХ нь гэмт хэргийн хохирогч, гэрч, сэжигтэн, яллагдагч болон гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн, зөрчил үйлдэж шийтгүүлсэн, хорихоос суллагдсан хүүхдийн асуудлыг хамаарч үйл ажиллагаагаа явуулах юм.

Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны зорилго

Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны зорилго нь гэмт хэргийн гэрч, хохирогч болсон, хууль зөрчсөн хэмээн сэжиглэгдэн шалгагдаж, шүүгдэж байгаа болон хорихоос өөр төрлийн ял авсан, сургалт хүмүүжлийн тусгай байгууллагаас суллагдсан хүүхдийн эрх, эрх чөлөөг хангах, эрх ашгийг нь хамгаалахад чиглэсэн арга хэмжээ авах, шаардлагатай үйлчилгээнд хамруулах замаар хорьж шийтгэхээс хөндийрүүлэх, дахин гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэхэд оршино. Өөрөөр хэлбэл хэрэг, зөрчил шалган шийдвэрлэх, шүүн таслах ажиллагаанд хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлнэ гэсэн үг юм.

8 Хүүхэд хамгааллын тухай хууль. 4.1.3 дахь заалт.

9 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.13 дахь заалтыг үз. <https://www.legalinfo.mn/law>.

10 Хүүхэд хамгааллын тухай хуулийн 15 дугаар зүйлийг үз. <https://www.legalinfo.mn/law>.

Хорооны Ажлын албаны чиг үүрэг

Хорооны ажлын албаны чиг үүргийг “Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам”¹¹-д тодорхой заасан байдаг.

Ажлын алба нь хороог хуралдуулах, хэлэлцэх асуудлыг тодорхойлох, бэлтгэх, тэмдэглэл хөтлөх, албажуулах, шийдвэрийн хэрэгжилтийг хангах, биелэлтэд хяналт тавих, хорооноос хүүхдэд үзүүлж буй үйлчилгээний чанар, үр дүнд хяналт тавих, хорооны үйл ажиллагааны хэрэгжилт, иргэдийн санал гомдлын талаар хорооны дарга, гишүүдэд мэдээлэл, танилцуулга хийх, статистик мэдээ авч нэгтгэх, тайлан гаргах гэх мэт. Жишээ нь: Хамтарсан багаас болон иргэд, цагдаагийн байгууллагаас шууд ирүүлсэн мэдээлэлд /кейст/ шинжилгээ, үнэлгээ хийж, кейсийн эзний хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, авах арга хэмжээ, үйлчилгээний талаарх саналаа боловсруулна. Энэхүү саналаа Хорооны даргад хорооны хурал хуралдуулах тухай тоот/цахим мэдээ/-ын хамт хүргүүлнэ. Хурлаар Ажлын албанаас ирүүлсэн саналыг хэлэлцэн үйлчилгээ үзүүлэх болон авах арга хэмжээний хэрэгжилтийг хангах субъектүүдэд тэмдэглэлээр үүрэг, чиглэл өгнө.

Хороо “Хамтарсан баг”-тай хэрхэн хамтарч ажилладаг вэ?

Хамтарсан багаас шилжиж ирсэн Хорооны хамрах хүрээний кейсийг бусад материалын хамт Ажлын албаар дамжуулан хүлээн авч шийдвэрлэх, шийдвэрийн дагуу “Хамтарсан багт” хамтран ажиллах дэмжих чиглэлээр зөвлөгөө чиглэл өгөх гэх мэт.

1.4. ХУУЛЬ ЗҮЙН ХОРОО ТӨРИЙН БА ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААГ САЙЖРУУЛАХ АРГА ЗАМ

Хорооны Ажлын алба хорооны бүрэлдэхүүнд байгаа төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтын ажиллагааны санамж бичиг, хамтарсан журам, төлөвлөгөө батлан хэрэгжүүлэх нь үр дүнтэй ажлын хэлбэр болж байна.

Энэ талаар хийж, хэвшиж байгаа сайн туршлагын арга хэлбэрүүд байна. Тухайлбал, Архангай аймагт ХЭХЗХ нь яаралтай хуралдан гэмт хэргийн сэжигтэн хүүхдийг өмгөөлөгчид “баг” болж өмгөөлөн ажилласан нь үр дүнд хүрчээ. Говьсүмбэр аймгийн Хууль зүйн хороо(ГБХЗХХ) гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдож, шүүхээс хорихоос өөр төрлийн ялаар шийтгүүлсэн хүүхдэд хувийн хэрэг нээж, ЦГ, ЭМГ, БСУГ-тай хамтран ажиллаж, зан байдал засрал хүмүүжилд нөлөөлөх сургалтыг зохион байгуулсан байна. Булган ХЭХЗХ (ЦГ) оролцогч бүх талуудтай хамтран ажиллахаар санамж бичиг байгуулж, ажлын өдөр бүр 9.00 цагт хэрэгт холбоотой хүүхдийн талаарх мэдээллийг харилцан солилцдог болсон байна.

Хөвсгөл аймгийн ХЭХЗХ (ЦГ) бага насны хүүхдийн эсрэг үйлдэгдсэн бэлгийн хүчирхийллийн шалтгааныг тогтооход хууль зүйн хорооноос үзүүлсэн үйлчилгээний хүрээнд чухал мэдээ, нотлох баримтыг илрүүлсэн нь хууль сахиулагчдад үнэлэгдсэн байна. Ховд аймгийн ХЭХЗХ 2015 оны Эрүүгийн хууль өсвөр насныханд хатуудсан хорих ялыг өөрчлүүлэх нөлөөллийн ажлыг ТББ-тай хамтран амжилттай өрнүүлж, хуулийн зохих заалтыг яаралтай өөрчлүүлж чадсан байна. Мөн гэр бүлийн хүчирхийллийн олон хохирогчтой хэрэгт хохирогч бүрийн эрхийг хамгаалж үр дүнтэй ажилласан туршлага байна. БЗД-ийн ХЭХЗХ Прокурорын

11 Журмын эхийг хавсралтаас үз.

байгууллагатай хамтран ХЧААХ-тэй хүүхдүүдийг зохион бичлэгийн уралдаанд оролцуулсан нь амжилттай болсон байна. Мөн Завхан аймгийн ХЭХЗХ журамд заасан бүрэлдэхүүнээс гадна хорооны үйл ажиллагаанд туслах хамтран ажиллах “мэргэжилтний баг” байгуулан ажилласан нь илүү шуурхай үр нөлөөтэй ажиллах нөхцөл бүрдүүлсэн байна. Түүнчлэн хохирогч хүүхдийн хөрөнгийг битүүмжлүүлсэн асуудлыг анх удаа нэхэмжлэл үүсгэн прокурорт хандаж, хохирогчийн сэтгэл зүйн хохирлыг тооцуулж тогтоолгоход хорооны гишүүд хамтран ажилласан байна¹².

Төр, иргэний нийгмийн байгууллагуудын түншлэл, хамтын ажиллагаанд жендэрийн бодлогыг хэрэгжүүлэхийн тулд жендэрийн тэгш байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх олон талт сонирхогч талуудын түншлэлийг хөгжүүлж, чадавхжуулах, жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүчирхийллийн хохирогчид үзүүлэх нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, ялгаварлан гадуурхах бүх хэлбэртэй тэмцэх үндэсний болон олон улсын гэрээ, эрх зүйн актуудыг практикт хэрэгжүүлэх нэгдмэл орчныг үндэсний хэмжээнд бүрдүүлэх нь чухал байна.

1.5. ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ НЬ

Хороо нь үйл ажиллагаандаа жендэрийн эрх тэгш байдлыг хангах зарчмыг баримтлах ёстой. Үүний тулд хорооны бүрэлдэхүүнд хүйсийн тэнцвэрт байдлыг харгалзах, төсөв болон төлөвлөлт, үйл ажиллагаа, үйлчилгээндээ жендэрийн мэдрэмжтэй хандах, мэдээлэл, мэдээллийн сангийн тоон үзүүлэлт бүр жендэрийн статистиктай буюу хүйсээр ангилагдсан байх шаардлагатай.

Хорооны гишүүд, мэргэжилтнүүд гэмт хэргийн “оролцогч” субъектүүдтэй харилцахдаа түүнчлэн мөрдөн байцаах, шүүн таслах үйл ажиллагааны бүхий л шатанд болон уг ажиллагааны дараа ч жендэрийн асуудлыг цаг ямагт анхаарч байх ёстой. Үүний тулд жендэрийн мэдрэмжтэй, жендэрийн хэвшмэл бус хандлагатай байхыг зүй ёсоор шаардаж байна.

Жендэр (Gender) гэдэг нь эрэгтэй, эмэгтэй хүмүүст аль алинд нь хамаатай ойлголт. Энэ нь эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн нийгмийн үүргийг ялгаж ойлгохын тулд хэрэглэх болсон нэр томъёо юм.

Харин хүйс (Sex) нь эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн насан туршид нь үл өөрчлөгдөх биологийн ялгааг илэрхийлдэг.

Жендэр нь эрэгтэй, эмэгтэй хүнд хүйсээс нь шалтгаалан нийгмээс оноосон дүр төрх, үнэлэмж, үүрэг хариуцлага, байр суурь, эрх мэдлийг илэрхийлдэг ойлголт юм. Тодруулбал, жендэр нь эрэгтэй, эсвэл эмэгтэй байхаас хамааран тухайн хүнд нийгмээс юу хийж болох, болохгүйг тулгаж, ямар байр суурь эзлэхийг тодорхойлж, ямар үүрэг хариуцлага хүлээхийг хуваарилж, энэхүү хүлээлт, шаардлагын дагуу биеэ авч явж, зан үйлээ тохируулахыг шаардаж, шахалт үзүүлдэг нийгмийн хүлээлт, итгэл үнэмшил, дүрэм, журмыг илэрхийлдэг хувьсах хэмжигдэхүүн юм¹³.

12 ХЭХЗХ-ны үйл ажиллагааны хэрэгжилтэд хийсэн үнэлгээний тайлан. ХЗССХ, 2021 он.

13 “Амьдрах ухааны чадвар” цуврал 13 гарын авлагын арван хоёр дахь модуль, “Жендэрт суурилсан хүчирхийллээс сэргийлэх”. НҮБХАС, МУБИС. 2014 он.

Жендэрийн асуудал нь нийгэм, соёл бүрд харилцан адилгүй бөгөөд цаг хугацааны туршид хувьсан өөрчлөгдөж байдгаараа эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн хоорондох түгээмэл шинжтэй, хувьсан өөрчлөгддөггүй биологийн ялгаатай холбоотой “хүйс” (sex) хэмээх нэр томъёоноос ялгаатай. Жендэр нь нийгмийн анги давхраа, нас, арьс өнгө, яс үндэс, шашин шүтлэг, газарзүй, эдийн засаг, улс төр, соёлын орчин гэх зэрэг олон үзүүлэлттэй харилцан хамааралтай.

Эмэгтэй, эрэгтэй хүмүүс нийгэмдээ болон хувийн амьдралын хүрээндээ эн тэгш үнэлэгдэж, тэгш эрх мэдэл, оролцоотой байх¹⁴-ыг жендэрийн тэгш байдал гэдэг. Тэгш байдлыг хангана гэдэг нь эмэгтэй, эрэгтэй хүмүүст яг адилхан хандана гэсэн үг биш, харин нөхцөл байдал, боломж, бололцоог нь адил тэгш болгоход анхаарахыг хэлж байгаа юм. Өөрөөр хэлбэл, эрэгтэй, эмэгтэй хүмүүс ижил гэсэн үг биш, харин тэдний эдлэх боломж бололцоо нь тэгш байхын зэрэгцээ нийгэм, гэр бүлдээ эзлэх байр суурь, эрх үүрэг нь адил байна гэсэн үг.

Жендэрийн тэгш бус байдал нь хүний эрхийн зөрчил, ялгаварлан гадуурхалтыг үүсгэж, хүйсээс нь шалтгаалан боломж, бололцоог нь хязгаарлаж байдаг. Үүний нэг илрэл нь жендэрт суурилсан хүчирхийлэл юм.

Хүчирхийлэл үйлдэгч нь аль ч хүйсийн хүн байж болох хэдий ч энэ төрлийн хэргийн тоо баримтаас харахад ихэнх тохиолдолд эрчүүд байна. Жендэрт суурилсан хүчирхийлэл нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн аль алинд тэгш бус байдлыг бий болгоод зогсохгүй хохирогчийн эрүүл мэнд, хараат бус, бие даасан байдал, аюулгүй байдалд хохирол учруулдаг. Хүчирхийлэл нь сэтгэцийн эрүүл мэндэд ноцтойгоор нөлөөлдөг бөгөөд сэтгэл зүйн гүн цочролд оруулдаг. Охид эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн болон бэлгийн эрүүл мэнд, биеийн эрүүл мэндэд нь ноцтойгоор нөлөөлөхөөс гадна зарим тохиолдолд үхэлд ч хүргэх магадлалтай. Жендэрт суурилсан хүчирхийлэл үйлдэгдэхэд архидалт, ядуурал, боловсролын түвшин зэрэг өөр хоорондоо холбоотой олон хүчин зүйл нөлөөлдөг. Гэвч суурь шалтгаан нь эрэгтэй, эмэгтэйчүүдийн хоорондын эрх мэдлийн тэгш бус байдал юм. Эрх мэдлийн тэгш бус байдал нь зөрчил, айдас, түгшүүр, хонзогнол, түрэмгийлэл, хүчирхийллийг төрүүлж байдаг¹⁵.

Хорооны гишүүн таны бүхий л үйл ажиллагаа жендэрийн мэдрэмжтэй, жендэрийн эрх тэгш байдлыг хангасан байх ёстой бөгөөд бусдад энэ талаар манлайлал үзүүлж байвал зохистой. Үүний тулд та өөрийнхөө жендэрийн талаарх мэдлэг, чадвар, хандлагаа үнэлнэ үү.

14 Жендэрийн нэр томъёо тодорхойлолт, үндсэн ойлголтуудын тайлбар толь. 32 дахь тал.УБ, 2013 он

15 “Амьдрах ухааны чадвар” цуврал 13 гарын авлагын арван хоёр дахь модуль, “Жендэрт суурилсан хүчирхийллээс сэргийлэх”. НҮБХАС, МУБИС. 2014 он.

ҮНЭЛГЭЭ¹⁶**1-р хэсэг. Мэдлэг**

Д/Д	Өгөгдөл	Тийм	Үгүй	Мэдэхгүй
1	Хүнд байгалиас заяагдсан мэдрэмж, хүсэл зориг, эрмэлзэл, чадавхыг нийтэд нь “хүний эрхэм чанар” гэж ойлгодог.			
2	Хүний эрхэм чанар нь хүний нэр төр, алдар хүндтэй адилхан ойлголт.			
3	Жендэр ба хүйс нь хоорондоо ялгаатай ойлголт.			
4	Эрх мэдэл нь амьдралын салшгүй нэг хэсэг бөгөөд бидний шийдвэр, сонголтод байнга нөлөөлдөг.			
5	Зөрчлийг шийдвэрлэх нь түүнийг үүсгэж байгаа асуудлыг шийднэ гэсэн үг.			
6	Ажлын байрны бэлгийн дарамт гэдэгт ажлын байр, сургалтын орчинд хэн нэгнийг бэлгийн сэдэлтэйгээр дарамт, шахалт үзүүлж, бэлгийн харилцаанд оруулах зэрэг үйлдлийг хамруулан ойлгоно.			
7	Эрх мэдлийн тэгш бус байдал ихэнх тохиолдолд ямар нэгэн төрлийн хүчирхийлэлд хүргэдэг			

2-р хэсэг. Чадвар

Д/Д	Өгөгдөл	Тийм	Үгүй	Мэдэхгүй
1	Хүчирхийлэлд өртсөн тохиолдлоо нуулгүй хэн нэгэнд хэлж, тусламж авна.			
2	Чамайг хүсээгүй байхад биед чинь хүрэх зэрэг үйлдэл хийвэл тухайн хүнд дургүй байгаагаа шууд хэлнэ.			
3	Аливаа хүчирхийлэлд өртсөн тохиолдлыг мэдээлж, тусламж авахаар хандаж болох байгууллагын хаяг, утсыг би мэднэ.			
4	Хашаа хэнтэй болзоонд явж байгаагаа гэр бүлийнхээ хэн нэгэнд заавал хэлдэг.			

3-р хэсэг. Үзэл бодол, хандлага

Д/Д	Өгөгдөл	Санал бүрэн нийлнэ	Санал нийлнэ	Эргэлзж байна	Санал нийлэхгүй	Санал огт нийлэхгүй
1	Жендэрийн үүрэг хариуцлага эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хувьд адилхан.					
2	Ажлаа бүтээхийн тулд эрх мэдлээ хэтрүүлэн ашиглах тохиолдол гарч болно.					
3	Байгууллага, хамт олны хүйсийн харьцааг тэнцвэржүүлэхийн тулд цөөнхийн төлөөллийг сонгох шийдвэрийг удирдлага гаргаж болно.					
4	Танихгүй хүн л биш бол хамт ажилладаг эсвэл хамт сурдаг хүмүүс чиний биед хүрэх зэрэг үйлдэл нь байдаг л зүйл.					
5	Эрчүүд, эмэгтэйчүүдийн эрх мэдлийн харьцаанаас үл хамааран хүн бүр эрүүл, сайхан амьдрах боломжтой.					

Өөрийгөө үнэлсэн танд баярлалаа. Хэрэв та үнэлгээндээ эргэлзээтэй, итгэл үнэмшил багатай байгаа бол Жендэрийн Үндэсний хорооны <https://www.gender.gov.mn> сайтад зочлон “ном хэвлэл” булангаас жендэрийн талаарх мэдлэгээ бататгаж болно.

Хүйсээр ангилсан мэдээлэл¹⁷: Хүнтэй холбоотой аливаа статистик мэдээллийг хүйсээр, мөн нас, албан тушаалын зэрэглэл зэрэг холбогдох бусад үзүүлэлтээр ангилан цуглуулж, тайлагнах нь жендэрийн дүн шинжилгээ хийх, жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт хийх, хэрэгжүүлэх эн тэргүүний алхам юм. Салбар, байгууллагын үйл ажиллагаанд бүтээгдэхүүн үйлчилгээний хүртээмж, эмэгтэй, эрэгтэй хүний оролцооны дүр зургийг гаргахад хүйсээр ангилсан мэдээлэл тусална. Энэ нь хүүхэдтэй холбоотой тоо баримт, мэдээллийг цуглуулах, шинжлэх, түгээхдээ хүйсээр ангилан нас, оршин суугаа газар, орлого зэрэг бусад үзүүлэлтүүдээр ялгах үйл ажиллагаа юм. Тэдгээр нь чанар, хамрах хүрээг тэгш авч үзэх, тоо мэдээллийн зөрүүтэй байдлыг арилгахад чиглэгдэнэ.

Хүйсээр ангилсан тоон мэдээлэл, тухайн цаг үеийн нийгмийн хэрэгцээнд тохирсон арга хэрэгслийн тусламжтайгаар жендерийн хэвшмэл сэтгэлгээ, тэгш шударга бус нөхцөл байдлыг өөрчлөхөд чиглэсэн бодлого боловсруулах үйл явц юм. Хүйс нь статистикийн нэгэн үзүүлэлт бөгөөд хүйсээр ангилсан тоо мэдээлэл нь охид хөвгүүдийн, эмэгтэй эрэгтэй хүмүүсийн бодит нөхцөл байдлыг харьцуулан үзэх, жендерийн зөрүү, тэгш бус байдлыг илрүүлэх боломж олгохоос гадна тэрхүү шударга бус байдлыг залруулах үндэслэл болдог. Харин жендерийн мэдрэмжтэй статистик нь тоон мэдээ, мэдээллийг хүйсээр ангилан цуглуулахаас хавьгүй өргөн хүрээний үйл ажиллагаа бөгөөд хөгжлийн олон асуудлыг шийдвэрлэх үйл явцад жендерийн ялгаатай байдлыг арилгах гол хэрэгсэл болдог. Жендерийн статистик нь

17 Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт жендэрийн талаар баримтлах бодлого. 5 дахь тал. 2018 он.

жендерийн тулгамдсан асуудлуудыг илүү тодорхой ойлгох, тэдгээрт нөлөөлж буй хүчин зүйлсийг тооцох, улмаар жендерийн тэгш байдалд нөлөөлж буй нийгэм, эдийн засаг, улс төрийн хүчин зүйлсийн хоорондын уялдаа холбоо, үр дагаврыг тогтоох арга хэрэгсэл юм. Жендерийн статистик тоо баримтыг гаргах зорилго нь үйлдвэрлэгчид болон хэрэглэгчдийн ажил үүргийн уялдаа, хэрэглээний ур чадвар, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд чиглэсэн байх ёстой. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай Монгол улсын хуульд хүйсээр ангилсан албан ёсны статистикийн болон бусад мэдээллийн ил тод, нээлттэй, хүртээмжтэй байдлыг ханган жендерийн мэдээлэл хүртээмжтэй байх зарчмыг хэрэгжүүлэхээр заасан байна¹⁸.

Иймд ХЭХЗХ-ны жендерийн статистикийг хорооны ажлын алба дараах байдлаар гаргаж, ГБХЗХГ-т улирал тутам илгээж байвал зохино. Үүнд:

ХЭХЗХ-ноос гаргах жендерийн статистик

Гэмт хэргийн сэжигтэн 18 хүртэл насны хүүхэд

Он	Нийт хэрэгт эзлэх хувь	Хүүхэд оролцсон гэмт хэргийн тоо	Хүүхдийн тоо	Үүнээс	
				эмэгтэй	эрэгтэй
2017	5,9%	948	1066	96	970
2018	5,8%	741	956	90	866
2019	3,4 %	1068	1356	170	1186
2020	3,5 %	811	990	105	885

Гэмт хэргийн хохирогч хүүхэд

Он	Нийт хэрэгт эзлэх хувь	Хүүхдийн тоо	Үүнээс	
			эмэгтэй	эрэгтэй
2017	4.7%	1757	694	1063
2018	5%	1688	780	908
2019	5.2%	1598	730	868
2020	5,1%	1181	578	603

Гэмт хэргийн гэрч 18 хүртэл насны хүүхэд

Он	Нийт хэрэгт эзлэх хувь	Хүүхэд оролцсон гэмт хэргийн тоо	Хүүхдийн тоо	Үүнээс	
				эмэгтэй	эрэгтэй
2018					
2019					
2020					

18 Жендерийн нэр томъёо тодохойлолт, үндсэн ойлголтуудын тайлбар толь. 31 дэх тал. УБ, 2013 он

Шүүхээр ял шийтгүүлсэн 18 хүртэл насны хүүхэд

Он	Хүүхдийн тоо	Үүнээс	
		Эмэгтэй	эрэгтэй
2018	295	-	-
2019	360	-	-
2020	228	-	-

Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан 18 хүртэл насны хүүхэд

Он	Хүүхдийн тоо	Үүнээс	
		Эмэгтэй	эрэгтэй
2018		-	-
2019		-	-
2020		-	-

Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагаас суллагдсан 18 хүртэл насны хүүхэд

Он	Хүүхдийн тоо	Үүнээс	
		Эмэгтэй	эрэгтэй
2018		-	-
2019		-	-
2020		-	-

**1.5. ХУУЛЬ ЗҮЙН ХОРОО ТӨРИЙН БА ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУДЫН ХАМТЫН
АЖИЛЛАГААГ САЙЖРУУЛАХ АРГА ЗАМ**

Хорооны Ажлын алба хорооны бүрэлдэхүүнд байгаа төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтын ажиллагааны санамж бичиг, хамтарсан журам, төлөвлөгөө батлан хэрэгжүүлэх нь үр дүнтэй ажлын хэлбэр болж байна.

Энэ талаар хийж, хэвшиж байгаа сайн туршлагын арга хэлбэрүүд байна. Тухайлбал, Архангай аймагт ХЭХЗХ нь яаралтай хуралдан гэмт хэргийн сэжигтэн хүүхдийг өмгөөлөгчид “баг” болж өмгөөлөн ажилласан нь үр дүнд хүрчээ. Говьсүмбэр аймгийн Хууль зүйн хороо(ГБХЗХХ) гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдож, шүүхээс хорихоос өөр төрлийн ялаар шийтгүүлсэн хүүхдэд хувийн хэрэг нээж, ЦГ, ЭМГ, БСУГ-тай хамтран ажиллаж, зан байдал засрал хүмүүжилд нөлөөлөх сургалтыг зохион байгуулсан байна. Булган ХЭХЗХ (ЦГ) оролцогч бүх талуудтай хамтран ажиллахаар санамж бичиг байгуулж, ажлын өдөр бүр 9.00 цагт хэрэгт холбоотой хүүхдийн талаарх мэдээллийг харилцан солилцдог болсон байна.


Хөвсгөл аймгийн ХЭХЗХ (ЦГ) бага насны хүүхдийн эсрэг үйлдэгдсэн бэлгийн хүчирхийллийн шалтгааныг тогтооход хууль зүйн хорооноос үзүүлсэн үйлчилгээний хүрээнд чухал мэдээ, нотлох баримтыг илрүүлсэн нь хууль сахиулагчдад үнэлэгдсэн байна. Ховд аймгийн ХЭХЗХ 2015 оны Эрүүгийн хууль өсвөр насныханд хатуудсан хорих ялыг өөрчлүүлэх нөлөөллийн ажлыг ТББ-тай хамтран амжилттай өрнүүлж, хуулийн зохих заалтыг яаралтай өөрчлүүлж чадсан байна. Мөн гэр бүлийн хүчирхийллийн олон хохирогчтой хэрэгт хохирогч бүрийн

эрхийг хамгаалж үр дүнтэй ажилласан туршлага байна. БЗД-ийн ХЭХЗХ Прокурорын байгууллагатай хамтран ХЧААХ-тэй хүүхдүүдийг зохион бичлэгийн уралдаанд оролцуулсан нь амжилттай болсон байна. Мөн Завхан аймгийн ХЭХЗХ журамд заасан бүрэлдэхүүнээс гадна хорооны үйл ажиллагаанд туслах хамтран ажиллах “мэргэжилтний баг” байгуулан ажилласан нь илүү шуурхай үр нөлөөтэй ажиллах нөхцөл бүрдүүлсэн байна. Түүнчлэн хохирогч хүүхдийн хөрөнгийг битүүмжлүүлсэн асуудлыг анх удаа нэхэмжлэл үүсгэн прокурорт хандаж, хохирогчийн сэтгэл зүйн хохирлыг тооцуулж тогтоолгоход хорооны гишүүд хамтран ажилласан байна¹⁹.

Төр, иргэний нийгмийн байгууллагуудын түншлэл, хамтын ажиллагаанд жендэрийн бодлогыг хэрэгжүүлэхийн тулд жендэрийн тэгш байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх олон талт сонирхогч талуудын түншлэлийг хөгжүүлж, чадавхжуулах, жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүчирхийллийн хохирогчид үзүүлэх нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, ялгаварлан гадуурхах бүх хэлбэртэй тэмцэх үндэсний болон олон улсын гэрээ, эрх зүйн актуудыг практикт хэрэгжүүлэх нэгдмэл орчныг үндэсний хэмжээнд бүрдүүлэх нь чухал байна.

19 ХЭХЗХ-ны үйл ажиллагааны хэрэгжилтэд хийсэн үнэлгээний тайлан. ХЭССХ, 2021 он.

хүүхдийн эрх ба хүүхдийн эрхийг хангахад төр, иргэн хуулийн этгээдийн оролцооны зураглал



Гэмт хэргийн гэрч, хохирогч болсон, хууль зөрчсөн хэмээн шалгагдаж байгаа болон шүүхээр яллагдаж байгаа, хорихоос суллагдан нийгмийн амьдралд эргэн орж байгаа хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр НҮБ-аас гаргасан олон улсын гэрээ, “стандарт баримт бичгүүд”²⁰-ийг сайтар судлах нь хүүхдийн төлөө үүрэг хүлээгч хүн бүрт тэр тусмаа Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны гишүүдийн хууль, эрх зүйн мэдлэг, ойлголт, хандлагад хамгаас чухал юм.

2.1. МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

2.1.1. НҮБ-ЫН ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ КОНВЕНЦ²¹-ООС:

Тус конвенц 1989 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр батлагдаж, 1990 оны 9 дүгээр сарын 2-ны өдөр хүчин төгөлдөр болсон. Монгол Улс 1990 оны 7 дугаар сарын 5-ны өдөр нэгдэн орсон. Хүүхдийн эрхийн тухай конвенц нь чухал байр суурь эзлэх бөгөөд хүний эрхийн салбар дах тулгуур гэрээний нэг болдог. Уг конвенц нь хүний эрхийн наад захын стандартыг агуулахаас гадна “хүүхдийн бие бялдар, оюун ухаан гүйцэд төлөвшөөгүйн улмаас түүнийг төрөхөөс өмнө болон төрсний дараа онцгой халамж, хамгаалалт, түүний дотор эрх зүйн зохих хамгаалалт шаардлагатайг” анхааралдаа авахыг чухалчилдаг.

Конвенц нь өндөр ач холбогдолтой үндсэн хоёр үзэл баримтлалыг дэвшүүлжээ:

1. “Хүүхдийн талаар явуулах аливаа үйл ажиллагаанд” заавал мөрдөх зүйл нь юуны өмнө “хүүхдийн дээд ашиг сонирхлыг хангах” зарчим юм (3 дугаар зүйл). Энэ зарчим нь шүүхийн, захиргааны, хууль тогтоох байгууллага болон төрийн, төрийн бус байгууллагын шийдвэр, үйл ажиллагаанд шууд хамааралтай. Энэ зарчмын хэрэгжилт нь конвенцын гол чухал зорилго юм.
2. Хөгжиж буй хүүхдийн чадавхад нийцүүлэн энэхүү Конвенцод заасан эрхээ хэрэгжүүлэхэд удирдан чиглүүлэх эцэг эх (хүүхдийн өмнөөс хуулийн дагуу хариуцлага хүлээх бусад этгээд)-ийн эрх, үүргийг хүндэтгэх (5 дугаар зүйл) үүргийг гишүүн улс болон хүлээн зөвшөөрч, хангах үүрэгтэй.

Хүүхэд бол эрх зүйн субъект бөгөөд хүний бүхий л эрх (иргэний, соёл, эдийн засаг, улс төр, нийгмийн эрх) хүний амьдрах, амьд явах, хөгжих, хамгаалагдах бүхий л явдалд шаардагдах эрх нь хуваагдашгүй бөгөөд хоорондоо нягт холбоотой байдаг.

Конвенцын 1 дүгээр зүйлд хүүхдийг тодорхойлохдоо хүүхдэд үйлчилж буй хуулиар тодорхой тохиолдолд насанд хүрсэнд тооцох тохиолдлоос бусад “18 нас хүрээгүй хүн бүрийг хүүхэд” гэжээ.

20 Олон улсын стандарт, дүрэм, журам, зарчмын талаар <http://www.fcy.gov.mn/сайтаас> үзнэ үү.

21 Конвенцийн эхийг <https://www.legalinfo.mn/law>. Хуулийн нэгдсэн портал сайтаас үз.

Конвенцын онцлог зохицуулалтын нэг бол хүүхэд бүр төрмөгцөө бүртгүүлэх, төрсөн цагаасаа нэр авах, иргэний харьяалалтай болох, түүнчлэн эцэг эхээ боломжийн хэрээр мэдэх, хайр халамжийг нь хүртэх эрхийг хүлээн зөвшөөрсөн явдал мөн. Харин гишүүн улсын зүгээс дээрх хүүхдийн эрхийг хүндэтгэх, үүнд хууль бусаар оролцохгүй байх үүрэг хүлээнэ.

Нэг ч хүүхдийн хувийн болон гэр бүлийн амьдрал, орон байрны халдашгүй байдал болон захидал харилцааны нууцад хөндлөнгөөс, хууль бусаар буюу дур мэдэн оролцох, эсхүл түүний нэр төр, алдар хүндэд хууль бусаар халдаж болохгүй.

Хэн ч хүүхдэд эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар, нэр төрийг нь доромжлон харьцах буюу шийтгэхгүй байх, 18 насанд хүрээгүй хүүхдийн үйлдсэн гэмт хэрэгт цаазаар авах буюу суллах боломжгүйгээр бүх насаар нь хорих ял ногдуулах ёсгүй.

Тус Конвенцын 32-36 дугаар зүйл нь хүүхдийг хүнд тэвчишгүй хөдөлмөр, хориглосон ажил үйлчилгээ эрхлүүлж эрхийг нь зөрчихгүй байх, хэрэв зөрчсөн тохиолдолд шаардлагатай арга хэмжээг нэн даруй авах талаар заасан байдаг.

Манай улсад хүүхдийг уул уурхайн албан бус секторт хөдөлмөрлүүлэх, биеийг нь үнэлүүлж эдийн засгийн болон бэлгийн мөлжлөгт өртүүлэх, насанд хүрээгүй хүүхдийг ажиллуулахыг хориглосон ажлын байран дээр ажиллуулах, хориглосон хугацаанд хурдан морины уралдаанд болон бооцоотой, бай шагнал өндөртэй тоглоом наадам, тэмцээнд оролцуулах, үүнээс үүдэн хүүхэд гэмт хэрэг, зөрчлийн хохирогч болох явдал түгээмэл байгаад Хороо анхаарч, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга хэмжээг холбогдох байгууллага, иргэдтэй хамтран хийх шаардлагатай байна.

Мөн конвенцын 37-40 дүгээр зүйл нь Эрүүгийн хууль зөрчсөн хэмээн сэжиглэгдэн шалгагдаж байгаа, ялагдан шүүгдэж байгаа, гэм буруутай нь тогтоогдсон хүүхдийн нэр төр, үнэ цэнэ, хүний эрх, бусдын үндсэн эрх чөлөөг хүндэтгэх үзлийг бататгах, нийгмийн амьдралд буцаан оруулах шаардлага, насны онцлогийг харгалзан, нийгэмд бүтээлч үүрэг гүйцэтгэх эрхийг хүндэтгэн хандах талаар хуульчлан заасан байдаг.

2.1.2. ХҮНИЙ ЭРХИЙН ТҮГЭЭМЭЛ ТУНХАГЛАЛ-ААС:

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 217/A/III/ тогтоолоор 1945 оны 6 дугаар сарын 26-ны өдөр баталж, 1945 оны 10 дугаар сарын 24-ний өдөр хүчин төгөлдөр болсон. Монгол Улс 1961 оны 10 дугаар сарын 27-ны өдөр нэгдэн орсон.

Тус тунхаглалын 1-11 дүгээр зүйлийг <https://www.legalinfo.mn/law>. Хуулийн нэгдсэн портал сайтаас үз.

2.1.3. ИРГЭНИЙ БОЛОН УЛС ТӨРИЙН ЭРХИЙН ТУХАЙ ОЛОН УЛСЫН ПАКТ-ААС:

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт нь 1966 оны 12 дугаар сарын 16-ны өдөр батлагдсан. 1976 оны 1 дүгээр сарын 3-ны өдөр хүчин төгөлдөр болсон. Монгол Улс 1974 оны 11 дүгээр 18-ны өдөр нэгдэн орсон.

Пактын 6-10, 14, 16-17, 23-24, 26-27 дугаар зүйлийг <https://www.legalinfo.mn/law>. Хуулийн нэгдсэн портал сайтаас үз.

2.1.4. ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ, СОЁЛЫН ЭРХИЙН ТУХАЙ ОЛОН УЛСЫН ПАКТ-ААС:

Энэхүү пакт нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 2200А (XXI) дугаар тогтоолоор баталж, 1976 оны 3 дугаар сарын 23-ны өдөр хүчин төгөлдөр болсон. Монгол Улс 1974 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр нэгдэн орсон. Гэр бүл болон эдийн засаг, нийгмийн бүхий л салбарт хүн бүрийн ялангуяа хүүхдийн эдлэх ёстой эрх, эрх чөлөөг тунхаглаж, түүнийг хуулиар хамгаалан бэхжүүлэхийн чухлыг онцолсон байдаг. Тухайн Пактын 10, 12-13 дугаар зүйлийг <https://www.legalinfo.mn/law>. Хуулийн нэгдсэн портал сайтаас үз.

2.1.6. ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨРИЙН ТЭВЧИШГҮЙ ХЭЛБЭРҮҮДИЙГ ХОРИГЛОХ, НЭН ДАРУЙ УСТГАХ ТУХАЙ ОЛОН УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН 182 ДУГААР КОНВЕНЦ-ООС:

18 нас хүрээгүй бүх хүүхдийн хувьд хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг хориглох тухай олон улсын хэлэлцээр. 1999 оны 6 дугаар сарын 17-ны өдөр баталж, Монгол Улс 2000 оны 10 дугаар сарын 5-ны өдөр соёрхон баталсан.

Уг конвенцыг үз. /<https://www.legalinfo.mn/law>. Хуулийн нэгдсэн портал сайт/.

2.1.7. ХҮҮХДИЙГ ХУДАЛДАХ, ХҮҮХДИЙН БИЕИЙГ ҮНЭЛЭХ, ХҮҮХДИЙГ САДАР САМУУНД СУРТАЛЧЛАХЫН ЭСРЭГ ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ КОНВЕНЦОД ОРУУЛАХ НЭМЭЛТ ПРОТОКОЛ -ООС:

Тус протоколыг 2000 оны 5 дугаар сарын 25-ны өдөр Ерөнхий Ассамблейн 2000 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн A/RES/54/263 тогтоолоор баталсан. Монгол Улс 2003 оны 5 дугаар сарын 15-ны өдөр соёрхон баталсан.

Уг конвенцын 1, 8, 9 дүгээр зүйлийг үз. <https://www.legalinfo.mn/law>. Хуулийн нэгдсэн портал сайт/.

2.1.8. ЭРҮҮДЭН ШҮҮХ БОЛОН БУСАД ХЭЛБЭРЭЭР ХЭРЦГИЙ, ХҮНЛЭГ БУСААР БУЮУ ХҮНИЙ НЭР ТӨРИЙГ ДОРОМЖЛОН ХАРЬЦАЖ ШИЙТГЭХИЙН ЭСРЭГ КОНВЕНЦ -ООС:

Энэхүү конвенцыг 1984 оны 12 дугаар сарын 10-ны өдөр Нью-Йорк хотноо баталж, 1987 оны 6 дугаар сарын 26-ны өдөр хүчин төгөлдөр болсон. Монгол Улс 2000 оны 11 дүгээр сарын 2-нд нэгдэж орсон.

Уг конвенцын 2, 4, 10-14 дүгээр зүйлийг үз. <https://www.legalinfo.mn/law>. Хуулийн нэгдсэн портал сайт/.

2.1.9. ОЛОН УЛСЫН ЭРҮҮГИЙН ШҮҮХИЙН РОМЫН ДҮРЭМ-ЭЭС:

Энэхүү дүрмийг 1998 оны 7 дугаар сарын 18-ны өдөр баталж, 2002 оны 7 дугаар сарын 1-ний өдөр хүчин төгөлдөр болсон. Монгол Улс 2002 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр соёрхон баталж, нэгдэн орсон.

Уг дүрмийн 26, 67-68, 75 дугаар зүйлийг үз. <https://www.legalinfo.mn/law>. Хуулийн нэгдсэн портал сайт/.

**2.1.10. ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ КОНВЕНЦЫН “МЭДЭЭЛЭЛ ХҮРГҮҮЛЭХ ЖУРМЫН ТУХАЙ”
НЭМЭЛТ ПРОТОКОЛ:**

Энэхүү протокол нь 2014 онд батлагдсан бөгөөд Монгол Улс 2015 оны 4 сарын 16-ны өдөр соёрхон баталсан.

Уг протоколын 5 дугаар зүйлд “Мэдээллийг /гомдлыг/ тухайн улс нэгдэн орсон хүүхдийн эрхийн тухай конвенц болон түүний нэмэлт протоколуудад заасан аливаа эрхийг тухайн оролцогч улс зөрчсөний улмаас хохирогч болсон гэж үзэж тухайн оролцогч улсын хуулийн харьяалалд хамаарах хувь хүн буюу хэсэг хүн өөрөө, эсхүл тэднийг төлөөлж хүргүүлж болно” гэж заасан. Мэдээллийг дотоодын эрх зүйн бүх хамгаалалтыг хэрэглэж дууссан үед хүргүүлж болдог. Мэдээлэлд хүргүүлэгчийн нэр, хаяг тодорхой тусгагдсан байх ёстой. Түүнчлэн хангалттай нотолгоо бүхий бичгээр үйлдсэн байхыг шаарддаг.

Нэмэлт протоколын эхийг <https://www.legalinfo.mn/law>. Хуулийн нэгдсэн портал сайтаас үз.

2.1.11. ЭМЭГТЭЙЧҮҮДИЙГ АЛАГЧИЛАХ БҮХ ХЭЛБЭРИЙГ УСТГАХ ТУХАЙ КОНВЕНЦ-ООС:

Ерөнхий Ассамблейн 34/180 тоот тогтоолоор 1979 оны 12 дугаар сарын 18-ны өдөр баталж, 1981 оны 9 дүгээр сарын 3-ны өдөр хүчин төгөлдөр болсон. Монгол Улс 1980.07.10-нд гарын үсэг зурж, 1981.05.14-нд соёрхон батласан.

Энэхүү Конвенцын 1, 5-6, 9, 11-12, 16 дугаар зүйлийг <https://www.legalinfo.mn/law>. Хуулийн нэгдсэн портал сайтаас үз.

**2.1.12. ХҮҮХДИЙГ ХАМГААЛАХ БОЛОН УЛС ХООРОНД ҮРЧЛЭХ АСУУДЛААР ХАМТРАН АЖИЛЛАХ
ТУХАЙ КОНВЕНЦ –ООС:**

1993 оны 5 дугаар сарын 29-ний өдөр баталж, 1995 оны 5 дугаар сарын 1-нд хүчин төгөлдөр болсон. Монгол улс 1998.01.16-нд нэгдэн орсон.

Хүүхдийг өв тэгш хөгжүүлэх үүднээс тэднийг гэр бүлийн болон баяр баясгалан, хайр, ойлголцлын орчинд өсгөн хүмүүжүүлэхийг хүлээн зөвшөөрч, улс бүр хүүхдийг төрсөн гэр бүлийн халамжид байлгах зохистой арга хэмжээ тэргүүн ээлжид авч хэрэгжүүлэхийг уриалж, төрөлх улсад үрчлэн авах тохиромжтой гэр бүл олдохгүй тохиолдолд хүүхдийг улс хооронд үрчлэх нь байнгын гэр бүлийн харгалзан үзсэнээр үрчлүүлж буй хүүхдэд тааламжтай байдал олгохыг хүлээн зөвшөөрч, улс хооронд хүүхэд үрчлэхэд хүүхдийн дээд ашиг сонирхолд нийцүүлэн, үндсэн эрхийг нь хүндэтгэж, хүүхэд худалдах, хулгайлах, хил дамнан худалдахаас сэргийлэх арга хэмжээ авах шаардлагатайг ухамсарлаж, хэлэлцэн тохиролцсон. <https://www.legalinfo.mn/law>. Хуулийн нэгдсэн портал сайт/.

2.2. МОНГОЛ УЛСЫН ЗАРИМ ХУУЛЬ, ТОГТООМЖ**2.2.1. ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ²² ХУУЛИАС:/2016/**

Энэ хууль 2016 оны 2 дугаар сарын 05-ны өдөр батлагдаж, 2016 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөн.

²² Хуулийн эхийг <https://www.legalinfo.mn/law>. Хуулийн нэгдсэн портал сайтаас үз.

Энэ хуулийн зорилт нь хүүхдийн эрхийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн бүрэн эрхийг тодорхойлж, хүүхдийн эрхийг хангах тогтолцоог бий болгох, хүүхдийн эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Энэхүү хууль нь хүүхдийг төрсөн цагаас нь эхлэн 18 насанд хүртэл эрхийг нь хангахад үйлчлэх бөгөөд Монгол Улсад оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүний хүүхдэд нэгэн адил хамаарна.

2.2.2. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТУХАЙ²³ ХУУЛИАС:/2016/

Энэ хууль 2016 оны 2 дугаар сарын 05-ны өдөр батлагдаж, 2016 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөн.

Энэ хуулийн зорилт нь хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоо, оролцогч талуудын харилцааг тодорхойлж, хүүхдийг үл хайхрах байдал, дарамт, мөлжлөг, хүчирхийллийн бүх хэлбэр, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, хариу үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Энхүү хууль нь Монгол Улсын олон улсын гэрээнд заасан тохиолдолд Монгол Улсын хилийн гадна байгаа хүүхэд, түүний асран хамгаалагч, харгалзан дэмжигчид нэгэн адил үйлчилнэ. Монгол Улсын иргэн төрсөн цагаас эхлэн 18 нас хүртэл, эсхүл Монгол Улсын олон улсын гэрээнд заасан тохиолдолд 18 наснаас дээш 21 хүртэл насны хүнд энэ хуульд заасан тусламж, үйлчилгээг үзүүлж болно.

Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

4.1. Энэ хуульд заасан дараахь нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

- 4.1.3. “хүүхдийн эрхийн хууль зүйн хороо” гэж гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэж сэжиглэгдэж, мөрдөн шалгагдаж байгаа, эсхүл гэмт хэргийн гэрч, хохирогч болсон, гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан, зөрчил үйлдэж шийтгэгдсэн хүүхдэд үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллагын төлөөлөл бүхий орон нутгийн нэгжийг;
- 4.1.4. “хууль зөрчсөн хүүхэд” гэж гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэж сэжиглэгдэн, мөрдөн шалгагдаж байгаа, эсхүл зөрчил үйлдэж шийтгэгдсэн, гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлж, албадлагын арга хэмжээ авагдсан, сургалт хүмүүжлийн тусгай байгууллагаас суллагдсан хүүхдийг;
- 4.1.6. “хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ” гэж эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, нөхцөл байдлын үнэлгээ хийх, аюулгүй байдлыг хангах, дэмжих, холбон зуучлах, нийгмийн харилцаанд дасган зохицуулах, гэр бүлд нь эргэн нэгтгэх үе шат бүхий үйл ажиллагааг;
- 4.1.7. “хүүхдийн эрхийн ажилтан” гэж хүүхдийн эрхийн улсын байцаагчийн эрх бүхий ажилтан, албан тушаалтныг;

- 4.1.8. “хүүхдийн эсрэг хүчирхийлэл” гэж санаатай эсхүл санамсаргүйгээр хүүхдийн амь нас, эрүүл мэнд, хөгжил, бие махбод, сэтгэл санаанд хор хохирол учруулах үл хайхрах байдал, бэлгийн зүй бус үйлдэл болон бие махбодийн шийтгэл, сэтгэл санааны дарамтыг.

2.2.3. ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ²⁴ ХУУЛИАС:

Энэ хууль 2011 оны 2 дугаар сарын 02-ны өдөр батлагдаж, мөн өдрөөс эхлэн дагаж мөрдсөн.

Энэ хуулийн зорилт нь улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд жендэрийн эрх тэгш байдлыг хангах нөхцөл бүрдүүлэх эрх зүйн үндсийг тодорхойлж, хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

- 4.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

- 4.1.1. “жендэр” гэж улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага, тэдний нийгэмд эзлэх байр суурийн талаар уламжлагдан тогтсон, түүхэн явцад хувьсан өөрчлөгддөг ойлголт, үзэл, хандлагыг;
- 4.1.2. “жендэрийн эрх тэгш байдал” гэж эрэгтэй, эмэгтэй хүн улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд тэгш эрхтэй оролцож, эдийн засаг, нийгэм, соёлын хөгжлийн үр шимээс тэгш хүртэж, хөгжилд эрх тэгш хувь нэмрээ оруулснаар жендэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байхыг;
- 4.1.3. “жендэрийн хэвшмэл үзэл” гэж улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, эдлэх эрхийн талаар хүйсийн шинжээр уламжлагдан тогтсон ялгаатай ойлголт, хандлагыг;
- 4.1.4. “жендэрийн ялгаварлан гадуурхалт” гэж улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд болон аливаа бусад салбарт эрэгтэй, эмэгтэй хүнийг хүйсийн шинж, гэрлэлтийн байдлаар ялгаварлах, үгүйсгэх, хязгаарлах үйлдэл, эс үйлдэхүйг;
- 4.1.5. “жендэрийн шууд ялгаварлан гадуурхалт” гэж бусдыг хүйсээр ялгаварлаж адил буюу ижил төстэй нөхцөлд эсрэг хүйсийн хүнээс ялгаатай байдалд хүргэсэн, эсхүл хүргэхийг оролдсон үйлдлийг;
- 4.1.6. “жендэрийн шууд бус ялгаварлан гадуурхалт” гэж хүйсэд хамааралгүй аливаа стандарт, хэм хэмжээ, үйлдэл нь хүнийг эсрэг хүйсийн хүнээс ялгаатай байдалд хүргэхийг;
- 4.1.7. “бэлгийн дарамт” гэж бусдыг хүсээгүй байхад нь бэлгийн сэдлээ үг хэлээр, биеэр буюу өөр хэлбэрээр илэрхийлсэн, эсхүл хурьцал үйлдэхээс аргагүй байдалд оруулсан, мөн бэлгийн сэдлийн улмаас ажил, албан тушаал, эд материал, сэтгэл санааны болон бусад байдлаар хохироох үр дагавар бүхий

тэвчишгүй орчин үүсгэх, айлган сүрдүүлэх, тулган шаардах зэрэг үйлдэл, эс үйлдэхүйг;

- 4.1.8. “жендэрт суурилсан хүчирхийлэл” гэж жендэрээс үүдэлтэйгээр бусдад бие махбодийн, бэлгийн, сэтгэл санааны гэм хор, эдийн хохирол учруулсан, учруулж болзошгүй үйлдэл, эс үйлдэхүйг;

2.2.4. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ²⁵ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/

Энэ хууль 2016 оны 12 дугаар сарын 22-ны өдөр батлагдаж, 2017 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөн.

Энэ хуулийн зорилт нь гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох, хохирогч, түүний гэр бүлийн бусад гишүүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, үйлчилгээ үзүүлэх, урьдчилан сэргийлэх тогтолцоо, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтооход оршино.

Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

- 5.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

- 5.1.1. “гэр бүлийн хүчирхийлэл” гэж энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан этгээд энэ хуулийн үйлчлэлд хамаарах хүний сэтгэл санаанд дарамт учруулах, эдийн засаг, бэлгийн эрх чөлөө, бие махбодод халдсан үйлдэл, эс үйлдэхүйг;
- 5.1.2. “гэр бүлийн хүчирхийллийн хохирогч” /цаашид “хохирогч” гэх/ гэж гэр бүлийн хүчирхийллийн улмаас сэтгэл санаа, эдийн засаг, бие махбод, бэлгийн халдашгүй байдлаараа хохирсон хүнийг;
- 5.1.3. “нэг цэгийн үйлчилгээ” гэж хохирогчийг эмнэлэг, төрийн, төрийн бус байгууллагад түр байрлуулан эмнэлгийн тусламж болон энэ хуульд заасан бусад үйлчилгээг нэг доор үзүүлэх ажиллагааг;
- 5.1.4. “гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хамтарсан баг” /цаашид “хамтарсан баг” гэх/ гэж хохирогч, түүний гэр бүлийн гишүүнд энэ хуулийн 37, 38.1.1, 40, 41, 42 дугаар зүйлд заасан үйлчилгээг хамтран үзүүлэх сум, хорооны Засаг даргаар ахлуулсан зохион байгуулалтын хэлбэрийг;
- 5.1.5. “түр хамгаалах байр” гэж хохирогчийг тодорхой хугацаагаар байрлуулан энэ хуульд заасан үйлчилгээ үзүүлэх зориулалт бүхий стандарт хангасан газрыг;
- 5.1.6. “хамтран амьдрагч” гэж гэрлэлтээ бүртгүүлээгүй ч харилцан тохиролцсоны үндсэн дээр гэр бүлийн харилцаа үүсгэн хамтран амьдарч байгаа этгээдийг;
- 5.1.7. “холбон зуучлах үйлчилгээ” гэж гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирогч, түүний гэр бүлийн гишүүнд учирсан сөрөг үр дагаврыг арилгах, хэвийн байдалд нь оруулах, нөхөн сэргээхэд туслах зорилгоор холбогдох төрийн, төрийн бус байгууллагад зуучилж, хамтран үйлчилгээ үзүүлэхийг;

5.1.8. “хүчирхийллийн болзошгүй эрсдэл” гэж гэр бүлийн хүчирхийлэлд хүргэж болзошгүй, эсхүл хүчирхийлэл дахин үйлдэгдэх нөхцөл байдлыг.

2.2.5. МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ²⁶

2008 оны 2 дугаар сарын 28-ны өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ БОЛОН ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН НИЙТЭЭР ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРСӨН ХЭМ ХЭМЖЭЭ, ЗАРЧМЫГ ШҮҮХИЙН ПРАКТИКТ ХЭРЭГЛЭХ ТУХАЙ

Монгол Улсын Үндсэн хуулийн аравдугаар зүйлд зааснаар олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчим болон Монгол Улсын олон улсын гэрээ нь тус улсын эрх зүйн тогтолцооны нэг хэсэг бөгөөд Монгол Улс нь олон улсын эрх зүйн үндсэн зарчмуудын нэг болох “гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлэх” зарчмыг баримтлах талаар Үндсэн хуулийн мөн зүйлийн 2 дахь хэсэгт тунхаглажээ. Олон улсын гэрээ нь олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх гол хэрэгсэл болж, төрийн болон төрийн бус байгууллагын, тэдгээрийн дотор үндэсний эрх зүйн харилцааны субъектүүдийн оролцоотой олон улсын харилцааг өргөжүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах салбарт анхдагч үүрэг гүйцэтгэдэг билээ. Ийм учраас олон улсын гэрээний заалтыг дотоодод хэрэгжүүлэхтэй холбоотой шүүхийн үйл ажиллагааг боловсронгуй болгох, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд олон улсын эрх зүйн хэм хэмжээ, зарчмыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Дээд Шүүхээс энэхүү тогтоолыг гаргажээ.

26 Тогтоолын эхийг <https://www.legalinfo.mn/law>. Хуулийн нэгдсэн портал сайтаас үз.

3.1. ГЭРЧ, ХОХИРОГЧ ХҮҮХДИЙН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХАД ШААРДЛАГАТАЙ ХУУЛЬ, ТОГТООМЖ

Гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг хохирогч²⁷, харин эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нөхцөл байдлыг мэдэж байгаа хүнийг гэрч гэнэ²⁸.

Аливаа гэмт хэргийн гэрч, хохирогч хэн ч бай нэн түрүүнд эрх зүйн туслалцаа авах шаардлагатай болдог. Эрх зүйн туслалцаанд эрх зүйн зөвлөгөө, өмгөөллийн үйлчилгээ хамаардаг.

Эрх зүйн зөвлөгөө: Эрх зүйн зөвлөгөөг биеэр уулзаж өгөхөөс гадна утсаар болон цахим хэлбэрээр үзүүлж болно. Эрх зүйн зөвлөгөөний зорилго нь үйлчлүүлэгч өөрийн эрх, нөхцөл байдлаа ойлгож мэдэх, тодруулах, асуудлаа хуулийн хүрээнд зохицуулахад туслах явдал юм. Иймд үйлчлүүлэгчийн мэдэж байвал зохих, тэдний эрх ашгийг хамгаалахад чиглэсэн зарим хуулиадаас эш татсаныг практик зөвлөгөө, хариу арга хэмжээнд хэрэглэж болох байна. Үүнд:

Гэмт хэргийн гэрч, хохирогч болсон бол Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн²⁹ 2-25 дугаар зүйл, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн³⁰ шинэчилсэн найруулга/ 3.2 дугаар зүйлийн 2, 8.1-8.5 дугаар зүйл, 9.5-9.6 дугаар зүйл, 11.4, 12.1, 12.3, 13.1, 13.2, 15.1, 15.2, 25.2-25.3, 25.7, 35.15, 35.18 дугаар зүйл, гэр бүлийн хүчирхийллийн гэрч, хохирогч болсон бол Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн³¹ 1, 3-4 дүгээр зүйл, 6, 8, 28 дугаар зүйл, Нийгмийн халамжийн тухай хуулийн³² 13, 18-19, 20-22 дугаар зүйл, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн³³ 10 дугаар зүйл, Бага, дунд боловсролын тухай хуулийн³⁴ 20 дугаар зүйл, Боловсролын тухай хуулийн³⁵ 5-6, 17-18, 28 дугаар зүйлд заасныг мөрдөн ажиллавал зохино. Мөн Засгийн газрын 2015 оны 346 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр”³⁶-т үйл ажиллагааны чиглэлийг тодорхой заасан байна.

Хүүхдийн эрхийн конвенцод зааснаар мэдүүлэг өгөх, гэм буруугаа хүлээхийг албадахгүй байх, эсрэг мэдүүлэг өгөх гэрчийг эрх тэгш нөхцөлд байцаах тухай заажээ. Гэвч ЭХХШТХ-ийн 8.2 дугаар зүйлийн 4-т, 9.6 дугаар зүйлийн 4-т хохирогч болон гэрч “эрүүгийн хэрэг хянан

27 ЭХХШТХ-ийн 8.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг

28 Мөн хуулийн 9.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.

29 хуулийн эхийг <https://www.legalinfo.mn/law>. Хуулийн нэгдсэн портал сайтаас үз.

30 Мөн сайтаас үз.

31 хуулийн эхийг <https://www.legalinfo.mn/law>. Хуулийн нэгдсэн портал сайтаас үз.

32 хуулийн эхийг <https://www.legalinfo.mn/law>. Хуулийн нэгдсэн портал сайтаас үз.

33 Мөн сайтаас үз.

34 Мөн сайтаас үз.

35 Мөн сайтаас үз.

36 Хөтөлбөрийн эхийг <https://www.legalinfo.mn/law>. Хуулийн нэгдсэн портал сайтаас үз.

шийдвэрлэх ажиллагаанд саад учруулсан, эсхүл худал мэдүүлэг өгсөн бол түүнд Зөрчлийн тухай хууль, эсхүл Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ” гэж тус тус заасан мөн 25.1 дүгээр зүйлийн 6-д “Мөрдөгч мэдүүлэг өгөх гэж байгаа хүнд өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхтэйг нь тайлбарлах ба санаатай худал мэдүүлэг өгвөл Эрүүгийн хуульд заасан эрүүгийн хариуцлага хүлээлгэх тухай сануулна” хэмээн хууль сануулж байгаа нь хүүхдэд нэгэн адил хамаарахаар хуульчлагдсан нь Хүүхдийн эрхийн конвенцын 40 дүгээр зүйлийн тодорхой заалтуудыг зөрчсөн байна³⁷ гэснийг анхаарч ажиллах шаардлагатай.

Гэмт хэргийн гэрч, хохирогч хүүхдэд халамжийн, боловсролын болон эрүүл мэндийн байгууллагууд хуульд заасан үйлчилгээ үзүүлж, эрхийг нь хангах үүрэг хүлээсэн байдаг. Иймд гэмт хэргийн болон гэр бүлийн хүчирхийллийн хохирогч болсон хүүхэд халамжийн үйлчилгээ авах, түүнд хамрагдах эрхтэй. Энэхүү эрхийг орон нутгийн халамжийн байгууллага хууль, журмын дагуу хангах үүрэгтэй.

Сургуулийн захирал нь гэмт хэргийн хохирогч хүүхдийн сурах, хөгжих, аюулгүй байдлыг нь хангах, дахин гэмт хэрэг, зөрчлийн хохирогч болох, аливаа эрсдэлд/нэр хүндийг нь гутаах, доромжлох, шоолох, гадуурхах, хувийн нууцыг нь задруулах зэргээс үүдэн амиа хорлох, сургуулиас гарах, халдлагад өртөх/өртөхөөс сэргийлэх, хамгаалах үүрэгтэй.

Аймаг, нийслэлийн боловсролын байгууллага нь гэрч, хохирогч хүүхдийн тасралтгүй боловсрол эзэмших эрхийг нь хангуулахад, тэдний нийгэмшихүйн хөгжлийг дэмжихэд хуулиар өгөгдсөн чиг үүргээ хэрэгжүүлж буй эсэх талаар сургуулийн үйл ажиллагаанд хяналт тавих, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх үүрэг хүлээсэн байна.

Эрүүл мэндийн сайд, Хууль зүйн сайдын хамтарсан 2014 оны 10 дугаар сарын 24-ны өдрийн, А/356,А/182 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Гэрч, хохирогчид эрүүл мэндийн туслалцаа үзүүлэх журам”³⁸-д гэмт хэргийн улмаас эрүүл мэнд нь хохирсон, хамгаалалтад байгаа гэрч, хохирогчид эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх харилцааг зохицуулсан байна. Мөн осол, гэмтэлд өртсөн, амь тэнссэн, эмнэлгийн яаралтай тусламж авах хойшлуулшгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд эмнэлгийн лавлагаа, шатлалын тусламж, үйлчилгээ үзүүлэх эмнэлэг болон хөнгөвчлөх, асаргаа сувилгааны төвд шууд хандан³⁹ эрүүл мэндийн үйлчилгээ авч байх заалт бий.

3.2. ГЭРЧ, ХОХИРОГЧ ХҮҮХДЭД ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ:

Олон улсын стандарт, удирдамжийн дагуу гэрч, хохирогч хүүхдийг дэмжин туслах үйлчилгээг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа (ХХША)-ны аль болох эрт үеэс эхлэн хүүхдийг ойлгон, хүлээж авахуйц байдлаар түүнд туслах талаар бэлтгэгдсэн мэргэжилтнээр дамжуулан хүргэх явдал юм. Түүний гол зорилго нь хүүхэд дарамтад орох, давхар болон дахин хохирохоос хамгаалахад чиглэнэ. “давхар хохирох” нь гэмт үйлдлийн шууд үр дагаврын улмаас бус байгууллага, хувь этгээдээс хохирогчийн талаар авсан арга хэмжээний улмаас хохирох, “давтан хохирох” нь нэг этгээд тодорхой хугацааны турш хэд хэдэн удаа гэмт үйлдлийн улмаас хохирохыг ойлгодог байна.

37 Хүүхдийн эрх, хамгаалал. Гарын авлага. 297-р тал.НҮБХС, ХЗДХЯ, МУИС-ХЗС, УБ., 2011 он

38 Журмын эхийг <https://www.legalinfo.mn/law>. Хуулийн нэгдсэн портал сайтаас үз.

39 Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль. 7.5.1 дэх заалт.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа зөвхөн хуулийн дагуу явагддаг. ЭХХШТХ-ийн 1.4 дүгээр зүйлийн 1.13-т “оролцогч” гэж сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, хуулийн этгээд, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийг” гэж заасан. Иймд “хохирогч” нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны “оролцогч” юм.

Олон улсын стандарт журмын дагуу практик үйл ажиллагааны зарчмуудыг хууль тогтоомж, процессын үйл ажиллагаатай нийцүүлэн хэрэглэж, бэрхшээлийг даван туулахыг эрмэлзэх, гэрч, хохирогч хүүхэд бүрийн онцгой хэрэгцээг хангах аргачлал бий болгох, ХЭТК-ийг хэрэгжүүлэх, эдгээр хүүхэдтэй ажиллах хүмүүст туслах, сургах шаардлагатай. Үүний учир нь эдгээр хүүхдэд ажиллагаанд оролцохдоо нэмэлт бэрхшээлтэй тулгардаг, тэдэнд тусгай хамгаалалт, халамж шаардлагатай болдог, тэд гадуурхагдаж магадгүй, тэднийг гэмт хэрэгтэн хэмээн андуурагдан хохирч болзошгүй тул эдгээр хүүхэдтэй ажилтнуудын харьцах хандлагыг сайжруулах хэрэгтэй болдог. Олон улсын чиг хандлага ч ийм байдаг байна.

Хохирогч болон гэрч хүүхдийн хүйсийг харгалзан адил хүйсийн байцаагч, өмгөөлөгч, прокурор, шүүгч ажиллуулах арга хэмжээ авах нь тухайн хүүхдийн хүйсийн ялгаатай байдлыг хүндэтгэн үзэж, сэтгэл зүйн хувьд айдасгүй, ичих зовох байдал бага байх боломжтойг анхаарвал зохино. Сүүлийн жилүүдэд гэмт хэргийн хохирогч эмэгтэй, эрэгтэй хүүхдийн тоон харьцаа 45-50% буюу ойролцоо байгаа нь тэдэнд нөлөөлж буй үндсэн шалтгааныг тогтоож арилгах, тэдний ялгаатай хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн болон бусад тусламж, үйлчилгээг өргөжүүлэх, хөгжих орчин нөхцөлийг сайжруулах жендэрийн мэдрэмжтэй бодлого арга хэмжээ шаардагдаж байна.

Үйл ажиллагааны зарчмууд нь гэрч, хохирогч хүүхдийн нэр хүндийг хамгаалах, ялгаварлан гадуурхахгүй байх, ашиг сонирхлыг дээд зэргээр хангах, хамгаалалт үзүүлэх, зохистой амьдарч, хөгжих, оролцож үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хангах явдал юм.

Гэрч, хохирогч хүүхдийг хамгаалах чиглэл

НҮБ-ын НЭЗЗ-ийн 1997 оны 30-р тогтоол 42-52 -оор баталсан эрх зүйн системд хүүхдийн талаар хэрэгжүүлэх ажиллагааны удирдамжид зааснаар гэрч хохирогч хүүхдийг оролцуулах процессын ажиллагаа нь:

- ямар нэгэн айдас, дарамт, хүндрэлгүй оролцуулах нийгэм, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх;
- Хохирогч хүүхэдтэй харьцах, ажиллах талаар цагдаа, хуульч, шүүгч нар сургагдсан байх;
- Хянан шийдвэрлэх ажиллагаанд хүүхдийг оролцуулах ажиллагааг явуулах эрх зүйн акт, ёс зүйн код, шалгагдсан практик ажиллагаатай байх ;
- Хохирогч хүүхдийн онцлог байдлыг хүндэтгэн үзэх;
- ямар нэг хохирол амсахаас хамгаалагдсан, шударга зарчмаар үйлчлүүлсэн байх ;
- Хохирогч хүүхдэд тохирсон өмгөөлөл, хамгаалал, эдийн засгийн эрүүл мэнд, нийгмийн тусламж, дэмжлэг, нийгэмшүүлэх үйлчилгээ, сэтгэл санаа, бие бялдрын нөхөн сэргээх үйлчилгээ авах боломж нээлттэй байх;
- Хөгжлийн бэрхшээлтэй, хүнд өвдсөн хүүхдэд тусгайлсан дэмжлэг үзүүлэх ;

- Гэр бүл, олон нийтэд түшиглэсэн нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэхийг институци түшиглэсэн арга хэмжээнээс илүү чухалд үзэх;
- Хохирогч хүүхдэд айдас, дарамт үүсгэхгүйгээр, тэгш байдлаар харьцсан нөхцөлд ажиллагаанд оролцох шүүхийн болон захиргааны механизмыг бэхжүүлэх;
- Хохирогч хүүхэд, түүний хууль ёсны төлөөлөгч энэ байдлаар ажиллагаанд оролцох;
- Хүнлэг бус, харгис үйлдлүүдийн хохирогч болсон хүүхдэд учирсан хохирлыг зохих ёсоор шударгаар барагдуулсан байх;
- Гэрч хүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоходоо дэмжлэг авах боломжтой байх ;
- гэрч хүүхдийн баримт гарган нотлох, хэрэг бүрдүүлэх хуулийн дагуу гэрч ажиллагаанд оролцуулахдаа хүүхдийн эрхийг бүрэн хамгаалсан байх;
- Энэ нөхцөл байдлыг хянан үзэх, үнэлэх, сайжруулах;
- хохирогч хүүхэд, гэмт хэрэгтэн хоёрыг нүүр тулан уулзуулахаас аль болох зайлсхийх;
- Хүүхдийн хувийн нууцыг хамгаалах зорилгоор олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглан мөрдөхийг хориглох;
- хүүхдийн мэдүүлгийг видеогоор баталгаажуулж, түүнийг шүүн таслах ажиллагаанд хэрэглэх;
- цагдаа, прокурор, шүүгчид гэрч хүүхэдтэй ярилцах, мэдүүлэг байцаалт явуулахдаа хүүхдэд ээлтэй байдлаар явагдах.

Процессын ажиллагаанд оролцуулах үйл явц:

- Хохирогч хүүхдэд ямар үүрэг гүйцэтгэх, энэ нь хэр ач холбогдолтой болох, хэр их цаг хугацаа шаардах, үйл явцын ямар өрнөл байгаа, гэмт үйлдлийн улмаас ямар хохирол учирсан зэргийг мэдээлнэ.
- Гэрч хүүхдийг мэдүүлэг өгөхөөс нь өмнө ажиллагаанд оролцуулах журмыг танилцуулна. Бүх үе шатанд гэрч болон хохирогч хүүхдэд зохих дэмжлэгийг тасралтгүй үзүүлнэ.
- Хохирогч хүүхдийн санал бодлыг ажиллагааны явцад зохих шатанд сонссон, түүнд ямар нэгэн гаднын нөлөө, өөр бусад сонирхлын илрэлгүй хууль ёсны дагуу анхаарал хандуулсан байна.
- Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг цаг алдалгүй шуурхай гүйцэтгэж, хохирогч болон гэрч хүүхдийн хувийн нууцыг хамгаалан, хэрэгцээ гарвал хүүхдийг дарамт, шахалтаас хамгаална.
- Хууль бусаар болон эндүүрлээр хийлийн чанадад гарсан хүүхдийг төрөлх оронд нь буцаах үндсэн зарчмыг баримтална. Эх орондоо эргэн ирсний дараа хүүхдэд хүндэтгэлтэй хандан, хүний эрхийн талаарх олон улсын зарчмуудыг мөрдлөг болгон гэр бүлд түшиглэсэн нөхөн сэргээх арга хэмжээг авна.

Процессын ажиллагааны үед гэрч, хохирогч хүүхдийн дараах эрхийг онцгойлж үзэн хэрэгжүүлэх нөхцөлийг хангахдаа хүүхдийн эрх ашгийг харгалзан үр бүтээлтэй ажиллаж, хамгаалах тусгай арга барил, хандлагыг бий болгон, тогтвортой ажиллах мэргэжилтнийг

сургаж, дэмжинэ. Энэ чиглэлээр тусгай нэгж, алба байгуулж болно:

- Хүндэтгэлтэй, анхаарал халамжтай хандуулах эрх
- Ялгаварлан гадуурхалтаас хамгаалуулах эрх
- Мэдээлэл авах эрх
- Үзэл бодол, сэтгэл зовнисон асуудлаа сонсгох, илэрхийлэх эрх
- Үр дүнтэй туслалцаа, дэмжлэг авах эрх
- Хувийн амьдралаа хамгаалуулах эрх
- Процесс ажиллагааны болзошгүй хүндрэл, бэрхшээлээс хамгаалуулах эрх
- Аюулгүй байдалд байх эрх
- Хохирлоо барагдуулах эрх
- Урьдчилан сэргийлэх тусгай арга хэмжээ авхуулах эрх

Дээрх бүхий л үйл ажиллагаанд мэргэжилтнүүд анхаарч ажиллах ёстой билээ. Мэргэжилтнүүд гэдэг нь гэмт хэргийн гэрч, хохирогч хүүхдүүдтэй байнгын холбоотой ажилладаг буюу энэхүү үндсэн зарчмуудыг хэрэгжүүлж байгаа, шүүх эрх мэдлийн тогтолцоон дахь хүүхдийн хэрэгцээг хангахын төлөө хариуцлага хүлээж байгаа этгээдийг хэлнэ. Үүнд: 1) хохирогч болон хүүхдийн өмгөөлөгч, тэдэнд дэмжлэг үзүүлж байгаа бусад этгээд; 2) хүүхэд хамгаалах албаны ажилтан; 3) хүүхдийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагын албан хаагч; 4) прокурорын байгууллагын ажилтан; 5) хариуцагчийн өмгөөлөгч; 6) дипломат болон консулын байгууллагын ажилтан; 7) гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хөтөлбөрийн ажилтан; 8) шүүгч, шүүхийн ажилтан; 9) хууль сахиулах байгууллагын ажилтан; 10) эмнэлэгийн ажилтан болон сэтгэл зүйч; 11) нийгмийн ажилтан хамаарна. Эдгээр этгээдээр хязгаарлаж үл болно (*"Гэмт хэргийн гэрч ба хохирогч хүүхэд оролцохтой холбоотой асуудлаарх шүүн таслах ажиллагаанд хамаарах Удирдах зарчмууд"* 9 зүйлийн "в" хэсэг).

Мэргэжилтнүүд салбар дундын хамтын ажиллагааг анхаарч хохирогчийг дэмжих, эрхийг нь хамгаалах, санхүүгийн дэмжлэг үзүүлэх, зөвлөгөө өгөх, боловсрол, эрүүл мэнд, эрх зүйн болон нийгмийн өргөн цар хүрээтэй үйлчилгээг үзүүлнэ. Процессын ажиллагааны бүх үе шатанд дээрх хүүхдэд үйлчилгээ үзүүлэх субъектүүдийн хооронд хамтын ажиллагаагаа дэмжин ашиглах талаар ажлын протоколууд, цагдаа, прокурор, эрүүл мэнд, сэтгэл зүйн, нийгмийн үйлчилгээний заавар журам гаргаж ашиглаж болно. Мэргэжилтнүүд бүх түвшинд хамтран ажиллаж, харилцан туслалцан гэрч, хохирогч хүүхдийг үр дүнтэй хамгаалах ажил үүргээ тогтмол үнэлгээ өгч байх хэрэгтэй.

Гэрч, хохирогч хүүхдээс мэдүүлэг авах өрөө нь Цагдаагийн байгууллага дээр биш ХЭХЗХ-ны Ажлын алба дээр эсхүл тусгай тохижуулсан хүүхдийн өрөөнд байх нь тохиромжтой. Энэ боломжийг төрийн байгууллага хангасан байх үүрэгтэй бөгөөд мэргэжилтнүүд бүхий л шатанд хүүхдийн эрх ашгийн үүднээс шаардах эрхтэй. Үүний тулд мэргэжилтнүүдэд төлөвлөлт, үйл ажиллагаа, хяналт-шинжилгээ, үнэлгээнд жендэрийн мэдрэмжтэй арга зүйг эзэмшүүлэх сургалт нөлөөллийн ажил зохион байгуулах замаар жендэрийн мэдрэмжтэй хүний нөөцийг бэлтгэх шаардлага үүсч байна.

3.3. ЯРИЛЦАХ СЭДЭВ БА ХЭЛЭЛЦЭХ КЕЙС

Гэрч ба хохирогч хүүхдийн эрх зүйн байдал ямар байна вэ?/Тэдний эрх ашгийг хамгаалсан хууль тогтоомжууд байгаа эсэх, байгаа бол хэрэгжилт ямар байгаа, сайжруулах ямар шаардлага байгаа талаар/

Гэрч ба хохирогчийн жендэрийн эрх тэгш байдал хэрхэн хангагдаж байна вэ? /жендэрийн хэрэглээ ба хэрэгцээ хэрхэн хангагдаж буй тухай, эмэгтэй, эрэгтэй хүүхдийн хүйсийн болон сэтгэл зүйн ялгаатай байдлыг хүндэтгэж, эрх тэгш хандаж буй эсэх/

Хүн амины гэмт хэргийн ганц гэрч 13 настай охин А. Гэмт хэрэг үйлдсэн этгээд үйлдэл дээрээ баригдсан боловч Цагдаагийн байгууллагад хүргэх явцад оргон зугтжээ. Гэмт этгээд гэрчийн амь насанд халдана гэж заналхийлж, гэрийн хаягийг нь хайж яваа тухай гэрчүүд мэдүүлсэн байна.

Гэрчийг хамгаалах арга хэмжээг хэрхэн зохицуулах вэ?

Гэмт хэргийн улмаас сэтгэл санааны хувьд гүн цочролд орсон гэрч А тавгүй байдалд орсон гэх эмчийн дүгнэлтийн дагуу түүний ээжийг мэдүүлэг өгөх явцад хажууд нь байлгахыг шүүх зөвшөөрчээ.

Шүүгдэгчийн өмгөөлөгч гэрчийн ээж нь мэдүүлэг өгөх үед нь гараас нь барьж байгаа нь түүний мэдүүлэгт нөлөөлж байх тул зайтай суулгахыг шүүхээс хүсэв.

Шүүх хэрхэн шийдвэрлэх вэ?

Төрөлжсөн асрамжийн газрын асруулагч сэтгэцийн өвчтэй 15 настай А-г асрамжийн үйлчилгээ үзүүлдэг ТББ-ын дарга Б удаа дараа хүчирхийлсэн гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татжээ. Яллагдагч Б-ын эхнэр өөрийн хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах чадваргүй хохирогч А-ын хууль ёсны төлөөлөгчөөр оролцож байгааг хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагын ажилтан прокурорт хандаж гомдол гаргажээ.

Прокурор гомдлыг хэрхэн шийдвэрлэх вэ?

ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДСОН ХҮҮХДЭД ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

Гэмт хэрэг, зөрчилд холбогдсон хүүхэд гэдэгт-гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэж сэжиглэгдэн шалгагдаж, мөрдөгдөж байгаа, шүүгдэж байгаа, шүүхээр шийтгэгдэж ял аван батлан даалтад байгаа, сургалт хүмүүжлийн тусгай байгууллагаас суллагдсан хүүхдийн асуудлыг хамааруулан үзнэ.

Монгол Улсын ЭХХШТХ-д “сэжигтэн”-г эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч байхаар уг хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1.13 дахь хэсэгт тодорхойлсон байдаг бөгөөд гэмт хэрэг үйлдсэн байж болзошгүй гэж хуульд заасан үндэслэлээр сэрдэгдсэн, хууль ёсны эрх ашиг, сонирхлоо хамгаалуулах, хууль зүйн туслалцаа авах эрхтэй субъект юм.⁴⁰ Энэ хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцсан сэжигтнийг яллагдагч⁴¹ гэнэ.

4.1. СЭЖИГТЭН ЯЛЛАГДАГЧ ХҮҮХДИЙН ЭРХ, ХАМГААЛАЛТАЙ ХОЛБОГДОХ ХУУЛИАС:

Эрүүгийн хуулийн/шинэчилсэн найруулга/⁴² 6.2, 6.14, 7.1, 7.3, 7.6, 8.1-8.7 дугаар зүйл, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн/шинэчилсэн найруулга/⁴³ 7.1-7.9, 8.6, 9.5, 12.1 дүгээр зүйл ба тус хуулийн Арван наймдугаар бүлэг, Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн⁴⁴ 31-32 дугаар зүйл, Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль⁴⁵ нь бүхэлдээ хамаарна. Дээрх хууль тогтоомжийн хүрээнд сэжигтэн, яллагдагч хүүхдийн эрх, хамгааллын асуудлыг анхаарч хяналт тавин ажиллах нь ХЭХЗХ-ны ажлын чухал чиглэлийн нэг юм. Практикаас ажиглахад зарим хуулийн заалт олон улсын гэрээ, стандарт дүрэм, журамд нийцэлгүй байдал ажиглагддаг. Тухайлбал:

ЭХХШТХ-ийн 14.10 дугаар зүйлийн 1-д “Яллагдагчийг цагдан хорих үндсэн хугацаа 1 сар байна” гэсэн нь мөн хуулийн 18.8 дугаар зүйлийн 2-т “Өсвөр насны яллагдагчийг цагдан хорих үндсэн хугацаа 1 сар байх” гэсэн заалттай адил байна. Түүнчлэн 18.2 дугаар зүйлийн 4-т “Өсвөр насны шүүгдэгчид холбогдох хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг энэ хуульд заасан ердийн журмаар явагдах ажиллагаанаас шуурхай, богино хугацаанд явуулах нөхцөлийг шүүх хангаж ажиллана” гэсэн заалт байгаа ч практик амьдрал дээр шүүгч хэргийг хүлээн авч гаргах захирамжийг хэргийг шүүхэд шилжүүлснээс хойш 15 хоногт, захирамж гаргаснаас хойш 10 хоногоос хэтрүүлэхгүйгээр шүүх хурлаар хэлэлцэн шийдвэрлэж байгаа нь шүүхэд хэрэг ирснээс хойш дор хаяад 25 хоногийн дараа шүүх хурал болох хугацааг

40 Б. Өнөрмаа. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны “оролцогч биш” оролцогч буюу “сэжигтэн”-ий талаарх зохицуулалтыг ХБНГУ-ын ЭХХШТХ-ийн /stpo/ зохицуулалттай харьцуулах нь өгүүлэл. 2019 он. <https://www.mglbar.mn/news/3090>

41 ЭХХШТХ-ийн 7.1 дүгээр зүйлийн 1.

42 Хуулийн эхийг <https://www.legalinfo.mn/law>. Хуулийн нэгдсэн портал сайтаас үз.

43 Мөн сайтаас үз.

44 Мөн сайтаас үз.

45 Хуулийн эхийг <https://www.legalinfo.mn/law>. Хуулийн нэгдсэн портал сайтаас үз.

заасан бөгөөд насанд хүрэгсэд болон насанд хүрээгүйчүүдийн гэмт хэргийн шүүн таслах ажиллагааны хугацаанд ямар нэгэн ялгавар тогтоогоогүй байна.

Мөнхуулийн 18.6 дугаар зүйлийн 4-т “Өсвөр насны сэжигтэн, яллагдагчийг албадан ирүүлсэн, баривчилсан, цагдан хорьсон тухай түүний гэр бүлийн гишүүн, хууль ёсны төлөөлөгч, эсхүл өмгөөлөгчид нь 6 цагийн дотор мэдэгдэнэ” гэсэн нь насанд хүрсэн сэжигтэнтэй адил хугацааг заасан байгаа нь олон улсын гэрээний зарчимд нийцэлгүй байна. Иймд ХЭХЗХ-ны гишүүд энэ чиглэлээр гаргасан олон улсын эрх зүйн баримт бичгүүдийг⁴⁶ судлан практикт хэрэглэх асуудлыг анхаарч ажиллах нь зүйтэй юм.

4.2. ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДСОН, СЭЖИГТЭН, ЯЛЛАГДАГЧ, ШҮҮГДЭГЧ ХҮҮХДЭД ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд “оролцогч”⁴⁷ хүүхэд тусгай анхаарал шаардагдах субъект болохын хувьд эрхээ хамгаалуулахаар нийтлэг болон онцгой, өвөрмөц, тусгай үйлчилгээг шаардана.

Юуны өмнө дээрх тогтолцооны хүрээнд насанд хүрээгүй хүн тэдний гэр бүлд тус дөхөм үзүүлэх, хүүхдийг гэмт хэргээс ангид байлгаж, хөгжлийг дэмжих, насанд хүрээгүй хүмүүст хүнлэг, шударга хандах, шүүн таслах ажиллагааны боловсон хүчнийг арга зүй, харилцаа хандлагын хувьд зохих түвшинд мэргэшүүлсэн байх зэрэгт анхаарал тавина.

Ажиллагаанд оролцогч хүүхэд бүрийг үл ялгаварлах, дээд эрх ашгийг хангах, амьд явах, амьдрах, хөгжих, бодол санаагаа илэрхийлэх, нэр хүндийг хамгаалах, оролцогч хүүхдийн асуудлыг шударга шийдвэрлэхэд салбар дундын уялдааг хангах, үндэслэлгүй хорих ял хэрэглэхээс зайлсхийх, гэмт хэргийн шинж байдал, үйлдсэн этгээдийн хувийн байдал нийгмийн хамгааллыг нийцүүлэн илүү уян хатан байдлыг хангах, процессын ажиллагааны үед шүүхийн өмнөх, дараах шатанд хорихоос өөр төрлийн арга хэмжээг хэрэглэх боломж хайх зэрэг онцлог бүхий үйл ажиллагаа явагдаж буйг анхаарч түүнд шаардлагатай хүүхдийн эрх зүйн байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн нотлох баримт, материалыг олох, тодорхойлоход анхаарч ажиллана. Хуулийн дагуу хэрэгжих нөлөөллийн арга хэмжээний үед хүүхдийг үл ялгаварлах, тэгш хандах, тэдний шашин, итгэл үнэмшил, зан үйл, ёс суртахууны үзэл баримтлалыг хүндэтгэх талаар мэргэжилтнүүд анхаарч хяналт тавина.

Сэжигтэн ба яллагдагч хүүхэдтэй ажиллах:

Гэмт хэрэг, зөрчилд холбогдсон хүүхэд сэтгэл санааны хувьд тогтворгүй болсон байдгийг харгалзан юун түрүүнд сэтгэл зүйн болон сэтгэл заслын үйлчилгээг мэргэжлийн сэтгэл зүйч-сэтгэл засалчаар үзүүлэхийн зэрэгцээ өмгөөллийн, эрүүл мэндийн, боловсролын үйлчилгээ, асран хамгаалагч-харгалзан дэмжигч, хууль ёсны төлөөлөгчийн дэмжлэг тусалцааг цогцоор үзүүлэх нь тухайн хүүхдийн эрх, хамгааллын чухал асуудал юм.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож буй гэмт хэрэгт холбогдсон, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч (цаашид эдгээр гэх) хүүхдэд зориулсан үйлчилгээний ерөнхий удирдамж нь Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын конвенцын 40 дэх хэсэг болон олон улсын дараах жишиг стандарт, дүрэм, журмын зорилго, зармыг үндэслэн явуулна. Үүнд:

46 Олон улсын стандарт, дүрэм, журмуудыг гарын авлагын хавсралтаас үзнэ үү.

47 ЭХХШТХ-ийн 1.4 дүгээр зүйлийн 1.13 дахь заалт. <https://www.legalinfo.mn/law>. Хуулийн нэгдсэн портал сайтаас үз.

- Гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн асуудлаар эрүүгийн хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүүхэдтэй ажиллах заавар (1997)
- Насанд хүрээгүй хүмүүсийн талаар шүүн таслах ажиллагаа явуулахтай холбогдуулан НҮБ-аас гаргасан стандартын наад захын журам (1985)
- Хорихоос өөр төрлийн арга хэмжээнд холбогдох НҮБ-ын наад захын жишиг дүрмийг хэрэгжүүлэх зөвлөмж 1990.12.14 45/110 (Токио)
- Эрх чөлөөгөө хязгаарлуулсан өсвөр насны хүнийг хамгаалахтай холбогдуулан гаргасан НҮБ-ын дүрэм (1990)

Хэрэг бүртгэлтийн хэргийн шатанд холбогдогч хүүхдэд үзүүлэх үйлчилгээнд анхаарах асуудал:

- насыг үнэн тогтоох
- хариуцлага хүлээх доод, дээд нас
- тохирсон цогц ажиллагаа
- дахин давтагдах үйлдлээс сэргийлэх
- Эвлэрүүлэх
- гэр бүлийн оролцоо төрөл бүрийн арга хэмжээ
- Тусгайлан анхаарал хандуулах
- хэлмэрч, орчуулагч авах
- шинжээч, эксперт томилох
- ХХША-ны зорилгыг санах
- үзэмжээрээ шийдэх эрх хэмжээг хэрэгжүүлэх
- Тэргүүлэх зарчмуудыг биелүүлэх
- Өсвөр насны хүнийг гэмт явдлаас урьдчилан сэргийлэх
- Процессын ажиллагаанд хөндлөнгийн оролцоог нэмэгдүүлэх
- хувийн орон зайг нь хамгаалах
- Үзэл бодлоо илэрхийлэх
- хувийн нууц, халдашгүй байдлыг хүндэтгэх
- буруугаа хүлээхийг албадахгүй байх
- гэрчүүдийг байлцуулан нарийн судлах оролцооны зарчмыг хангах
- Ажиллагаанд үр бүтээлтэй оролцуулах
- эрх зүйн туслалцаа үзүүлэх
- гэм буруугүйд тооцох, тооцуулах
- хохирогчийн эрхийг хангах шалгуур үзүүлэлтээр үнэлгээ хийх
- Хорихоос өөр төрлийн арга хэмжээг сонгуулах хүсэлтээ гаргах
- эрхийг нь зөрчсөн талаарх гомдлоо гаргах
- гомдол, хүсэлт гаргах, давж заалдах эрх
- ажилтны зохих сургалт
- хүүхдийн эрх санаатай зөрчигчид хариуцлага

Мөрдөн шалгах шатанд сэжигтэн, яллагдагчаар тооцох хүүхдэд хамаарах үйлчилгээнд анхаарах асуудал:

- баривчлах, саатуулах үеийн зохих тусламж, анхаарал
- ажилтны сургалт
- хэрэв саатуулах, цагдан хорих бол энэ нь эцсийн зайлшгүй арга хэмжээ байх, энэ талаар ар гэрт нь нэн даруй мэдэгдэх
- суллах шийдвэрийг даруй гаргах
- Хоригдсон үед жишиг дүрмийн дагуу зохих эрх чөлөөгөөр хангагдах
- насанд хүрэгчдээс тусдаа байх
- хоригдогчийн хувийн байдлыг харгалзан шаардлагатай халамж, хамгаалалт үзүүлэх
- процессын бус ажиллагааны журмаар хянаж үзэх
- цагдаагийн алба хаагч мэргэшсэн байх
- Гэм буруугүйд тооцох, тооцуулах
- яллагдагчаар татсан тухай шууд, шуурхай мэдээлэх
- эрх зүйн туслалцаа үзүүлэх
- буруугаа хүлээхийг албадахгүй байх
- урьдчилан хорих түүний нөхцөл, хугацааг хуулиар тогтоон тогмол шалгах
- аль болох даруй суллах
- 24 цагийн дотор хянах, үндэслэлийг 2 долоо хоног тутам шалгах, хорьсноос
- 30 хоногийн дотор шийдвэрлэх, эрх бүхий байгууллага 6 сарын дотор шүүхийн эцсийн шийдвэрийг гаргаж байхыг баталгаажуулах
- цагдан хорихоос зайлсхийх тэр болтол хувилбарт арга хэмжээг хэрэгжүүлэх
- цагдан хоригдсон үедээ зохих талд гомдол, хүсэлт гаргах
- таслан сэргийлэх арга хэмжээ нь хамгийн богино хугацаагаар байх, тэр үедээ хуулийн зөвлөгөө, туслалцаа авах, өмгөөлөгчтэйгөө тогтмол уулзах
- Хувийн нууцаа хангуулах
- Цалин хөлстэй ажил хийх, сургалтад хамрагдах, амрах, зохих тал зөвшөөрвөл чөлөөт цагийн эд зүйлээ авч орох, өөртөө байлгах

Шүүн таслах үе шатанд шүүгдэгч хүүхдэд хамаарах үйлчилгээнд анхаарах асуудал

- Хаалттай институцэд хүүхэд байлгахыг багасгах
- ажилтны сургалт
- өмгөөлөгч, эцэг эх, асран хамгаалагч харгалзан дэмжигчийг /АХХД/ оролцуулах
- Өмгөөлүүлэх, үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа авах, хүсэх
- хувийн байдлыг үнэлсэн мэдээлэл баримт сонсох, авах, тэдгээрийг нягт судлах
- шийдвэрийн үндэслэл хэргийн байдал болон өсвөр насны хүний байдлыг тэдний хувийн болон нийгмийн хэрэгцээтэй хамааруулж үзэх
- эрх чөлөөг хязгаарлахыг боломжийн хэрээр богино хугацаатай байлгах
- аль болох нөлөөллийн арга хэмжээг сонгох

- төвлөрүүлж хүмүүжүүлэх байгууллагад өгөх арга хэмжээг аль болох бага хэрэглэх
- Шаардлагагүй чирэгдүүлэлтээс зайлсхийн аль болох шуурхай шийдвэрлэх
- хэргийн материал бүрэн нууц байх
- шударга шүүхийн баталгаагаар хангах
- шүүх ажиллагааны өмнөх шатны хувилбарт арга хэмжээг сонгох
- эрх бүхий албан тушаалтны лавлагаа, тодорхойлолт гаргуулах, гаргах
- ял оногдуулахад холбоотой зөвлөмж мэдээлэл өгөх, санал дүгнэлтээ илэрхийлэх

Шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх шатанд байгаа хүүхдийн үйлчилгээнд анхаарах асуудал

- Бүх тогтолцоонд бие махбодын шийтгэлийг хориглох
- ХЭК37.
- эцэг эх, асран хамгаалагч харгалзан дэмжигчийг хялбаршуулан журмаар нэвтрэх боломж олгох
- хүүхдэд үнэлгээ хийж байгаа талын эрх, нөхцөл шаардлагыг биелүүлэх
- хүсэлт, эргэлтийг хүлээн авах
- тухайн системийн хүүхдэд тусах сөрөг нөлөөг анхаарах
- ажилтны сургалтыг тогтмол хийх
- хууль сахиулах болон захиргааны байгууллага нягт хамтын ажиллагаатай байх
- Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагын /СХТБ/ гадна байгаа өсвөр насны хүнд
- Шийдвэрийг үр нөлөөтэй гүйцэтгэх
- зайлшгүй туслалцааг үзүүлэх
- Сайн дурын олон нийтийг дайчлах
- СХТБ-д байгаа өсвөр насны хүнд анхаарал хандуулах
- асрамж халамжаар дэмжих
- боловсрол, мэргэжлийг дэмжих
- насанд хүрэгчдээс тусад нь байлгах
- охидын хэрэгцээнд анхаарах
- эцэг эх, АХХД–тэйгээ уулзах боломж олгох
- хоригдлуудтай харилцах жишиг дүрмийг дагах
- тэнсэх суллах нөхцөлийг аль болох эрт хэрэглэх
- завсрын дэглэмийг зохион байгуулах
- шүүхийн ажиллагааны дараа эрх чөлөөг хязгаарлуулах үед:
- Хуульд нийцсэн, эцсийн, хамгийн богино байх
- Хүүхэд шийдвэрээ шаардах, танилцуулах
- Насанд хүрэгчдээс тусад байлгах 18 нас хүрмэгц шилжүүлэх эсэхийг нухацтай судлах
- Хүүхэд эргэлт авах, захидлаар харилцах зэргээр гэр бүлтэйгээ холбоотой байх энэ эрхийг нь үл хязгаарлах
- Хүүхдийн байх орчин байрыг аль болох тохиромжтой, эрсдэлгүй байлгахад анхаарах

- Сургалт үйлчилгээтэй байх
- Хүүхэд өөрийгөө гэмтээхээс сэргийлэх
- Хүүхэд хүлээн авах, бүртгэх, шилжүүлэх журамтай байх
- тухай бүрийг ар гэрт нь даруй мэдэгдэх,
- хүүхдийн бүрэн мэдээллийг мэргэжилтэн бэлтгэж, танилцуулах
- хүүхдэд байрны дэг дүрмийг танилцуулах, эрх үүргийг тайлбарлаж ойлгуулах,
- Бүх мэдээллийг шинэчлэлийн хамт агуулах хавтаст хэрэг үүсгэх
- түүнтэйгээ танилцах, залруулах хүсэлт гаргах эрх

Хянан шийдвэрлэх ажиллагааны бүх үе шатанд сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ял шийтгэл, хариуцлага хүлээсэн, эдэлж байгаа хүүхдэд үзүүлэх үйлчилгээнд анхаарах нийтлэг асуудал

- хүүхдийн эрх санаатай зөрчигчид хариуцлага тооцох
- Ажилтан, мэргэжилтний зохих сургалт, мэргэжлийн бэлтгэл, ур чадвар хангалттай байх
- Хянан шийдвэрлэх ажилтнуудыг тогтмол сургалтаар мэргэшүүлэх
- Шүүн таслах тогтолцоонд үндэсний цөөнх, эмэгтэйчүүдийн төлөөлөл бий болгох чармайлт гаргах
- Бүс нутаг, олон улсын түвшинд хамтран ажиллах
- Хэрэгжүүлж буй арга хэмжээний дэлгэрэнгүй мэдээлэл, шалгуур үзүүлэлттэй байх
- Зохих талаас зөвлөх үйлчилгээ, техникийн туслалцаа авах
- Тусгай анхаарал шаардсан хүүхдийг хамгаалах арга хэмжээ боловсруулах
- Техник хамтын ажиллагааны нөөцийг бүрдүүлэхийн зэрэгцээ нөөц, ур чадвар бүхий ТББ-ыг өргөнөөр оролцуулах
- Бүх хүүхдэд сурч хөгжих нийгэмших стратегид чиглэх
- Урьдчилан сэргийлэх төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх
- Процессын ажиллагааг үр бүтээлтэй цар хүрээтэй удирдан явуулах бүтэц байх
- Эрх бүхий институциуд дээр төрөлжсөн нэгж байгуулан хүүхдэд эрх зүйн болон бусад шаардлагатай дэмжлэг үзүүлэх өмгөөлөгч, төлөөлөгчдийг бий болгох
- Өсвөр насны хүнийг батлан даах, заавар зөвлөгөө өгөх дагнасан үйлчилгээ шаардлагатай бол тэднийг асарч хамгаалах байр, нэгжийг байгуулах, үйл ажиллагааг нь тогтмолжуулахыг дэмжих
- Өсвөр насны хүнийг гэмт үйлээс урьдчилан сэргийлэх, процессын ажиллагаа явуулахад үүрэг бүхий ТББ-ыг оролцуулах цар хүрээтэй бодлого боловсруулах, ТББ-ыг нөөц бололцоогоор хангаж ажиллах.
- Алба хаагчид мэргэшсэн байх, өсвөр насны хүний алдааг засахад нөөц бололцоогоо дайчлах
- Ажлын байранд тавих шалгуур үзүүлэлтийн дагуу сонгож сургаж бэлтгэн ажиллуулах
- Захиргаа хүүхэд, ажилтны харилцааг хянаж ажиглах,
- Өсвөр насны хүний эрх, нэр хүндийг хууль ёсоор хангаж, хамгаалж ажиллах

- Хүчирхийллээс ангид орчин бүрдүүлж эмнэлгийн үзлэгийг тогтмол явуулах
- Хүүхдийн хувийн нууцыг чанд хадгалах
- Сахилгын бүх арга хэмжээ заавар журамтай байна.нэг зөрчилд давхар шийтгэл ногдуулахгүй
- Хяналт шалгалт хийх, гомдол гаргах нөхцөлийг бүрэн хангах

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүх шатанд төрийн нэрийн өмнөөс прокурор байнгын хяналт тавьдаг. Прокурорын хяналт хууль ёсны байх ёстой бөгөөд түүний хэрэгжилтийн үр дүнд сэжигтэн, яллагдагч болон тэдгээрийн асран хамгаалагч, хууль ёсны төлөөлөгч ч сэтгэл ханамжтай байх ёстой. Үүний тулд прокурорын хянаж байх чиг үүрэг, түүний үүргээ биелүүлж байгаа байдалд оролцогч талууд санал, гомдлоо гаргах эрхтэй билээ.

4.3. МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГААНД ТАВИХ ПРОКУРОРЫН ХЯНАЛТЫН АЖЛЫН АРГАЧИЛСАН ЗААВАР-ААС

Улсын ерөнхий прокурорын 2017 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн А/96 дугаар тушаалаар баталсан. Энэ зааврын дагуу прокурор хяналт тавьж буй эсэхийг өмгөөлөгч, хууль ёсны төлөөлөгч ажиглах, санал хүсэлт, гомдол гаргаж болно.

Есдүгээр бүлэг. Өсвөр насны сэжигтэн, яллагдагчид холбогдох хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тавих прокурорын хяналт

9.1 дүгээр зүйл. Өсвөр насны сэжигтэн, яллагдагчид холбогдох хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа

1. Прокурор өсвөр насны сэжигтэн, яллагдагчийг түүний хууль ёсны төлөөлөгч, асран хамгаалагчаар дамжуулан мэдэгдэх хуудсаар дуудан ирүүлнэ.
2. Сурган хүмүүжүүлэгч, эсхүл хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагын ажилтныг дараах тохиолдолд өсвөр насны сэжигтэн, яллагдагчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд байлцуулж болно:
 - 2.1. өсвөр насны сэжигтэн, яллагдагч гэр бүлийн хүчирхийлэл, эцэг, эхийн нөлөөлөлд автаж гэмт хэрэг үйлдсэн;
 - 2.2. өсвөр насны сэжигтэн, яллагдагч нь сэтгэцийн өвчингүй боловч ухаан санаа нь гүйцэд хөгжөөгүйн улмаас өөрийн үйлдэл холбогдлыг бүрэн ойлгож, болсон хэргийн талаар үнэн зөв мэдүүлэг өгөх эсэхэд эргэлзээ төрвөл;
 - 2.3. хууль ёсны төлөөлөгч нь өсвөр насны сэжигтэн, яллагдагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулж болзошгүй гэж үзвэл.
3. Сурган хүмүүжүүлэгч нь Бага, дунд боловсролын тухай хуульд заасан багшлах эрхтэй хүн байна.
4. Прокурор, мөрдөгчийн зөвшөөрснөөр сурган хүмүүжүүлэгч, хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагын ажилтан нь мөрдөгч, прокурор, өмгөөлөгч, шинжээчийн тавьсан асуултыг зөв ойлгосон эсэхийг өсвөр насны сэжигтэн, яллагдагчаас тодруулан асууж, тайлбарлан, түүний тавьсан асуулт, өгсөн хариултыг үгчлэн тэмдэглэлд тусгана.

5. Өсвөр насны сэжигтэн, яллагдагч гэр бүлийн хүчирхийлэл, эцэг, эхийн нөлөөлөлд автаж гэмт хэрэг үйлдсэн бол тэднийг хууль ёсны төлөөлөгчөөр тогтоохгүй.
6. Прокурор Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.5 дугаар зүйлд заасан хүнийг хууль ёсны төлөөлөгчийг тогтоохдоо тогтоол үйлдэнэ.
7. Сэжигтэн, яллагдагчийн төрсөн он, сар, өдөр, насыг тогтоохдоо иргэний баримт бичиг /төрсний гэрчилгээ, иргэний үнэмлэх, иргэний бүртгэл мэдээллийн лавлагаа, гадаад паспорт/-ийг үндэслэнэ.
8. Насыг тодорхойлох баримт бичиг байхгүй, эсхүл бичиг баримтыг хуурамч гэж үзэх үндэслэл байвал шинжээчийн дүгнэлт гаргуулна.
9. Өсвөр насны сэжигтэн, яллагдагч нь сэтгэцийн өвчингүй боловч ухаан санаа нь гүйцэд хөгжөөгүйн улмаас өөрийн үйлдэл холбогдлыг бүрэн ойлгож, болсон хэргийн талаар үнэн зөв мэдүүлэг өгөх эсэхэд эргэлзээ төрвөл прокурор, мөрдөгч сэтгэц, эмгэг судлалын шинжээч томилж, дүгнэлт гаргуулна.
10. Амьдралын нөхцөл байдал, хүмүүжилтэй холбоотой мэдээллийг тогтоохдоо ам бүл, амьжиргааны түвшнийг тодорхойлсон харьяа нутаг дэвсгэрийн засаг захиргааны нэгжийн тодорхойлолт, хэрэв сургуульд сурдаг бол сургуулийн тодорхойлолтыг гаргуулан, амьдарч буй орчин, хүмүүжлийн талаар эцэг, эх, сурган хүмүүжүүлэгч болон хөрш зэргэлдээ амьдардаг бусад хүмүүсийг гэрчээр байцаах зэргээр тодорхойлно.
11. Өсвөр насны сэжигтэн, яллагдагчийн амьжиргааны түвшин, гэр бүлийн хүчирхийлэл, архидан согтуурал, найз нөхдийн хүрээлэл, сургууль завсардалт, гэр бүлийн орчин, хараа хяналтгүй байсан эсэх, эцэг, эхийн буруу үлгэр дуурайлал зэрэг нөхцөл байдал гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн эсэхийг шалгаж тогтооно.
12. Өсвөр насны яллагдагчид хавтаст хэргийн материалыг танилцуулахдаа өмгөөлөгчийг заавал оролцуулах бөгөөд түүний ашиг сонирхолд хохирол учруулж болзошгүйгээс бусад тохиолдолд хууль ёсны төлөөлөгчийг оролцуулна.
13. Прокурор нь өсвөр насны яллагдагч гэмт хэрэг үйлдэхийн өмнө болон дараа биеэ хэрхэн авч явж байсан зан байдал, гэмт хэрэг үйлдэх үедээ ямар нөхцөл байдалд байсан талаар “Өсвөр насны хүүхдийн зан байдлын тодорхойлолт”-ыг мөрдөгчөөр үйлдүүлж, хавтаст хэрэгт хавсаргана.

9.2 дугаар зүйл. Өсвөр насны яллагдагчид цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах

1. Өсвөр насны яллагдагчийн үйлдсэн гэмт хэргийн шинж, хувийн байдлыг харгалзан цагдан хорихоос бусад төрлийн таслан сэргийлэх арга хэмжээг авбал зохино.
2. Өсвөр насны яллагдагчид цагдан хорихоос бусад төрлийн таслан сэргийлэх арга хэмжээ авсан тохиолдолд ерөнхий боловсролын мэдлэг олгох хичээлийг таслуулахгүй байхаар мөрдөн байцаалтыг төлөвлөнө.
3. Өсвөр насны сэжигтэн, яллагдагчийг албадан ирүүлсэн, баривчилсан, цагдан хорьсон тухай түүний гэр бүлийн гишүүн, хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид прокурор, мөрдөгч 2 цагийн дотор амаар болон харилцаа, холбооны хэрэгсэл ашиглан мэдэгдэж, энэ тухай тэмдэглэл үйлдэн хавтаст хэрэгт хавсаргана.

4. Эрүүгийн хуульд найман жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэргийн яллагдагчийн хувийн байдал, үйлдсэн гэмт хэргийн шинж, урьд авсан таслан сэргийлэх арга хэмжээг зөрчсөн, дахин гэмт хэрэг үйлдсэн зэргийг харгалзан өсвөр насны яллагдагчид цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч болно.
5. Өсвөр насны яллагдагчид цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авахад хуульд заасан дараах хугацааг баримтална.

Өсвөр насны яллагдагчийг цагдан хорих үндсэн хугацаа 1 сар байна.

Эрүүгийн хуульд хорих ялын дээд хэмжээг 5 жил хүртэл хугацаагаар оногдуулахаар заасан гэмт хэрэгт 3 сар хүртэл, Эрүүгийн хуульд хорих ялын дээд хэмжээг 5 жилээс дээш хугацаагаар оногдуулахаар заасан гэмт хэрэгт 6 сар хүртэл байдаг бөгөөд цагдан хоригдсон өсвөр насны яллагдагчтай хэрэгт хяналт тавьж буй прокурор 10 хоног тутамд уулзаж, гаргасан санал, хүсэлт, гомдлыг шийдвэрлэнэ.

Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч хүүхдийн өмгөөлөгч, хууль ёсны төлөөлөгч хянан шийдвэрлэх ажиллагааны туршид хамт байх эрх зүйн боломжийг хууль журмын дагуу бүрэн ашиглах, мөрдөгч, прокурор, шүүгчийг аль болох хэрэгт холбогдогч хүүхэдтэй адил хүйсийн байх шаардлагыг тавьж шийдвэрлүүлэх боломжтой юм. Хүүхдийн байцаалт авах өрөө, шүүхийн танхим нь тэдний тэдний сэтгэл зүй, эрх ашигт нөлөөлж байдгийг анхаарч тусгайлсан байр бэлтгэж явуулах шаардлагатай.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь өөрийн үе шатуудтай тогтолцоо бүхий үйл ажиллагаа билээ. Иймд хүүхэд оролцсон хэргийн хянан шийдвэрлэх ажиллагааны тогтолцоонд дүн шинжилгээ хийх, хорихоос өөр төрлийн арга хэмжээг хэрэглэж байгаа байдал түүний үр дүнгийн талаарх судалгааг хөгжүүлэх, мэдээллийн тогтолцоог эрүүгийн процессын системтэй уялдуулах нөхцөлд анхаарч ажиллана. Процессын ажиллагааны үед хүүхдэд тулгарч буй асуудлуудыг тогтмол судлан шинжилж байх, шийдвэрлэх арга замын талаар хэлэлцэж байх шаардлагатай. Хороо өөрийн үйл ажиллагааны бүх хүрээнд судалгаа, шинжилгээ, хяналт үнэлгээ хийх ажлыг тогтмолжуулах нь чухал байна.

4.4. ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА БА ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ХАРИУ ҮЙЛЧИЛГЭЭ

ХЭХЗХ-ны ажлын нэг гол чиглэл нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үед хүүхдийн эрх, хамгааллын асуудалд түлхүү анхаарч, шаардлагатай арга хэмжээг Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасан ажил, үйлчилгээг үзүүлэх ёстой билээ.

Иймд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээтэй хэрхэн холбогдож, ямар үе шат, дараалалтай явагдаж болохыг дараах схемээр харуулахыг зорилоо. Схемийг ашиглан үйл ажиллагаа, үйлчилгээний төрөл, хувилбараа сонгон төлөвлөж ажиллавал зохино.

4.5. ХОРИХООС СУЛЛАГДСАН БОЛОН ХОРИХООС ӨӨР ТӨРЛИЙН ЯЛ, АЛБАДЛАГЫН АРГА ХЭМЖЭЭ АВАГДСАН ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАНГАХ, ХАМГААЛАХТАЙ ХОЛБООТОЙ ХУУЛИАС:

Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагаас суллагдсан, чөлөөлөгдсөн хүүхэд иргэний нэгэн адил халамжийн дэмжлэг, туслалцааг авах эрхтэй. Нийгмийн халамжийн тухай хуулийн⁴⁸ 13 дугаар зүйлийн 13.5.3, 18 дугаар зүйлийн 18.2.5 дахь заалтыг үндэслэн асаргааны тэтгэмж олгох, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн болон нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах үйлчилгээнд хамруулдаг.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн⁴⁹ 3.1.7, 7-11 дүгээр зүйл, 13-15-р зүйлд заасны дагуу хорихоос суллагдсан иргэнийг/16-гаас дээш насны/ үйлдвэр дээрээ дадлагажуулж буй ажил олгогчийн нэг жил хүртэл хугацааны сургалтын зардлыг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас нөхөн олгох, түүнчлэн хорихоос суллагдсан болон асрамжаас гарсан иргэн хувиараа хөдөлмөр эхлэх бол нэг сая төгрөгийн санхүүжилтийг нэг удаа олгох, мөн мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээ үзүүлэх, хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл хүргэх, ажил хайгчаар бүртгэх, ажил олгогчийг дэмжих арга хэмжээний талаар танилцуулга явуулж ажилд зуучлах үйлчилгээ үзүүлэх, хорих ангиудад ял эдэлж буй ялтнуудад суллагдсаны дараа хэрхэн ажлын байртай болох талаар зөвлөгөө өгөх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлж болох юм.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн/шинэчилсэн найруулга/ 9 дүгээр зүйл, 41-45 дугаар зүйл нь сургалт хүмүүжлийн тусгай байгууллагаас суллагдсан хүүхэд ажиллах талаар тусгайлан заасан байдаг.


Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагаас суллагдсан насанд хүрээгүй хүнийг дахин гэмт хэрэгт өртүүлэхгүй байх, тэднийг тодорхой хамт олны дунд нийгэмшүүлэн төлөвшүүлэх, хандлага зан үйлийг нь өөрчлөхөд чиглэсэн сургалт, нөлөөллийн/зөвлөн туслах/ арга хэмжээг ганцаарчлан болон хамт олны оролцоотой зохион байгуулах нь тус хуулийн хэрэгжилтийг хангах нэг алхам юм.

Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагаас суллагдсан, чөлөөлөгдсөн хүүхэдтэй ажиллах: /Сэжигтэн, яллагдагч байх үеэс хамтарсан ажиллагааг үргэлжлүүлэх, хорих байгууллагад байхад нь тогтмол харилцаатай байж, хорих байгууллагатай хамтран ажиллах, суллагдаж, чөлөөлөгдсөний дараа хяналтын шатанд хамтран ажиллах, хамт олны дунд бүрэн шилжүүлж, итгэл хүлээлгэх/

48 Нийгмийн халамжийн тухай хууль. <https://www.legalinfo.mn/law>. Хуулийн нэгдсэн портал сайтаас үз.

49 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль. <https://www.legalinfo.mn/law>. Хуулийн нэгдсэн портал сайтаас үз.

**ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА БА ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН
ХАРИУҮЙЛЧИЛГЭЭ**



ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН
ХАРИУ ҮЙЧИЛГЭЭ



Мэдээлэл хүлээн авах,
илрүүлэх шалгах



Нөхцөл байдлын
үнэлгээ

Аюулгүй байдлыг
хамгаалах

Дэмжих холбон
зуучлах

Хүүхдийн эрхийн хууль
зүйн хороо

Гэр бүлд эргэн нэгтгэх

1. Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх зорилгоор нөхцөл байдлын үнэлгээ хийнэ.

2. Нөхцөл байдлын үнэлгээ хүүхдийн амьдарч байгаа орчин, хүүхдэд үүссэн нөхцөл байдал, хүүхдийн эрхийн эсрэг үйлдэл, эс үйлдэхүйн аюул, эрсдэлийн түвшинг үнэлэх, шалгах, дүгнэх үе шатнаас бүрдэнэ.

3. Баг, хороо, сум, дүүрэг, аймаг, нийслэлийн нийгмийн ажилтан, хүүхдийн эрхийн ажилтан өөрийн санаачилгаар, эсхүл хуулиар хүлээлгэсэн үүргээ биелүүлэх явцаа холбогдох этгээдээс ирүүлсэн мэдээ, мэдээллийг үндэслэн нөхцөл байдлын үнэлгээ хийнэ.

4. Нийгмийн ажилтан, хүүхдийн эрхийн ажилтан нөхцөл байдлын үнэлгээ хийх явцаа тухайн асуудлыг газар дээр нь болон хуульд заасны дагуу холбогдох этгээдээр шийдвэрлүүлэх үндэслэлтэй бол хүүхдэд хувийн хэрэг нээж, зөвлөгөө өгөх, дэмжих, холбон зуучлах үйлчилгээнд хамруулна.

5. Эрсдэлд байгаа хүүхдэд нөхцөл байдлын үнэлгээ хийх журмыг хүүхэд гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална.

6. Нөхцөл байдлын үнэлгээ хийсэн, хариу үйлчилгээ үзүүлсэн нийгмийн ажилтан, хамтарсан багийн гишүүнд нэмэгдэл урамшуулал олгох бөгөөд уг журмыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална.



ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН
ХАРИУ ҮЙЧИЛГЭЭ



Мэдэлэл хүлээн авах,
илрүүлэх шалгах

Нөхцөл байдлын
үнэлгээ

Аюулгүй байдлыг
хамгаалах

Дэмжих холбон
зуучлах




Хүүхдийн эрхийн хууль
зүйн хороо

Гэр бүлд эргэн нэгтгэх


1. Аймаг, дүүргийн Засаг дарга орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралтай зөвшилцөн хүүхдийн эрхийн хууль зүйн хороог байгуулах бөгөөд хороо нь дараахь үйл ажиллагаа явуулна:
1.1. Гэмт хэрэг үйлдэж шүүхээс ял шийтгүүлсэн, хүмүүжлийн чанартай арга хэмжээ авагдсан хүүхдийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас хүлээн авах, шүүхээс хүүхдэд даалгасан үүргийг биелүүлэхэд зөвлөгөө өгөх, дэмжлэг, тусалцаа үзүүлэх;
1.2. Сургалт, хүмүүжлийн тусгай байгууллагад хүмүүжиж байгаад суллагдсан хүүхдийг нийгэмд хэвийн амьдрахад нь дэмжлэг, тусалцаа үзүүлэх;
1.3. Гэмт хэрэг, зөрчилд холбогдон шалгагдаж байгаа хүүхдийг эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны сөрөг нөлөөлөөс хөндийрүүлэх зорилгоор хууль сахиулах байгууллагатай хамтран ажиллах, хүүхдэд батлан даагч томилуулахаар санал гаргах;
1.4. Хууль зөрчсөн хүүхдийг зөв зохистой хүмүүжил олгох сургалт, хөгөлбөрт хамруулах;
1.5. Эцэг, эх, гэр бүлийн гишүүд, үе тэнгийхэн, сургууль, хамт олонд нь зөвлөгөө өгөх, тогтмол хугацаанд уулзалт, ярилцлага зохион байгуулж, үр дүнг тооцох;
1.6. Хорт зуршлаас ангижрах эмчилгээнд хамруулах, зөвлөгөө өгөх, ажил, сургууль, мэргэжил олгох сургалтад хамруулах;
1.7. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн үйлчлэлд хамаарахгүй хүүхдэд тусалцаа үзүүлэх, зөвлөгөө өгөх, гэдний эрх ашгийг хамгаалах;
15.2. Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны ажлын албаны үүргийг орон нутгийн хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн байгууллага хэрэгжүүлнэ.
15.3. Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хууль зүйн болон хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.
15.4. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 20.1-д заасан хамгарсан баг эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар нөхцөл байдлын үнэлгээ хийж, цаашид тухайн хүүхдэд шаардлагатай үйлчилгээний талаар дүгнэлт, зөвлөмж гаргаж, хуульд заасны дагуу тусламж, үйлчилгээ үзүүлнэ.



**ХҮҮХДИЙН ЭРХИЙН ХУУЛЬ ЗҮЙН ХОРООНЫ ШИЙДВЭР ГАРГАХ,
ШИЙДВЭРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ, ХЯНАЛТ ТАВИХ БУДУУВЧ**




ХОРООНЫ НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРЭГ




ДЭМЖЛЭГ, ТУСЛАЛЦАА, ҮЙЛЧИЛГЭЭ



НӨХЦӨЛ БАЙДЛЫГ ҮНЭЛГЭЭГ ҮНДЭСЛЭН








ХОРООНЫ

ТУСГАЙ

ЧИГ ҮҮРЭГ





ХОРООНЫ ТУСГАЙ ЧИГҮҮРЭГ

- 1 Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад хүмүүжиж байгаа хүүхэд
- 2 Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагаас сүлжигдсэн хүүхэд
- 3 Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авалдсан хүүхэд
- 4 Гэмт хэргэгт холбогдон шалгагдаж байгаа хүүхэд
- 5 Гэмт хэргийн гэрч, хохирогч хүүхэд

ГЭРЧ

- 1 Гэрч хүүхдийн мэдээллийг цагдаагийн байгууллага болон бусад этгэдээс хүлээн авсны гэрч хүүхэд болон түүний хууль ёсны төлөөлөгчтэй уулзах уулзалтыг зохион байгуулах;
- 2 Сум, хорооны цагдаа болон нийгмийн ажиглан нь гэрч хүүхэд, түүний хууль ёсны төлөөлөгчтэй уулзаж, хорооноос гэрч хүүхэд үзүүлж болох үйчлгээ, зовлогөө, туслацаан танинуулж, хамтран ажиглах боломжийг санал болгох;
- 3 Гэрч хүүхэд, түүний хууль ёсны төлөөлөгчид хэрэг хянан шийдвэрлэх ажиглагаа болон гэрч хүүхэд, түүний хууль ёсны төлөөлөгч энэ ажиглагаанд ямар эрх, үүрэг, хариуцлагатай оролцох талаар хууль зүйн зовлогөөг өгөх
- 4 Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан хамгаалалтын арга хэмжээг гэрч хүүхэд авах шаардлагатай нөхцөл байдал үүссэн талаар хүүхэд, түүний хууль ёсны төлөөлөгч хүсэлт гаргавал хороо холбогдох албан тушаалтанд холбоон зуучлах;
- 5 Гэрч хүүхэд, түүний хууль ёсны төлөөлөгч нь хэрэг хянан шийдвэрлэх ажиглагааны явцад хүүхдийн эрх, ашиг сонирхол, хувийн халдашгүй байдал зөрчигдсөн, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, өмгөөлөгчийн зүгээс ёс зүйн зөрчил гаргасан, эрх ашгийг хохироосон зэрэг хэрэг хянан шийдвэрлэх ажиглагааны сөрөг нөлөөллийн талаар хороонд гомдол гаргасан тохиолдолд хороо хүүхдийн эрх ашгийг хамгаалахаар хуульд заасан арга хэмжээг хэрэгжүүлэх;
- 6 Гэрч хүүхдийн эрх, ашиг сонирхол хууль ёсны төлөөлөгчтэй зөрчилдсөн нь тогтоогдсон тохиолдолд хорооноос хүүхдийн эрх ашгийг төлөөлөн хамгаалах эрх бүхий этгэдийн гомдлуудлах, хэрэг хянан шийдвэрлэх ажиглагаанд оролцуулах ажлыг зохион байгуулах;
- 7 Хэрэг хянан шийдвэрлэх ажиглагаанд оролцогч сэтгэл зүйч, хэлмэрч, орчуулагч, сурган хүмүүжүүлэгч, нийгмийн ажиглан, хүүхдийн эрхийн ажиглантай холбоо тогтоож хэрэг хянан шийдвэрлэх ажиглагааг хүүхэд хүндрэл бэрхшээлтэй шуурхай явуулах ажлыг зохион байгуулах;
- 8 Гэрч хүүхдээс байцаалт мэдүүлэг авах, гэрч хүүхдийг шүүх хуралд оролцуулах тусгай нөхцөл боломжийг бүрдүүлдсэн орчныг бий болгох асуудлаар цагдаа, прокурор, шүүх байгууллагатай хамтран ажиллах;

4.6. СУРГАЛТ ХҮМҮҮЖЛИЙН ТУСГАЙ ТӨВӨӨС СУЛЛАГДСАН ХҮҮХДИЙН АСУУДЛЫГ ТУСГАЙЛАН АВЧ ҮЗЭХ НЬ⁵⁰

Бодлогын судалгааны хүрээнд хорих байгууллагаас суллагдсан хүүхдийн асуудлыг тусгайд нь авч үзэх шаардлагатай хэмээн үзжээ. 2006, 2009 онуудад батлагдан гарсан “Өршөөл үзүүлэх тухай” хуулиар хорих 411, 407 дугаар ангиас суллагдсан хүүхдүүд ахин гэмт хэрэг үйлдэж шоронд орсон, эсвэл насанд хүрсэн хүмүүсийн хорих ангид дэглэм өгсөж хоригддог, 50-70 хувь нь суллагдсанаас хойш 3 жилийн дотор дахин гэмт хэрэг үйлдсэн байна.

Дээрхээс дүгнэн үзвэл шоронгоос суллагаад хүүхдүүдийн тал нь ахин гэмт хэрэг үйлдэж байгаа нь онцгой анхаарал татаж байна. Ер нь хүүхдийг хорих ялаар удаан хугацаагаар шийтгэх нь “гэмт хэргийн карьер”-ийг ахиулдаг ба ирээдүйд мэргэшсэн гэмт хэрэгтэн бэлтгэх суурийг тавьдаг.

Хорих байгууллагын ажилтан болон сэтгэл зүйч, нийгмийн ажилтан нартай уулзаж ярилцахад “шоронд удаан хугацаагаар байсан хүүхэд эргээд нийгэмд амьдрахад онцгой нөхцөл шаарддаг, энэ асуудал анхаарал хандуулахгүй байгаагаас хүүхдүүд гэмт хэрэг ахин үйлдэж, мэргэшиж байна. Өршөөл үзүүлэх тухай хуулиудын дараагаар хүүхдийн хорих анги хоосордог боловч тун удалгүй 6-8 сарын дотор эргээд дүүрдэг нь энэ хүүхдэд ногдуулж байгаа ялын бодлого гэхээсээ илүү суллагдсан хүүхдүүдэд чиглэсэн ямар ч ажил хийгдээгүйтэй шууд холбоотой” гэж дүгнэж байв.

Хүүхдээс давтан гэмт хэрэг үйлдэж байгаа шалтгаан, нөхцөлийг судлан үзэхэд:

- 1) Хорихоос суллагаад очих газаргүй, орон гэргүй,
- 2) Эцэг, эх нь өрхийн орлого байхгүй, амьдралын баталгаажих түвшингээс доогуур амьдралтай,
- 3) Ажил, сургуульд орох гэхэд иргэний бичиг баримтгүй, сургууль завсардсан, мэргэжил, боловсролгүй. Өөрөөр хэлбэл тэднийг нийгмийн зүгээс хүлээн авах бэлтгэл хангагдаагүй, нийгмийн хүрээлэл нь зөвөөр хүлээж авахгүй байгаа нь дахин гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлдөг.

Иймээс шоронгоос /уг нь хүүхдэд хорих ял ногдуулах нь хамгийн эцсийн арга хэмжээ байх ёстой/ суллагдсан хүүхдэд амьдрах орчин бэлтгэх, түр хугацаанд байршуулах зэрэг онцгой арга хэмжээг авах хэрэгтэй юм.

Манай улсын хувьд гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй хүмүүст нийгмээс тусгаарлахгүйгээр оногдуулж буй хүмүүжүүлэх үр нөлөө бүхий бусад орнуудыг бодвол харьцангуй бага. Энэ нь хүүхдээс үйлдсэн зөрчил, хэргийг тусгайлан шийдвэрлэх процедур манай улсад байхгүй байгаатай холбоотой. Хүүхдийн хувьд нөхөн сэргээх эрх зүйн хандлагыг алхам алхмаар төлөвшүүлж эхлэх нь зүйтэй бөгөөд тэр тусмаа насанд хүрээгүй этгээдэд үйлдсэн гэмт хэргийн шинж чанараас нь хамааран хэрэгтэнд тодорхой биечилсэн хориг хэрэглэлгүйгээр хянан харгалзах /пробац/ албадлага хэрэглэх хандлагыг төлөвшүүлэх хэрэгтэй байдаг.

1. Хүүхдэд чиглэгдсэн хууль зүйн тогтолцоо боловсронгуй болсон боловч олон хүүхэд

⁵⁰ Судлаач Г.Оюунболд. Шоронгоос суллагдсан хүмүүст нийгэмд дасан зохицоход дэмжлэг үзүүлэх бодлого боловсруулах нь. Бодлогын судалгааны тайлан, 2011 он.

баривчлагдах, гэм буруутайд тооцогдох, анх удаа ялихгүй хэрэгт хүндээр шийтгэгдэх байдал их гарч байгааг анхаарч хууль зүйн хэрэгжилтийн орчныг бүрдүүлэхэд анхаарах

2. Хүүхдийн эрхийг хамгаалах болон эрүүгийн хэрэгт холбогдон шалгагдаж буй хүүхдийн эрхийг хангуулах талаарх Монгол улсын нэгдэн орсон олон улсын гэрээний зүйл заалтуудыг хэрэгжүүлж, Хүүхдийн хорих ангийн чиг үүрэг, статусыг өөрчлөн, сургалт хүмүүжлийн чиг үүрэгтэй болгох асуудлыг шийдвэрлэх /Хүүхдийн хорих байгууллага гэсэн нэрээс авахуулаад хүүхдэд гэмт зан төлөв бүрдүүлдэг орчин бүрдүүлэхгүй байхад чиглэсэн байх/
3. Тогтоол биелүүлэхийг хойшлуулсан насанд хүрээгүй этгээдийг дахин гэмт хэрэг зөрчил үйлдүүлэхгүй хүмүүжүүлэхийн тулд шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулахдаа уг этгээдийн ар гэрийн байдал, амьдралын түвшин, өрхийн орлого, учруулсан хохирлоо нөхөн төлсөн байдал зэргийг харгалзан шүүхээс тогтоосон хянан харгалзах хугацаанд дүйцүүлэн албадан ажил хийлгэхээр хуульчилж болох юм.

Хүүхдийн төлөө ажилладаг олон төрийн ба төрийн бус байгууллагууд анхаарлаа хандуулж гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй этгээдэд хохирлоо нөхөн төлөх, хорих ял биечлэн эдлэхгүйгээр нийгэм, хүмүүсийн дунд хүмүүжихэд нь тусламж дэмжлэг үзүүлж, уг этгээдэд итгэл найдвар хүлээлгэх замаар үйл ажиллагаагаа чиглүүлж ажиллах боломжтой.

Олон улсын туршлага

ОХУ: Ялтныг нийгэмшүүлэх ажил нь хэд хэдэн үе шатанд хуваагддаг. Энэ нь *нийгэм-эрүүл мэндийн, хөдөлмөр мэргэжлийн, эрх зүйн, сэтгэл заслын, ахуй-нийгмийн* гэж хуваагддаг. Эдгээр нь тус бүртээ өөрийн гэсэн нийгэмшүүлэх тодорхой аргатай байдаг.

Эдгээр нийгэмшүүлэх ажлыг амжилттай, үр дүнтэй болгохын тулд үе шаттай байх, бүрэн дүүрэн байх, залгамж холбоотой байх, үр дүнтэй байх зарчмуудыг баримтлахаас ихээхэн хамаардаг. Мөн нийгэмшүүлэх ажиллагааг явуулахдаа сайн дурын болон үүргийн, үнэ төлбөргүй болон хүртээмжтэй зарчмыг баримтлан энэ төрлийн үйлчилгээ зайлшгүй хэрэгцээтэй байгаа хэсэгт (тухайлбал, ганц бие эх, өндөр настан, тэтгэврийнхэн, хөгжлийн бэрхшээлтэй болон өвчтэй хүмүүс, ажилгүйчүүд, шилжин суурьшигсад, дүрвэгсэд) хүрч үйлчилдэг.

Энэхүү олон талт нийгэмшүүлэх ажил нь засан хүмүүжүүлэх газар эхэлдэг бөгөөд үүнд хамрагдагсдын хувийн чадавх нь нийгэмд байр сууриа бүрэн дүүрэн олох боломжтой болох хүртэлх хугацаанд хэрэгждэг.

Тусгаар тогтносон улсуудын хамтын нөхөрлөлийн орнуудын хүрээнд “Криминон СНГ” гэсэн бие даасан ашгийн бус байгууллага үйл ажиллагаа явуулдаг. Уг байгууллагын бүтэн нэр нь Хууль зөрчигчдийг нийгэмшүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, Криминон СНГ төв гэдэг бөгөөд 2010 оны 6 дугаар сарын 17-ны өдөр ОХУ-ын Хууль зүйн яаманд бүртгэгдсэн байна. Үүнээс өмнө “Эйбл СНГ” гэдэг буяны сангийн салбар байдлаар үйл ажиллагаагаа явуулж иржээ. Энэхүү байгууллага нь “Криминон” хөтөлбөрийн зорилгод хүрэхийг хүссэн байгууллага, аж ахуйн нэгж, сайн дурынхныг нэгтгэж байдаг. Уг хөтөлбөрийн зорилго нь гэмт хэргээс ангид аюулгүй нийгмийг бий болгох, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, ялтныг нийгэмшүүлэх юм. Хөтөлбөрийн хүрээнд “Криминон-Новосибирск”, “Криминон-

Надежда”(Украин), “Криминон-Урал”(Екатеринбург), “Криминон-Уфа” гэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Мөн Санкт-Петербург, Москва, Самара, Барнаул зэрэг хотуудад зайны сургалтын сүлжээ ажилладаг байна.

ОХУ-д “Криминон” хөтөлбөр нь 1996 оноос хэрэгжиж байгаа бөгөөд “Аз жаргалд хүрэх зам” нэрийн дор явуулсан туршилт хөтөлбөрийг Шахов дахь засан хүмүүжүүлэх газар /1996-1997/, Оренбург муж дахь эрэгтэйчүүдийн чанга дэглэмтэй хорих ангид /1999-2000/ тус тус явуулсан байна. Туршилтын багийг 55 ялтнаас бүрдүүлж байсан бөгөөд сургагч нар шууд газар дээр нь ажиллажээ.

Хөтөлбөр болон нэмэлт сургалтыг амжилттай төгссөн ялтнууд хөтөлбөрийг бусдадаа зааж сургах туршлага өргөжиж байгаа бөгөөд Челябинск болон Омск дахь хорих ийм маягаар сургагч багш бий болсон байна.

2010 оны 2 дугаар сарын 17-ны өдөр ОХУ-ын Холбооны бүгд хурлаас “Ял эдлэгсдийг нийгэмшүүлэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох тухай” тогтоол гарсан байна. Үүнд ял эдэлж байгаа болон хорих ял эдлээд суллагдсан этгээдийг эргэж нийгмийн хэвийн амьдралд оруулах нь төрийн болон эрүүгийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, иргэний нийгмийн чухал асуудал гэдгийг онцлоод, сүүлийн жилүүдэд эрүүгийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудад ялын альтернатив бодлого болон аливаа шийтгэлийг энэрэнгүй ёсонд нийцүүлэх чиглэл баримтлах хэрэгтэйг дурджээ. Мөн сүүлийн 10 жилийн хугацаанд 3 сая хүн хорих ял эдлээд суллагдсан ба гэмт хэргийн 35 хувийг онц аюултай гэмт хэрэг эзэлж байгааг дурдсан байна.

Герман: Ял эдлээд дууссаны дараа эргээд нийгэмд ороход нь туслах зорилгоор болон нийгэмтэйгээ адил хөгжих хүний эрхийг хүндэтгэх үүргээ биелүүлэхийн тулд Герман улс нь ял эдэлж байгаа хүмүүст тусгай боловсрол эзэмших янз бүрийн арга хэмжээг зохион байгуулдаг бөгөөд өөрөө хөгжих, эргээд нийгэмд орох зэрэгт байнга бэлддэг. Ялаа эдэлж дууссаны дараа ялтан нь сурсан боловсролоороо “*Ажил олгох газар*”-т бүртгүүлэх бөгөөд хорих ял эдлээд суллагдсан хэнд боловч үйлчилдэг. Ажил эрхлэх чадвараас нь хамаараад тохирох ажлыг нь хайх бөгөөд боломжгүй бол нөхөн олговор олгодог. Ажилгүйдлийн мөнгө нь хамгийн багадаа 400 орчим еврогоос эхлэн олгодог. Мөн энэ хугацаандаа тухайн хүний ажил эрхлэхэд нь саад болж буй бэрхшээлийг алга болгохын тулд сургалт, арга хэмжээ зохион байгуулдаг ба үүнд оролцох эрхтэй байдаг. Хүүхэд боловсрол эзэмшиж амжаагүй байдаг учраас шүүхээс ял ногдуулахдаа боловсрол эзэмшүүлэхэд нь таслахгүй байх, нийгмээс нь хөндийрүүлэхгүй байхад нь хамгийн ихээр анхаардаг. Тиймээс “*насанд хүрээгүйчүүдэд туслах төв*” гэж төрийн байгууллага байдаг бөгөөд энэ нь гэмт хэрэгт холбогдсон цагаас эхлэн хүүхдийн эрх ашгийг хамгаалдаг бөгөөд шийдвэрлэгдээд дууссан ч тэр хүүхдийг нийгэмд байр сууриа олтол нь тусалж дэмждэг.

Германд ялтныг нийгэмшүүлэх чиглэлээр тусгайлан бэлтгэсэн мэргэжилтнүүд ажилладаг бөгөөд насанд хүрсэн хүн, хүүхдэд хүртэл ялгаатай сурган хүмүүжүүлэгч, сэтгэл зүйч, мэргэжилтнүүд үйлчилдэг. Өөр нэг чухал зүйл нь *Ausbildung* /мэргэжил олгох сургалт-их дээд сургуулиар олгох шаардлагагүй, сургалт үйлдвэрлэлийн төв/ тогооч жолооч, даатгалын ажилтан, мужаан, слесарь гэх мэт мэргэжил олгодог байна. Эдгээрийг санал болгосон байгууллагуудад хүргүүлдэг бөгөөд үүнийг хорих анги болон өөр төрлийн ял эдэлж байгаа хүмүүсийн дунд зохиодог төдийгүй суллагдсан хүнд ч хамааралтай байдаг байна. Энэ нь

энгийн амьдарлаа цааш нь хэвийн үргэлжлүүлэхэд нэлээд чухал үүрэгтэй байдаг бас баталгаа болдог байна.

Энэ бүгдээс харвал Герман улсад хүний эрхийг өндөрт тавьж үздэг төдийгүй ял эдлэх нь тухайн гэм буруутай үйлдэлд нь оногдуулах арга хэмжээ бөгөөд үүнийг цааш нь хэтрүүлэн хэрэглэж болохгүй гэж үздэг. Жишээ нь: хорих ял эдэлж байгаа хүн нийгмээс тусгаарлагдсан байрандаа бүх эрхээ эдлэх боломжтой байдаг. Герман улсад иргэний нийгмийн баталгаа нь ял эдэлсэн хүнд ч үйлчилдэг. НҮБ-ын Хүний эрхийн дүрмүүд ялантай харьцах наад захын жишиг дүрмийн заалтуудыг бараг бүгдийг хуульдаа ч, амьдралдаа хэрэгжүүлж чадсан байна.

4.7. ЯРИЛЦАХ СЭДЭВ БА ХЭЛЭЛЦЭХ КЕЙС:

1. Хүүхэд ямар учир шалтгаанаар/үндэслэлээр/ байцаан шалгах ажиллагаанд зайлшгүй оролцох субъект болдог вэ? /Гэмт хэрэг, зөрчилд холбогдсон байж болзошгүй байх бөгөөд 14 нас хүрсэн учир гэх мэтээр ярилцах/
2. Хүүхэд байцаан шалгах, шүүн таслах ажиллагаанд оролцох үед тэдний эрх зөрчигдөх явдал гарч байсан уу? Эсхүл гарах эрсдэл байна уу?/өмгөөлөгчгүй байцаалт явуулах, хууль ёсны төлөөлөгч болон асран хамгаалагчийг оролцуулаагүй гэх мэт/
3. Хүүхдийн эрх зөрчигдсөн бол субъектив хүчин зүйлийн ямар нөлөөлөл байсан бэ? Эсхүл ямар субъектив эрсдэл зөрчил үүсэж болох вэ? /байцаан шалгагч талын зан харилцаа, мэдлэг, туршлага, ёс зүйн асуудал, өмгөөллийн үйлчилгээний сэтгэл ханамж гэх мэт/
4. Хүүхдийн эрх зөрчигдсөн бол объектив хүчин зүйлийн ямар нөлөөлөл байсан бэ? Эсхүл ямар объектив эрсдэл зөрчил үүсэж болох вэ? /Байр танхим, өрөө тасалгааны зохион байгуулалт, техник хэрэгслийн хангалт, тав тухтай байдал, хуулийн хатуу заалт эсхүл хууль хоорондын зөрчилт байдал, давхцал, хийдэл гэх мэт/
5. Хуулийн байгууллагын хүрээлэлд орж ирсэн хүүхдийн хамгаалагдах эрх болон хамгааллын талаар бид юу хийж болох вэ?/Олон улсын гэрээ, стандарт дүрэм журамд нийцсэн шинэ хуулиудыг яаралтай батлуулж мөрдөх, зарим өөрчлөлт оруулах, журам шинээр гаргах, хууль зүйн хороог сайн ажиллуулах, өрөө танхим бий болгох, төсөв хөрөнгө гаргах гэх мэт/
6. Мөрдөн шалгах болон шүүн таслах ажиллагааны бүх процесст байнга оролцох эрхтэй субъект хэн бэ? Түүний эрх ямар хуулийн ямар зүйл заалтаар хуульчлагдсан бэ?/ өмгөөлөгч, хууль ёсны төлөөлөгч гэх мэт/
7. Сэжигтэн ба яллагдагч, хоригдол ба хорихоос суллагдсан хүүхдийн эрх зүйн байдал ямар байна вэ?/Тэдний эрх ашгийг хамгаалсан хууль тогтоомжууд байгаа эсэх, байгаа бол хэрэгжилт ямар байгаа, сайжруулах ямар шаардлага байгаа талаар/
8. Гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн жендэрийн эрх тэгш байдал хэрхэн хангагдаж байна вэ? /жендэрийн хэрэглээ ба хэрэгцээ хэрхэн хангагдаж буй тухай, эмэгтэй, эрэгтэй хүүхдийн хүйсийн болон сэтгэл зүйн ялгаатай байдлыг хүндэтгэж, эрх тэгш хандаж буй эсэх/

Төрсөн эгч дүү болох 14 настай А, 15 настай Б нар хоорондоо зодолдож бие биедээ хүнд гэмтэл учруулжээ. Энэ явдлаас болж аав нь А-ын, ээж нь Б-ын хууль ёсны төлөөлөгчөөр оролцоно гэсэн хүсэлтээ мөрдөгчид хэлжээ. Эхнэр, нөхөр хоёр гэр бүлээ цуцлуулаагүй хамт

амьдардаг боловч хүүхдүүдээсээ болоод хоорондоо маргалдсан байдалтай байна.

Хууль ёсны төлөөлөгчийг хэрхэн шийдвэрлэх вэ?

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн улмаас нас барсан 12 настай А нь ээжээрээ овоглодог боловч төрсөн эцэгтэйгээ амьдардаг. А-г 3 настай байхад нь ээж нь салаад өөр хүнтэй гэр бүл болон амьдардаг.

Гэмт хэргийн яллагдагч хохирол, гэм хороо нөхөн төлөхөөр шийдвэрлэж 50 сая төгрөгийг мөрдөгчид өгчээ. А-ын төрсөн ээж төрсөн эцгийг нь түүний эцэг биш учир хууль ёсны төлөөлөгчөөр оролцох хүсэлт гаргажээ. Хохирогчийн аав нь түүнийг үл зөвшөөрчээ.

Хэрхэн шийдвэрлэх вэ? .



ХҮҮХДИЙН ЭРХИЙН ХУУЛЬ ЗҮЙН ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АРГА ЗҮЙ

Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагааны арга хэлбэр

Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо нь хамрах хүрээний хүүхдэд чиглэсэн үйлчилгээг хууль, журамд заасны дагуу үзүүлж байгаа ч тэдгээр хүүхэдтэй ажиллах нийгмийн ажил буюу нийгэмшүүлэх, сөрөг дадал хэвшлээс нь хөндийрүүлэх, авьяас ур чадварыг нь илрүүлэн хөгжүүлэх, дэмжих, гэр бүлд нь, хамт олонд нь түшиглэсэн үйл ажиллагааны арга хэлбэр, арга зүй дутмаг байна.

5.1. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хүүхэд, өсвөр үеийг гэмт үйлдлээс урьдчилан сэргийлэх, гэмт үйлдэлд хохирсон, оролцсон үед тэдгээр хүүхэдтэй холбоотой хянан шийдвэрлэх ажиллагааны үед оролцогч хүүхэд бүрийн эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангах зорилгоор хандах хэрэгцээ байна.

Ерөнхий төлөвлөлт, төлөвлөгөө

Хууль зүйн хороо хүүхэд, өсвөр үеийг гэмт үйлдлээс урьдчилан сэргийлэх ажил, үйлчилгээгээ шинэчлэн найруулсан “Монгол Улсын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хууль, Хүүхдийн хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр/2017-2021 он/, уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу төлөвлөж ажиллана.

Уг төлөвлөлтөд “гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил нь гэмт хэрэг, зөрчлийн тухай мэдээллийг судалсны үндсэн дээр гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхэд нөлөөлж байгаа шалтгаан, нөхцөл, хүчин зүйлсийг тогтоож, түүнийг арилгахад чиглэсэн эдийн засаг, нийгэм, эрх зүйн болон зохион байгуулалтын бусад арга хэмжээний нийлбэр цогц мөн”⁵¹ гэж хуульд заасныг эш үндэс болгож, хүүхдийн эсрэг болон хүүхдээс үйлдэж буй гэмт хэрэг, хүүхэд оролцсон, холбогдсон зөрчлийн тухай мэдээллийг судлан эдгээр гэмт үйлдлийн шалтгаан, нөлөөлж буй хүчин зүйлийг тогтоох, арилгахад чиглэсэн арга хэмжээг тусгана.

Сайтар боловсруулсан төлөвлөгөөг хэрэгжүүлж, үр дүнг үнэлэх замаар ажлаа зохион байгуулах нь зүйтэй юм.

Тэргүүлэх чиглэл, зорилго, зорилтууд

Урьдчилан сэргийлэх ажлын нийтлэг зорилго нь аюулгүй байдлыг хангах, хүний эрх, эрх чөлөө, төр, хуулийн этгээдийн хууль ёсны ашиг сонирхлыг гэмт халдлагаас хамгаалах, нийгмийн дэг журмыг бэхжүүлж, иргэний ухамсар, соёлыг төлөвшүүлэхэд чиглэдэг.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх; гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил цогц, тогтвортой, уялдаа холбоотой байх; төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэр гэмт хэрэг, зөрчил гарах

51 Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль./Шинэчилсэн найруулга/, 2019 он.

шалтгаан, нөхцөлийг бүрдүүлэхгүй байх; гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэгжүүлэх арга хэмжээ судалгаа, шинжилгээ, шинжлэх ухаан, техник, технологийн орчин үеийн ололт, амжилт, шинэ мэдлэгт үндэслэсэн байх; зардал, үр өгөөжийн хувьд үндэслэлтэй байх; олон нийтийн оролцоонд түшиглэсэн, хэрэгцээ, шаардлагад нь нийцсэн байх зарчмуудыг баримталж, төрийн захиргааны болон хууль сахиулах байгууллага үйл ажиллагаандаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг тэргүүлэх чиглэл болгодог.

Нийтлэг зорилго, зорилтуудын хүрээнд хүүхэд хэмээх тусгай хамгаалалт шаардагддаг субъектийн хувьд нэгдмэл бодлогоор тэдний хөгжлийн онцлог, ирээдүй, хувийн байдал зэргийг хүндэтгэх, хүүхдэд хэрэгтэй мэдээлэл, мэдлэг өгч үйлчлэх, олон нийтийн ойлголт, хандлагыг нэмэгдүүлэхэд анхаарах;

Харин *тусгай зорилтуудын* хүрээнд хүүхдэд шударга хандах, хэргийг нь шуурхай шийдвэрлэх, хүүхдэд хэрэглэх арга хэмжээ нь ямагт тэдний байдалд тохирсон байх, ажилтан, мэргэжилтнүүдийг сургах, удирдамж заавраар хангах, гэрч, хохирогчийн онцгой хэрэгцээг хүндэтгэж даван туулахад нь туслах, нийгмийн шударга ёс зөрчил үйлдэгч, гаргагчийн эрх ашгийн хооронд зүй зохистой харьцааг хангах асуудлыг анхаарах шаардлагатай.

Үндсэн зарчмууд

Үйл ажиллагааны үндсэн зарчмууд нь хувь хүний онцлогийг хүндэтгэх, жендэрийн эрх тэгш байдлыг хангах, ХЭТК ийн суурь 4 зарчмыг хэрэгжүүлэх; урьдчилан сэргийлэх, хохирлыг барагдуулах арга хэмжээг үр дүнтэй, идэвхтэй хэрэгжүүлэх, хангалттай нөөц (хүн хүч, байгууллага, технологи, эдийн засаг, мэдээлэл)-ийг бүх шатанд үр ашигтай бүрдүүлж, бүх талууд хамтран ажиллах явдал байна.

Мэдээлэл, судалгаа шинжилгээ

Урьдчилан сэргийлэх талаар үр нөлөөт судалгаа явуулах түүний үр дүнг түгээх, үнэлэх, жендэрийн мэдрэмжтэй мэдээллийн эх сурвалж бий болгох, мэдээлэл солилцох механизмыг бүрдүүлэх, үйл ажиллагаандаа хяналт үнэлгээ хийх замаар мэдээлэл, менежментийн тогтолцоог боловсронгуй болгоход анхаарч ажиллавал зохино.

Урьдчилан сэргийлэх ажил, үйлчилгээний зарим арга хэлбэр

Урьдчилан сэргийлэлт бол хүүхдийг аливаа эрсдэл, хүчирхийллээс хамгаалахад чиглэгдсэн мэдлэг, хандлага, чадвар эзэмшүүлэх үйл ажиллагаа юм. Өөрөөр хэлбэл тодорхой, таамаглаж болохуйц асуудал, бэрхшээлийг багасгах, эдгээрээс урьдчилан сэргийлэх, одоогийн сайн сайхан байдлаа хамгаалах, хүссэн үр дүн эсвэл зан үйлийг бий болгохыг дэмжиж байдаг арга, үйл ажиллагаа гэж болно. Товчлон хэлбэл хүүхдийг хууль зөрчих, эрсдэлд өртөхөөс хамгаалахад чиглэсэн нөлөөллийн үйл ажиллагаа билээ.

Иймд хүүхэд өсвөр үеийг бие даасан, анхаарал халамжтай, бусдын болон өөрийнхөө өмнө хариуцлага хүлээх чадвартай, зорилго тэмүүлэлтэй, бүтээлч, хувь хүнийг нийгмийн гишүүнийх нь хувьд бүх талаар хөгжиж, төлөвшихөд нь чиглэсэн тэдний насны онцлог, чадварт нь үндэслэн боловсруулсан хөгжлийн жишиг хөтөлбөр гарган хэрэгжүүлэх шаардлагатай байна. Уг хөтөлбөр хэрэгжсэнээр Монголын хүүхэд, өсвөр үеийнхний хөгжил,

төлөвшилд чанарын ахиц өөрчлөлт гарч, дэлхийн хүүхэд, залуустай мөр зэрэгцэн алхах боломж нэмэгдэх болно. Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, хүүхэд оролцсон гэмт хэрэг буурна.

Хүүхдүүд хамтран гэрэлгүй гудамжны тоо гаргах, хүүхдүүдийн дунд гэмт үйлдэлд өртсөн эсэх судалгаа явуулж үр дүнг илтгэх, халдлагаас өөрийгөө хамгаалах талаар сургалт зохион байгуулах, бие хамгаалах секц, дугуйланд хамрагдах хөдөлгөөн өрнүүлэх, Өсвөрийн цагдаа, “Шерлок Холмсын бүлэг” байгуулан ажиллах, 5-15 насныханд “My craft” цахим тоглоомын, 16-аас дээш насныханд цахим спортын төрлүүдээр уралдаан, тэмцээн зохион байгуулах зэрэг хууль ёсны “хяналт”, дэмжлэгтэй тодорхой, бүтээлч ажлууд хийж болно. Ер нь гэмт хэргийн хохирогч, гэрч, сэжигтэн, яллагдагч, ял эдэлж байгаа, ялаас чөлөөлөгдөж, суллагдсан насанд хүрээгүй хүн бол хүүхэд юм. Хүүхэд л учраас тэд бусад хүүхдийн адил тоглох, наадах, сурч хөгжих, санал бодлоо илэрхийлэх, хуулиар хязгаарлагдаагүй бол нийгэм, хамт олны амьдралд оролцох эрхтэй. Тэдэнд өөрийгөө нээж таних, чадвараа хөгжүүлэх, нийгэм хамт олондоо байр сууриа эзлэх, бусадтай харилцах зэрэг нийгэмшихүйн хэрэгцээ чухлаар тавигддаг. Иймээс энэхүү хэрэгцээг хангахад чиглэсэн зарим ажлын арга хэлбэрийг товч авч үзье.

Урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээх үйл ажиллагаа нь тухайн хүүхдийн оролцоонд тулгуурлан түүний хөгжил, төлөвшилд эергээр нөлөөлөхүйц олон талт арга хэмжээ бүхий цогц хөтөлбөр юм.

Харин үйлчилгээ нь тухайн хүүхдэд нэн даруй шаардлагатай байгаа хэрэгцээ юм. Энэхүү хэрэгцээ нь эрүүл мэндийн, сэтгэл зүйн, нийгмийн халамжийн, эрх зүйн, аюулгүй байдлаа хангуулах, хамгааллын үйлчилгээ авах гэсэн төрөлтэй байж болно. Үйл ажиллагаа болон үйлчилгээ хослон явагдах нь үр дүнтэй.

5.2. НИЙГЭМШИХҮЙН ЧИГЛЭЛЭЭР ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АРГА ХЭЛБЭР:

Сэжигтэн, яллагдагч, хорихоос өөр төрлийн ял шийтгэгдсэн, сургалт хүмүүжлийн тусгай байгууллагаас суллагдсан хүүхдэд зан үйлээ засах, өөрчлөх, өөрийн ажил амьдралдаа эерэг зөв аргаар бүтээлч хандах, нийгмийн амьдрал, хамт олныхоо дунд дасан зохицоход туслах зорилготой олон төрлийн үйл ажиллагаа зохион байгуулах боломжтой юм. Тэд ихэвчлэн сэтгэл зүйн хямралтай, нийгэмд эзлэх байр сууриа алдсан, гэр бүл төрөл төрөгсдийн хоорондын харилцаа хөндийрсөн, бусад хүүхэд, найз нөхөдтэйгөө харилцахад бэрхшээлтэй болсон байдаг. Тиймээс тэдэнд өөрийн болон бусдын мэдрэмжийг ойлгох, нийгэмд хүлээн зөвшөөрөгдөхөд нь чиглэгдсэн дараах интервенцүүдийг хэрэгжүүлж болохоор байна.

- Үйлчлүүлэгчийг мэдрэмжээ хуваалцахад нь туслах. Уураа барьж сургах, сэтгэл хөдлөлөө зөвөөр илэрхийлэх, стрессийг бууруулах аргуудыг ашиглана.
- Мэдээлэл өгөх зөвлөгөө. Тодорхой хугацаанд нийгмээс тусгаарлагдсан хүүхдийн хувьд өөрийгөө хэн болохыг ойлгох, ирээдүйд амьдралаа авч явахад нь туслахуйц мэдээллийг өгнө. Тухайлбал хичээл боловсролыг ямар хэлбэрээр, хаана яаж үргэлжлүүлж болох, ямар мэргэжил сонгох, аль дугуйлан секцэд хамрагдах, оршин суух сум дүүргийнхээ иргэний бүртгэлд бүртгүүлэх, мэргэжил олгох сургалтад хамрагдах талаар.
- Шийдвэр гаргахад туслах. Бусдын нөлөөнд автсан, бусдын үгийг сонсдоггүй,

тэвчээргүй, биеэ барих чадваргүй, хүчирхийлэл бүхий орчинд өсч торнисон, үл хайхрах хүчирхийлэлд өртөж байсан, тодорхой хугацааны туршид хорихын дүрэм хуваарьт дасан зохицсон байдгаас өөрөө бие даан шийдвэр гаргахад бэрхшээлтэй тулгардаг. Мөн нөгөө талаас мөрдөн байцаалтын болон шүүх ажиллагааны явцад, шүүхээс ял авсны дараа, эсхүл суллагдсаны дараа олон асуудал дээр янз бүрийн шийдвэр гаргах хэрэгтэй болдог.

- Үйлчлүүлэгч өөрийн нөхцөл байдлаа тодорхойлоход нь нийгмийн ажилтан, хууль ёсны төлөөлөгч, сэтгэл зүйч, хүүхдийн эрхийн ажилтан бүх талаар тусална.
- Үйлчлүүлэгчийн орчныг өөрчлөхөд дэмжлэг үзүүлэх, шаардлагатай нөөц боломжуудтай холбож, зуучилж өгөх.
- Өөрийн зан үйлээ өөрчлөхөд нь туслах. Эдгээр чиглэлүүдийг хэрэгжүүлэхэд тус дэм болох, санаа сэдэл өгөх зорилгоор дараах ажлын арга, хэлбэрүүдийг хэрэглэж болох байна.

“Бид чадна” хөгжлийн хөтөлбөрийн аргачлал

Уриа: Бид шинэ ертөнцийг нээнэ.

Зорилго: *Хүүхэд өсвөр үеийг зорилго тэмүүлэлтэй, бие даасан, бүтээлч, бусдын болон өөрийнхөө өмнө хариуцлага хүлээх чадвартай иргэн болж төлөвшихөд шаардлагатай чадваруудыг эзэмшүүлэхэд чиглэгдэнэ.*

Хамрагдах нас: 13-18 насны өсвөр үеийнхэн

Мөрдөх зарчим: Манай баг бол миний эрх, эрх чөлөөний орон зай.
Миний эрх, бусдын эрхээр хязгаарлагдана.

Анхааруулга: Эзэмших чадварын дарааллыг баримтлах, нэг багц чадварыг бүрэн дуусгасны дараа дараагийн чадвар луу шилжинэ. Гэхдээ багийн гишүүд хамтдаа байх ёстойг анхаар.

Өөрийгөө илэрхийлэх чадвар:

Суурь ойлголт: Энэ чадвар танаас сэтгэл хөдлөл болон өөрийгөө удирдах ур чадварыг шаардана. Өөрийн сэтгэл хөдлөл, сэтгэхүйн мэдрэмжээ зөв илэрхийлж сурах нь таны нийгэмд эзлэх байр суурь, үзэл бодол, зан чанарын төлөвшилд чухал нөлөө үзүүлнэ. “Emotional intelligence” номын зохиогч Дэниэл Гоулман “Өөрийнхөө сэтгэл хөдлөлийг удирдах, бусдын сэтгэл хөдлөлийг ойлгох нь амжилтад маш их нөлөө үзүүлдэг” хэмээснийг санаж яваарай.

Бидний амьдарч буй энэ нийгэм нь хүний бүх талын хөгжил, ялангуяа харилцах урлагийг ихээхэн үнэлдэг болоод байгаа. Нийгмийн харилцааны оюун ухаан гэгддэг EQ (Emotional quotient) – сэтгэл хөдлөлийн чадамж нь өөрийн болон бусдын сэтгэлийн хөдөлгөөнийг ойлгох, сэтгэл хөдлөлөө зохистой илэрхийлэх, өөрийгөө урамшуулах, тэвчээртэй байх, үргэлж сэтгэл өөдрөг явах зэрэг цогц чадварыг харуулдаг. EQ өндөртэй хүн өөрийнхөө сэтгэлийн дотоод хөдлөлд автахгүй биеэ барих чадвар эзэмшсэн байх бөгөөд орчинтойгоо зохицон, ажил, амьдралаа амжилттай явуулж байдаг.

Энэ шаардлагыг хангахын тулд та янз бүрийн арга хэлбэрээр тухайлбал, зургаар, дохиогоор, тэмдэгтээр, мессежээр, захидлаар, үгээр, биеийн үйлдлээр, асуултаар, дүрсээр, өнгөөр, хувцаслалтаар гэх мэтээр өөрийгөө илэрхийлж болно. Та өөрийгөө илэрхийлэх чадварт суралцахын тулд дараах туршилтуудыг хийгээд үз.

Бэлтгэх зүйл:

- Хүүхдүүдийг 4-5 хүний бүрэлдэхүүнтэй хэд хэдэн багт хуваана.
- Оролцогч хүүхдүүдэд суурь ойлголт гэсэн хэсгийг багш тайлбарлаж өгнө.
- Багийн гишүүдийн сонгох өнгийг дэлгэцээр эсхүл өнгийн цаасаар бэлтгэх
- Сонгох хөгжмийн фонд бүрдүүлсэн байна.

Таны хийх зүйл:

- Өгөгдсөн олон өнгөнөөс сонголт хийж, яагаад энэ өнгийг сонгосноо олон талаас нь тайлбарлана уу.
- “Би чамд хайртай. Хэзээ, хаана уулзах вэ?” гэсэн өгүүлбэрийг үг үсэг, цифр оруулахгүйгээр бүтээнэ үү.
- Та хэн бэ? Та өөрийгөө хөгжмийн хэлээр илэрхийлнэ үү. Та өөрийгөө илэрхийлж чадах ямар нэгэн хөгжим, аялгуу сонгож найз нөхдөдөө танилцуулж ярина.

Таныг хамгийн шударга үнэлэгч бол та өөрөө. Та өөрийгөө үнэлнэ үү.

Үнэлгээний загвар:

Хийх зүйлийн дугаар	Хийсэн эсэх		Таны үнэлгээ			Та өөртөө яагаад “...” үнэлгээ өгснөө товч, тодорхой бичнэ үү.
	Тийм	Үгүй	А	В	С	
а	✓				✓	Би яагаад тэр өнгийг сонгосноо сайн илэрхийлж чадаагүй тул гэх мэт
б	✓		✓			Яг өгөгдлийн дагуу хийж чадсан.
в	✓			✓		Бичсэн амьтныхаа таалагддаг шинжийг яагаад тэр шинж нь таалагддаг шалтгааныг бичээгүй
г	✓		✓			Миний сонгосон хөгжим найзуудад минь таалагдсан.
д	✓			✓		Энэ эссэгээр би өөрийгөө бүрэн илэрхийлж арай л чадаагүй

Таны үнэлгээ:

Хийх зүйлийн дугаар	Хийсэн эсэх		Таны үнэлгээ			Та өөртөө яагаад “...” үнэлгээ өгснөө товч, тодорхой бичнэ үү.
	Тийм	Үгүй	А	В	С	
а						
б						
в						
г						
д						

Та чадлаа. Танд баяр хүргэе. Таныг дараагийн чадварт суралцахыг урьж байна.

Харилцааны ур чадвар:

Суурь ойлголт: Энэ нь бусад хүмүүстэй зөв боловсон харилцах, тэдэнтэй үр дүнтэй хамтран ажиллах, нийгэмд хэрэгтэй бүтээлч байх чадвар юм. Өөрөөр хэлбэл харилцах, хамтран ажиллахыг хослуулах чадвар билээ. Та өөрийн дотоод мэдрэмжээр бусдын зан авирыг таньж мэдэх, сэтгэл хөдлөлийн хариу үйлдлээ зөв илэрхийлснээр нийгмийн харилцааны ур чадварыг эзэмших суурь тавигдана. Хувь хүний нийгмийн харилцааны хөгжил нь тэдний бусад хүмүүстэй харилцах, хамтран ажиллах дадал, чадварыг хэр зэрэг эзэмшсэн байдлаар илэрхийлэгддэг байна.

Ажлын амжилт, эцсийн үр дүн нь хүмүүсийн хамтын ажиллагаатай салшгүй холбоотой билээ. Хүмүүс бие биеийнхээ давуу талыг мэддэг төдийгүй аливаа нөхцөл байдлын өөрчлөлтөд уян хатан зохицож ажиллах чадварыг тэдний хоорондын халуун дулаан харилцаа, бусдыг сонсох, хүлээцтэй хандах чанар л олгодог байна.

Харилцааны ур чадварт суралцахын тулд эхлээд сонсох, унших, бичих, ярих, илтгэх гэсэн харилцан хамаарал бүхий харилцааны ерөнхий чадваруудыг эзэмших шаардлагатай байдаг байна. Ингэснээр та харилцах ур чадварын далайд сэлүүрээ тавьж, үгээр, биеэр, үйл хөдлөлөөрөө бусдыг татах илтгэхүйн урлагт суралцах болно.

Алдаагүй илтгэх 10 арван санамж

1. Илтгэх сэдвээ сайтар боловсруул
2. Өөртөө итгэлтэй бай
3. Илтгэх зорилгоо мэд
4. Ярих нөхцөл байдлаа тогтоо
5. Танхимын талаарх мэдээллийг/хэн таныг сонсож байгаа тухай/ цуглуул
6. Илтгэлийн бүтцээ зөв тавь
7. Илтгэх арга барилд суралц
8. Ярих техник эзэмш
9. Үгээ зөв сонго
10. Илтгэх үедээ биеийн хэлэмжийг/дохио зангаа, үйл хөдлөлөө/ чөлөөтэй хий

Та харилцааны ур чадвар эзэмшсэн уран илтгэгч болмоор байна уу? Яагаад болохгүй гэж. Тэгвэл дараах үйлдлүүдийг хийгээд үз.

Бэлтгэх зүйл:

- Хүүхдүүдийг 2-3 хүний бүрэлдэхүүнтэй хэд хэдэн багт хуваана.
- Оролцогч хүүхдүүдэд суурь ойлголт гэсэн хэсгийг багш тайлбарлаж өгнө.
- Багийн гишүүдийн сонгож сугалах кино болон жүжгийн текстийг бичиж бэлдсэн байх/нэг багт 2-3 төрлийн текст байвал зохино/

Таны хийх зүйл:

- Багийнхаа нэг гишүүний өөрт нь тохиолдсон явдал эсхүл уншсан ном, үзсэн киноных нь тухай яриулж, сонсоод хэлсэн зүйлийн талаар утга санаа, дарааллыг алдагдуулахгүйгээр бичиж тэмдэглэ. Тэмдэглэсэн зүйлээ уншиж өгөөд харилцан ярилц. Энэ дасгалыг 2-3 удаа өөр өөр найзуудтайгаа хийх нь улам үр дүнтэй хөгжилтэй байх болно.
- Багийн гишүүд сонгосон сэдвийг уншин цээжлээд харилцан ярилцах маягаар зохиолын дүрүүдийг бүтээнэ. Энэ дасгалыг 2-3 удаа хийнэ.

Таныг хамгийн шударга үнэлэгч бол та өөрөө. Та өөрийгөө үнэлнэ үү.

Үнэлгээний загвар:

Хийх зүйлийн дугаар	Хийсэн эсэх		Таны үнэлгээ			Та өөртөө яагаад "... " үнэлгээ өгснөө товч, тодорхой бичнэ үү.
	Тийм	Үгүй	А	В	С	
а						Би найзуудынхаа /багийнхаа/ ярьсан бүх зүйлийг зөв тэмдэглэж, бүх зүйлийг нь ярьж чадсан.
б						Сэдвийн агуулгыг гүйцэт ярьж чадахгүй, зарим үйл явдал, дарааллыг орхигдуулаад байсан.

Таны үнэлгээ:

Хийх зүйлийн дугаар	Хийсэн эсэх		Таны үнэлгээ			Та өөртөө яагаад "... " үнэлгээ өгснөө товч, тодорхой бичнэ үү.
	Тийм	Үгүй	А	В	С	
а						
б						

Та чадлаа. Танд баяр хүргэе. Таныг дараагийн чадварт суралцахыг урьж байна.

“Би Монгол улсын иргэн”

Зорилго: Монгол улсын иргэн байхын утга учир, үүрэг хариуцлага, эрхийн талаар ойлголт өгч, хүүхэд, өсвөр үеийнхэн бол эх орныхоо хүндтэй иргэн, нийгмийн идэвхтэй гишүүн нь байх ёстой гэсэн бахархал, сэтгэл хөдлөлийг бий болгоно.

Хүүхдүүдийг хүсэлтээр нь эсвэл тоглоомын арга хэрэглэн /өнгө сонгуулах, геометрийн дүрс сугалуулах, ил захидал болон дүрс эвлүүлэх гэх мэтээр/ багуудад хуваана. Баг нь оролцогчдын тооноос хамаарч 8-10 хүртэл гишүүнтэй, 3-5 баг байх нь тохиромжтой. Баг бүрд дараах чиглэлээр даалгавар өгнө. Үүнд:

- Миний эрх, чиний эрх
- Миний үүрэг, хариуцлага
- Монгол улсын төрийн далбааны утга учир, бэлгэдэл
- Монгол улсын төрийн сүлдний утга учир, бэлгэдэл
- Монгол улсын төрийн соёмбын утга учир, бэлгэдэл

Багууд “Дүрд тоглох”, “Зурган өгүүлэмж”, “Зурагт хуудас” /плакат/ бүтээх, ТВ-ийн тойм зэрэг арга, хэлбэрүүдийг ашиглан 10-15 минутад багтаан даалгавраа бэлтгэнэ. Даалгавраа бэлтгэх, бусад багуудын өмнө үзүүлэхэд гишүүн бүр ямар нэг хэлбэрээр оролцсон байх нь чухал. Багуудын бэлтгэсэн зүйлээр сургалтын болон сурталчилгааны материал, шинэ санааны эмхэтгэл хийж болно.

“Хөгжмийн солонго”

Зорилго: Сурагчдад сонгодог хөгжим, урлагийг сурталчилж, тэдэнд гоо зүйн мэдлэг, хөгжмийн боловсрол олгох

Бэлтгэл ажил : Оролцогчдод сонсгох хөгжим, дууны бичлэг, зургийн цаас, харандаа фламастер, усан будаг, гаушь, самбар. Оролцогчдыг хүний тооноос шалтгаалж хэд хэдэн баг болгон хуваасан байна.

Даалгаврын чиглэл:

1. Сонгодог хөгжмийг нийт оролцогчдод сонсгоно. 3-5 минут.
2. Хэний зохиол ямар нэртэй бүтээл болохыг таана. Багууд хариултыг нууцаар бичиж, нэгэн зэрэг самбарт наана.
3. Сонссон хөгжмийн агуулга, өгүүлэмжийг илэрхийлсэн зураг зурж, шүлэг зохионо. Сэтгэгдлээ сурвалжилгаар илэрхийлнэ. /Энэ үед хөгжмийг хэд дахин үргэлжлүүлэн сонсгоно./
4. Багууд дарааллаар зурсан зургаа тайлбарлан, зохиосон шүлгээ уншиж, төрсөн сэтгэгдлээ нийт оролцогчидтой хуваалцана.

Анхаарах зүйл: Хөгжмийн талаар ямар сэтгэгдэл төрсөн талаар, хөгжмийн зохиолч болон уг бүтээлийн түүх, агуулгын талаар нээлттэй ярилцлага өрнүүлж, амжилттай оролцсон хүүхдүүдэд талархал илэрхийлж, зурсан зураг, зохиосон шүлгийг дурсгаж болно.

ТОГЛООМ

Найзын солилцоо

Тоглогчдын тоо: 4-өөс дээш

Ур чадвар:

- Асуудлыг шийдэх
- Ойрхон байх
- Харилцан ойлголт
- Бие биеэ дэмжих

Хэрэглэгдэх зүйлс: Байхгүй

Бэлдэх зүйл: Байхгүй

Тайлбар:

- Тод шулуун шугамтай газар олох
 - Хөл бөмбөгийн талбай
 - Тоглоомын талбай гэх мэт
- Тоглогчид мөр мөрөө зэрэгцэн шугаман дээр жагсана.
- Тоглогчид шугамаас гаралгүйгээр жагсаалын эрэмбийг тонгоруулан өөрчилнө.
- Хэрэв аль нэгэн тоглогч шугамаас гарах эсвэл гараараа газарт хүрвэл уг баг гараанаас дахин эхэлнэ.

Дүгнэлт:

- Тоглоомын юу нь хөгжилтэй байсан бэ?
- Тоглоомын юу нь хэцүү байсан бэ?
- Ямар аргаар тогловол үр дүнтэй байна
- Багаас хэн нэгэн ахлагч болон тоглосон уу
- Энэхүү тоглоом манай багт хэрхэн туслах вэ?

Тайвшрал

Зорилго. Аль ч насны хүүхдүүдтэй ажиллахад ашиглаж болох ба хүүхдүүдийг амраах, аливаа нэг зүйлд анхаарлыг нь төвлөрүүлэхийн өмнө энэхүү дасгалыг хийж гүйцэтгүүлнэ.

Бэлтгэл ажил: Тайвшруулах дасгалыг чимээгүй тайван орчинд хийж гүйцэтгэнэ. Сайн суниаж болох том орон дээр юм уу эсвэл дэвсгэр дээр хэвтэх нь сайн /сууж хийж болно/.

Багш удирдана: Биед тухтай байрлалаа олоод нүдээ ань. Удаан гүнзгий амьсгаа аваарай. Эхлээд биеийнхээ булчинд анхаарлаа хандуул. Булчингуудаа 5-10 секунд чангалаад дараа нь 10-20 секунд амраа. Булчингаа чангалахдаа өвдтөл болон өөртөө зовууртайгаар чангалах хэрэггүй. Хэрвээ контакт линз зүүдэг бол авахыг зөвлөх хэрэгтэй. Хийх дараалал:

1. **Баруун шуу болон гар:** гарын булчингийн дасгал хийж буй мэт гараа атгаад мөр рүүгээ тат. Гараа чанга атгаж, шууныхаа булчинг чангал. “тайвшир” гэж хэлсэн үед суллаад амраа. Гарын булчин суларч байгааг та анзаарна. Одоо зүүн гараараа

дээрхийг давтан хий.

2. **Дух:** хөмсгөө дээш нь дух руугаа тат. Духныхаа арьсыг чангалж үрчлээ үүсгэ. Тэгээд дараа нь амраа. Булчин амарч байгааг анзаарч мэдэхийг хичээ.
3. **Нүүрний булчингууд:** нүдээ тас аньж, хамрынхаа арьсыг үрчийлгэнэ. Нүд болон хамрын ойролцоох булчингууд чангарна. Одоо амраа.
4. **Хүзүүний булчингууд:** толгойгоо аажуухнаар баруун тийш эргүүл. Таны хүзүүний баруун талын булчин чангарна. Одоо толгойгоо буцаагаад хэвийн байдалд оруул. Булчин амрахад танд өөр мэдрэмж төрнө. Одоо толгой зүүн тийш эргүүлэн хий.
5. **Мөр:** мөрөө чихэнд хүргэх гэж байгаа юм шиг дээш нь сайн өргө. Булчин чинь чангарч өвдөж байгаа нь мэдрэгдэнэ. Одоо бүх булчингаа амраа.
6. **Нурууны булчингууд:** цээжээ төвийлгөж, хоёр далаа хооронд нь хүргэх гэж байгаа мэт хоёр мөрөө хойш тат. Нурууны дээд хэсгийн булчин чангарч байгаа нь мэдэгдэнэ. Одоо амраа.
7. **Гэдэсний булчингууд:** таны гэдэс рүү хэн нэгэн цохилоо гэж төсөөлөн гэдэсний булчингаа чангал. Гүн амьсгаа аваад чангал. Амьсгалахад хэцүү байгаа биз? Одоо булчингаа амраа.
8. **Баруун хөлийн өвдөгнөөс дооших булчин:** хөлөө шулуун жийгээд өвдгөө түгж. Хөлийн хуруу болон тавхайг хойш нь гэдийлгэ. Удаан барих тусам булчин чангарна. Дараа хөлийн тавхай болон хурууг доош тэнийлгэ. Таны гуя болон өвдөгнөөс дооших булчин чангарч байгаа нь мэдрэгдэнэ. Одоо амраа. Зүүн хөлдөө давтан хий.
9. Бүх биеийн булчин суллаж дууссаны дараа нүдээ аньсан хэвээр дахин гүнзгий амьсгаа авч гарга.
10. Нүдээ нээгээгүй байхад үргэлжлүүлэн төсөөллийн орчныг бүрдүүлэн үйлчлүүлэгчийг амраа.

Дасгалыг хийж гүйцэтгэсний дараа юу таалагдсан, бие нь амрахад ямар мэдрэмж төрсөн талаар ярилцана.

Гурван секундийн ид шид:

Зорилго. Сэтгэл хөдлөлийн тэнцвэрт байдлыг хангах, тайвшруулахад оршино.

Бэлтгэл ажил: Хүүхдүүд өөрсдийн байгаа орчиндоо босоо, суугаа байж болно.

Нийгмийн ажилтан эсвэл хэн нэг хүүхэд удирдаж болно:

Хийх дараалал: Оролцогчид нуруугаа цэх болгоно. Эхний 3 секундэд буюу 3 удаа тоолоход хамраараа амьсгаа авч гэдсээ сайн түнхийлгэнэ. 2 дахь 3 секундэд буюу 4-6 тоолоход амьсгаагаа түгжин барина. 3 дахь 3 секундэд буюу 7-9 тоолоход амьсгаагаа гаргана. Энэ дасгалыг 3-7 удаа давтан хийнэ. Та бүхэн бүгд маш их тайвширснаа мэдрэх болно.

Хохирогч болон сэжигтэн, яллагдагч, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан, сургалт хүмүүжлийн тусгай байгууллагаас суллагдсан хүүхдийг сургууль, боловсролын байгууллагууд ивээл хамгаалалтдаа авч, сургалт боловсролын үйлчилгээг тасалдуулахгүй байх цахим, зайны болон ганцаарчилсан сургалтын хувилбар сонгож хэрэгжүүлэх, ном сурах бичгээр хангах, анги хамт олонтойгоо хамт суралцах боломж, нөхцөлөөр хангаж өгөх арга хэмжээ авч байх хэрэгтэй.

Түүнчлэн эдгээр хүүхдэд шаардлагатай эм тариа, боох материал зэрэг хангалтыг аль болох даатгалаас эсхүл хохироогчийн талаас цаг алдалгүй гаргуулах арга замыг сүвэгчлэх, хохирогчийн нөхөн төлбөр гаргуулж авах асуудалд холбогдох материал бүрдүүлэхэд туслах, сэтгэл зүйн зөвлөгөөг үндэслэн тайвшруулах түгшүүр айдсаас хөндийрүүлэх зорилгоор уянгалаг, зөөлөн хөгжим сонсгох, сонсгосон хөгжийн утгыг зургаар илэрхийлэх, хөгжмийн янз бүрийн ритмтэй аянд бүжиг, хөдөлгөөн хийх зэрэг чөлөөт цагаа үр ашигтай өнгөрөөх талаар зөвлөж, тийм боломжийг бүрдүүлж өгвөл зохилтой. Тухайн хүүхдийн дуртай спортын болон бусад тоглоомоор тоглох, спортын дугуйлан секцэд хамруулах /бие хамгаалах чиглэлийн/ нь үр нөлөөтэй байдаг байна. Эмэгтэй, эрэгтэй хүмүүс, охид хөвгүүдийн ялгаатай байдлыг хүндэтгэсэн, нээлттэй үйлчилгээний орчныг бүрдүүлж ажиллах хэрэгцээ бий болсоор байна.

5.3. ХҮҮХДИЙН ЭРХИЙН ХУУЛЬ ЗҮЙН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ҮЛГЭРЧИЛСЭН ЗАГВАР

Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо нь улирал тутамд, шаардлагатай бол ээлжит бусаар хуралдах журамтай билээ. Хорооны хурал нь дараах дэгээр явагдах боломжтой юм. Хурлыг цахимаар явуулж ч болохыг анхааралдаа авна уу.

Нэг. Хуралдааны ерөнхий дэг:

- 1.1. Хуралдаанаар хэлэлцэх асуудлыг Ажлын албанаас боловсруулан Хорооны даргад танилцуулан, зөвшилцсөн байна.
- 1.2. Хорооны даргад танилцуулж, зөвшилцсөн асуудлыг хэлэлцэх ээлжит хуралдааны товыг 7-10 хоногийн, ээлжит бус шуурхай хуралдааны товыг 1-3 хоногийн өмнө Хорооны гишүүдэд Ажлын албанаас бичгээр болон утсаар, мессеж, мейл/зөвхөн албаны/ зэрэг боломжит хэлбэрийг ашиглан зарлан хүргэсэн байна.
- 1.3. Хуралдаанд зөвхөн хорооны гишүүд биеэр оролцох бөгөөд хүндэтгэх шалтгаантай бол бүрэн төлөөлөх эрх бүхий этгээдийг оролцуулж болно. Тухайн хурлаас гарсан шийдвэрийн хэрэгжилт, биелэлтийг зөвхөн Хорооны гишүүн хариуцна.
- 1.4. Хорооны ээлжит хуралдааны эхэнд өмнөх хурлаас гарсан шийдвэрийн биелэлтийг заавал хэлэлцэнэ. Биелэлтийн талаарх нэгдсэн танилцуулгыг Ажлын алба хийнэ.
- 1.5. Хорооны хуралд 2-с дээш удаа биеэр оролцоогүй эсхүл хуралд өөрөө болон төлөөний хүн ирүүлээгүй, хурлаас гарсан шийдвэрийг удаа дараа хэрэгжүүлээгүй бол хууль, журамд заасан үүргээ биелүүлээгүйн төлөө ёс зүйн болон хуулийн хариуцлага хүлээлгүүлэхээр Хорооны дарга тухайн этгээдийн удирдах дээд байгууллагад эсхүл Засаг даргад санал хүргүүлнэ.

Хоёр. Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:

Хорооны хурал 2019 оны 5 сарын ... ны өдөр 10.00-12.00 цагийн хооронд ЗДТГ-ын Хурлын танхимд болов. Хурлыг Хорооны дарга удирдан явууллаа.

Хурлын дарга: - ХЭХЗХ-ны хуралд ирвэл зохих 11 гишүүнээс ирсэн 9, бие төлөөлөл 2 хүрэлцэн ирсэн тул ирцийг 100% гэж үзээд хурлаа эхэлье. Хурлаар хэлэлцэх асуудлыг та бүхэнд Ажлын албанаас урьдчилан тараасан тул Ажлын албаны мэдээлэл, танилцуулгыг

сонссоны дараа шууд ярилцаад явъя. Өөр саналтай гишүүд байна уу? Байхгүй байна. За хурлын дэг ёсоор өмнө нь гаргасан шийдвэрийн хэрэгжилтийн талаар Ажлын албаны дарга танилцуулга, мэдээлэл хийнэ.

Ажлын албаны дарга: - Өмнөх хурлаар Гэр бүлийн хүчирхийллийн гэрч 15 настай Г-ийн асуудлыг хэлэлцээд түүнд Хууль зүйн болон Сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээ үзүүлэхийг Цагдаагийн газар, ГБХЗХГ-т даалгасан. Манай хоёр байгууллага хамтраад Түр хамгаалах байранд байгаа Г-д Хууль зүйн зөвлөгөөг 1 удаа, сэтгэл зүйн зөвлөгөөг 3 удаа өгсөн. Одоо сэтгэл зүйн хувьд айдасгүй, тогтвортой болсон. Мөн аюулгүй байдлын хувьд хүчирхийлэгч нь хоригдсон байгаа тул хэвийн болсон гэж үзэж байна. Г нь одоо гэртээ харьсан бөгөөд хичээл сургуульдаа үргэлжлүүлэн явж байгаа учир асран хамгаалагчид нь даалган өгсөн байгаа. Цагдаагийн хүүхдийн асуудал хариуцсан байцаагч болон цагдаагийн газарт, сэтгэл зүйн зөвлөгөө өгч хамтарч ажилласан “Энэрэнгүй сэтгэл” ТББ-ын сэтгэл зүйчдэд талархал дэвшүүлье.

Хорооны дарга: - Өмнөх шийдвэрийн хэрэгжилтийн талаар мэдээлэл хийсэн Ажлын албаны дарга Н танд баярлалаа. Хэлэлцэх асуудал ёсоор хүчирхийллийн хохирогч О-ийн талаар хэлэлцье. Манай өнөөдрийн хуралд хохирогч О-ийн хууль ёсны төлөөлөл болох эх Д нь оролцож байна. Мэдээлэл сонсохын өмнө хуралд оролцогчид Хүүхдийн нууцыг хадгалах гэрээнд гарын үсэг зурцгаана уу. /Хуралд оролцож буй бүх хүмүүс Нууц хадгалах гэрээнд гарын зурна./ За бүгд гарын үсэг зурсан учир Цагдаагийн газрын дарга танилцуулгаа хийнэ үү.

Цагдаагийн дарга: - Хохирогч О нь 14 настай. Эмэгтэй. Бэлгийн хүчирхийллийн хохирогчоор тогтоогдоод байгаа. Сэтгэл санааны гүн хямралтай, мэдүүлэг өгөх чадамжгүй байдалтай байна. Мөрдөн байцаалтын ажиллагааг шуурхай явуулахад хохирогчийн мэдүүлэг, нотолгоо чухал байна. Иймд холбогдох байгууллагуудын хамтын ажиллагаа шаардлагатай тул ХЭХЗХ-ны хуралд асуудлыг оруулж байна. Дэлгэрэнгүй мэдээлэл өгөх нь хуулиар хориотой тул мөрдөн шалгах ажиллагаанд дэмжлэг болохуйц мөн хохирогчийн эрхийг хангах зорилгоор мэргэжлийн байгууллагуудын хамтын ажиллагаа хэрэгтэй байна. Тухайлбал, энэ хохирогчид сэтгэл зүйн зөвлөгөө хэрэгтэй байна. Сайн, мэргэшсэн өмгөөлөгчийн хууль зүйн туслалцаа ч шаардлагатай байна. Мөн түр хамгаалалтад авч аюулгүй байдлыг нь хангах, эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах ч хэрэгцээ бий болоод байна. Энэ хэргийн мөрдөн шалгах ажиллагаа хуулийн дагуу хэвийн явагдаж байгаа. Хүчирхийлэгч сэжигтнийг саатуулан шалгаж байгаа.

Хорооны дарга: - За Ажлын албанаас нэмэлт тайлбар, санал байна уу?

Ажлын албаны дарга: - Хохирогчийн талаарх мэдээллийг манай байгууллагад нэлээд хожуу шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн явцад мэдэгдсэн. Бид нөхцөл байдлын үнэлгээ хийсэн. Холбогдох мэдээллийг цагдаагийн байгууллагад өгсөн. Нөхцөл байдлын үнэлгээнээс үзэхэд гэр бүлийн гишүүдийн харилцаа хэвийн тогтвортой. Гэр бүлийн амьдралын орчин нөхцөл хэвийн боломжтой. Эцэг нь тодорхой ажилгүй. Эх нь төсвийн байгууллагад ажилтай. Ам бүл 5-лаа. 2 дүүгийн хамт амьдардаг. О нь сургуульд сурдаг. Хичээлээ тасалж байгаагүй. Анги хамт олонтойгоо нийцтэй биш зожигдуу зантай. Гар утас, фейсбүүк ашигладаг. Фейсбүүкээр иргэн Т-тэй холбогдсон. Хэд хэдэн удаа харилцсан. Т нь хотоос ирж, тэд буудалд уулзсанаар энэ хэрэг явдал эхэлж, О хохирогч болсон байдаг. О хохирогч болсон гэдгээ үйл явдал болсноос хойш 2 хоногийн дараа ээждээ хэлснээр ээж нь цагдаад хандсан байна. О-г хохирогч болсныг сургууль, анги хамт олон нь мэдээгүй байгаа. Өвчтэй гэж ойлгож байгаа.

Харин нийгмийн ажилтан, анги удирдсан багш, захирал нар нь мэдэж байгаа.Манай байгууллагад шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн үед Цагдаагийн байгууллагаас мэдэгдсэн.

Хорооны дарга: - За бид хохирогчийн талаар зохих мэдээлэлтэй танилцлаа. Одоо яг ямар арга хэмжээг шуурхай авч, ямар тусламж, үйлчилгээ үзүүлэх талаар ярилцъя. Ажлын албанаас саналаа хэлнэ үү?

Ажлын албаны дарга: - Хохирогчид хэдэн чиглэлийн тусламж үйлчилгээ шаардлагатай байгаа. 1-т эрүүл мэндийн шинжилгээ, эмчилгээнд хамруулах; 2-т сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, 3-т өмгөөллийн үйлчилгээ авах, 4-т түр хамгаалалтад авах

Хорооны дарга: - Хохирогчийг эдгээр үйлчилгээнд хамруулахад ямар бэрхшээл хүндрэл байна вэ? Хариуцсан салбарууд холбогдох арга хэмжээг авч, шаардлагатай зөвлөгөө үйлчилгээгээ үзүүлээд явахад болох юм биш үү?

Эрүүл мэндийн газрын дарга: - Манайх шинжилгээ, оношилгоо, эмчилгээний асуудлыг хариуцан тусламж үзүүлэхэд бэлэн байна. Эрүүл мэндийн даатгалын дэвтэртэй л байх шаардлагатай.

Боловсролын газрын дарга: - Бид сургуулийн захиргаатай яриад хичээл сургуулийг нь тасалдуулахгүй байх тал дээр анхаарч ажиллахыг үүрэг болгоё.

Хуульчдын холбооны гишүүн/өмгөөлөгч/: -Бид өмгөөллийн про-боно үйлчилгээ үзүүлэхэд бэлэн байна. Харин өмгөөллийн явцад гарах зарим зардлын асуудлыг шийдвэрлэж өгнө үү? Нааш цааш явах унаа, бичиг цаас гэх мэт зардлууд нэлээдгүй гардаг.

Албаны дарга: - Мөрдөн шалгах ажиллагаа хуулийн дагуу явагдсан гэдэгт эргэлзээтэй байна. Яагаад өнөөдрийг хүртэл өмгөөлөгчгүй байхад байцаалт явагдсан бэ? Монгол Улсын Ерөнхий прокурорын 2017 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн А/96 дугаар тушаалаар баталсан “Мөрдөн шалгах ажиллагаанд тавих прокурорын хяналтын ажлын аргачилсан заавар” хэр биелэгдсэн бол?

Хорооны дарга: - Прокурор хариулна уу?

Прокурор: - Бид хууль, журмын дагуу хяналт тавьж байгаа. Өмгөөлөгч болон хууль ёсны төлөөлөгчгүйгээр мөрдөн байцаалт явагдсан бол дахин мөрдөн байцаалт явуулахаар буцаах ёстой. Энэ удаад хохирогчийн хууль ёсны төлөөлөгч нь оролцсон учир байцаалт явагдсан. Харин хохирогчийн ээж нь хохирогчийн эрх ашигт харшлах нөхцөл байдал үүссэн тул хууль ёсны төлөөлөгчөөр ГБХЗГ-ын мэргэжилтнийг томилуулахаар, өмгөөллийн үйлчилгээгээр хангах асуудлыг хууль журмын дагуу тавиад явж байна. Одоо хохирогч маань шинээр хууль ёсны төлөөлөгчтэй, мөн өмгөөлөгчтэйгөөр шүүхийн үйл ажиллагаанд оролцох боломжтой болсон.

Ажлын албаны дарга: - Өмгөөллийн байгууллага үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлэх боломжтой гэлээ. Цаашид энэ про-боно үйлчилгээгээ үргэлжлүүлэх бололцоотой юу?

Хуульчдын холбооны гишүүн /өмгөөлөгч/: - Про-боно үйлчилгээ бол сайн дурын үйл ажиллагааны нэг хэлбэр. Бид байнга үзүүлэх боломж бага. Үнэхээр төлбөрийн чадвар муу тийм хохирогчид л шуурхай тусалж байгаа хэрэг. Ийм үйлчилгээг өмгөөлөгч бүр жилдээ 1-2 үйлчлүүлэгчид үзүүлэх боломжтой гэж үзэж байгаа. Энэ боломж дуусвал хохирогчийн өмгөөллийн төлбөрийн асуудал яригдаж таарна. Тиймээс хууль ёсны тодорхой эх үүсвэрийг

бас олох л хэрэгтэй байгаа юм.

Ажлын албаны дарга: - Төлбөрийн чадваргүй хохирогчид өмгөөллийн үйлчилгээ үзүүлэхэд туслах дэмжих талаар ямар эрх зүйн боломжууд байна вэ? Хөдөлмөр, нийгмийн халамжийн газрын дарга саналаа хэлнэ үү?

Хөдөлмөр, нийгмийн халамжийн газрын дарга: - Хохирогч хүүхэд бол эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд. Тиймээс Нийгмийн халамжийн тухай хуулийн 18.2.3-т зааснаар “эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд”, мөн 18.2.4-т зааснаар “хүчирхийлэлд өртсөн иргэн” учраас Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдана. Мөн хуулийн 13.2.1-т зааснаар “бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг асран хамгаалж, харгалзан дэмжиж байгаа” бол, түүнчлэн уг хуулийн 13.2.2-т зааснаар “Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан болон хүчирхийллийн улмаас сэтгэл санааны болон бие махбодын хохирол хүлээж хамгаалалт шаардлагатай болсон хүүхдийг Гэр бүлийн тухай хуулийн 74 дүгээр зүйлд заасны дагуу гэр бүлдээ авч асрамжилж байгаа хүүхдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор Хүүхэд хамгааллын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд хамрагдсан байгаа” бол асаргааны тэтгэмжийг олгож болдог хуулийн зохицуулалт байна.

Хорооны дарга: - Хөдөлмөр, нийгмийн халамжийн газрын даргад баярлалаа. Ийм нөхцөл байдал цаашид үүсвэл хохирогч хүүхдэд үзүүлэх шаардлагатай үйлчилгээний зардлыг Хорооны хурлын шийдвэрийг үндэслэн гаргаж байх нь эрх зүйн хувьд боломжтой юм байна. Шүүхийн Тамгын газрын дарга ямар саналтай байна.

Шүүхийн Тамгын газрын дарга: - Шүүхийн үйл ажиллагаа эхэлчихсэн. Шүүх зөвхөн үнэн зөв, нотлох баримтыг л үндэс болгон шийдвэрээ гаргадаг. Хохирогч хүүхдийн бүхий л эрхийг хангахад анхаарч ажиллана. Байр танхимын асуудал бололцоотой бол хүүхдийн өрөө байгуулах, камер болон дэлгэцээр хуралдааныг явуулах, 1-2 шүүгчийг хүүхдийн асуудлаар мэргэшүүлэх зэрэг асуудлууд байгаа. Эдгээр асуудлаар хамтран ажиллах төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлага байгаа. Ингэж чадвал шүүх хүүхдэд ээлтэй байх зарчим хэрэгжинэ байхаа.

Хорооны дарга: - За Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга саналаа хэлнэ.

Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга: - Ер нь манай аймагт сүүлийн үед хүүхдийн эсрэг хүчирхийлэл өсөх шинжтэй болж байна. Хуралд танилцуулсан мэдээллээс харахад. Ялангуяа садан төрлийн, цахим халдлагын хэлбэртэй хүчирхийлэл илүү анхаарал татаж байна. Иймд энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нөхцөл шалтгааныг тодруулах талаар мэдээлэл, сонсгол бэлтгэж ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлж, тодорхой арга хэмжээ авъя. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл, энэ Хорооны ажлын алба буюу ГБХЗХГ-тай хамтран оруулж ирье.

Хорооны дарга: За. Танд баярлалаа. Маш тодорхой бодлогын шинжтэй санал гаргалаа. Манай Ажлын алба, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлтэй хамтраад ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралд асуудал оруулъя. Одоо хууль ёсны төлөөлөгч Д саналаа хэлнэ үү.

Хууль ёсны төлөөлөгч Д: - Миний охинд тохиолдсон золгүй явдалд тусалж дэмжиж байгаад талархаж байна. Өөрөөс шалтгаалах бүхнээ та бүгдийн зөвлөмж, тусламжтайгаар хийх болно. Баярлалаа.

Хорооны дарга: За өнөөдрийн хурал үүгээр өндөрлөж байна. Хурлаас гарах шийдвэрийн төслийг танилцуулъя.

Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны хуралдааны хураангуй тэмдэглэл

Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны 2011 оны 5 дугаар сарын ...-ний өдрийн хуралдааны ... дугаар тэмдэглэлд:

“ХЭЛЭЛЦСЭН НЬ: Хохирогчид үзүүлэх дэмжлэг тусалцааны тухай

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ: 1. Гэмт хэргийн хохирогч О-гийн талаарх танилцуулгыг хэлэлцээд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 5.2 дугаар зүйл, 5.3 дугаар зүйлийн 1.2 дахь хэсэг, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 23.4, 25.4-т заалт, ХЭХЗХ-ны журмыг үндэслэн Хууль зүйн хорооны гишүүдэд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгав.

- а) Хохирогч О-д хүүхдийн эрх, хамгааллыг сайн мэдэх, туршлагатай байцаагч томилон ажиллуулахыг Цагдаагийн газарт;
- б) Цаашид Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 25.4-т заасны дагуу насанд хүрээгүй гэрч, хохирогчийг хамгаалах, тэдний эрхийг хангах чиглэлээр шүүгч, прокурор, мөрдөгчийг чадваржуулах сургалтад хамруулж, дагнан мэргэшүүлэх арга хэмжээг авч, хэрэгжүүлэхийг Шүүхийн Тамгын газар, Аймгийн прокурорын байгууллага, Цагдаагийн газар, ГБХЗХГ-ын дарга нарт;
- в) Цагдаагийн байгууллага хүүхэдтэй холбоотой/хүүхэд гэрч, хохирогч болсон, хууль зөрчсөн байж болох нөхцөл үүссэн зэрэг/мэдээлэл хүлээн авмагц Хүүхдийн асуудал хариуцсан байгууллагад буюу Ажлын албанд даруй мэдээлж, хамтран ажиллахыг Цагдаагийн газар/хэлтэс/т;
- г) Цагдаагийн байгууллага ГБХЗХГ, Хөдөлмөр халамж үйлчилгээний газартай хамтран Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 23.4-т заасны дагуу мэргэжлийн хууль зүйн зөвлөгөө өгөх болон сэтгэл зүйчийн багийг байгуулж, ажиллуулахыг Цагдаагийн газар, ГБХЗХГ, ХХҮГ-ын дарга нарт;
- д) Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралд «Хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ тухай» мэдээлэл, танилцуулга хийж, асуудал хэлэлцүүлэхийг Хорооны Ажлын алба, ИТХ-ын нарийн бичгийн дарга нарт;
- е) Насанд хүрээгүй хохирогчийн эрхийг хангах зорилгоор насанд хүрээгүй этгээд нь заавал өмгөөлөгч болон хууль ёсны төлөөлөгчтэй хамт байж мэдүүлэг өгдөг журам тогтоож, мөрдүүлэхийг Цагдаагийн газарт тус тус үүрэг, чиглэл болгох;

2. Хохирогч О-д сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлэхийг ГБХЗХГ, Цагдаагийн газрын дарга нарт, эрүүл мэндийн шаардлагатай үзлэг, оношилгоонд оруулах, яаралтай эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэхийг Эрүүл мэндийн газрын даргад, өмгөөллийн үйлчилгээ үзүүлж хамтран ажиллахыг Өмгөөллийн холбооны тэргүүнд, мөрдөн байцаалтын болон шүүх ажиллагааны бүхий л явцад хохирогч О-ийн сурч, боловсрох эрхийг хангаж ажиллахыг Боловсролын газрын даргад тус тус даалгав” гэжээ.

Ажлын алба

ХАВСРАЛТ.

1. ХЭХЭХ-НЫ ШИНЭЧИЛСЭН ЖУРАМ

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД, ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2021 оны 12 сарын
06 ний/ны өдөр


Дугаар А/190.1/А/280

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3, 17 дугаар зүйлийн 17.1.1, 17.1.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам"-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга /Г.Өнөрбаяр/, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Б.Баасандорж/ нарт даалгасугай.
3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/51, А/69 дүгээр хамтарсан тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд,
Хууль зүй, дотоод хэргийн сайдын
2021 оны 12 дугаар сарын 06 -ны өдрийн
А/15.01/А/230 дугаар хамтарсан тушаалын
хавсралт

ХҮҮХДИЙН ЭРХИЙН ХУУЛЬ ЗҮЙН ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмаар Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо /цаашид "Хууль зүйн хороо" гэх/-ны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагаа болон Хууль зүйн хорооноос бусад байгууллагатай хамтран ажиллахтай холбоотой харилцааг зохицуулна.

1.2.Хууль зүйн хорооны үйл ажиллагаанд энэ журам болон Монгол Улсын Үндсэн хууль, Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, олон улсын гэрээ, конвенц, захиргааны хэм хэмжээний актыг мөрдөнө.

1.3.Хүүхэд хамгааллын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасны дагуу аймаг, дүүргийн Засаг дарга, тухайн орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралтай зөвшилцөн Хууль зүйн хороог байгуулна. Сум дундын шүүх ажиллаж байгаа сумдад тус хороог байгуулж болно.

Хоёр.Хууль зүйн хорооны үйл ажиллагааны зарчим, нийтлэг чиг үүрэг

2.1. Хууль зүйн хороо үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална.

- 2.1.1.хүүхдийн эрх, нэр төрийг хүндэтгэх;
- 2.1.2.хууль, шүүхийн өмнө эрх тэгш байдлыг хангах;
- 2.1.3.жендерийн эрх тэгш байдлыг хангах;
- 2.1.4.хүүхдийн дээд ашиг сонирхлыг эн тэргүүнд хангах, хамгаалах;
- 2.1.5.гишүүдийн оролцоо тэгш байх;
- 2.1.6.гишүүдийн ажлын ачааллыг тэгш хуваарилах;
- 2.1.7.байгууллага болон хувь хүний нууцад хамаарахаас бусад асуудлаар Хууль зүйн хорооны үйл ажиллагаа олон нийтэд ил тод, нээлттэй байх;
- 2.1.8.хүүхдийн хувийн халдашгүй байдлыг хүндэтгэж, нууцыг хадгалах;
- 2.1.9.журам зөрчсөн байгууллага, албан тушаалтанд хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцуулах.

2.2.Хууль зүйн хороо, түүний Ажлын алба нь Хүүхэд хамгааллын тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, энэ журамд заасан үүргээ хэрэгжүүлэхдээ хүүхдийн эрүүл мэнд, ёс суртахуун, сэтгэцийн онцлогийг харгалзаж хүүхдийн нас биед тохирсон, хүсэл сонирхолд нийцсэн зөвлөгөө, туслалцаа, дэмжлэг үзүүлж, үйлдсэн гэмт хэрэг, зөрчлийн хор уршгийг нь ухамсарлуулах, бусдад учруулсан хохирол, гэм хорыг арилгахад хүүхдийг оролцуулах, гэмт хэрэг үйлдэхэд хүргэсэн шалтгаан нөхцөлийг арилгах, сөрөг нөлөөнөөс тусгаарлах зэрэг арга хэмжээг хууль тогтоомжид заасан хүрээнд нийцүүлэн авна.

Гурав. Хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, тэдгээрийн эрх, үүрэг

3.1.Хууль зүйн хороо нь аймаг, дүүрэгт гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэж сэжиглэгдэж, мөрдөн шалгагдаж байгаа, эсхүл гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан, зөрчил үйлдэж шийтгэгдсэн хүүхдэд /цаашид "хүүхэд" гэх / үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулна.

3.2.Хүүхэд хамгааллын тухай хуульд заасны дагуу Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуулийн үйлчлэлд хамаарахгүй хүүхдэд энэ журамд заасны дагуу туслалцаа үзүүлэн, зөвлөгөө өгч, эрх ашгийг нь хамгаална.

3.3.Хууль зүйн хорооны дарга нь тухайн аймаг, дүүргийн Засаг даргын орлогч байна.

3.4.Хууль зүйн хорооны гишүүнээр дараах алба хаагч, иргэн ажиллана:

3.4.1.аймаг, дүүрэг дэх шүүхийн Тамгын газрын дарга;

3.4.2.аймаг, дүүргийн Прокурорын газрын ерөнхий прокурор;

3.4.3.аймаг, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга;

3.4.4.аймаг, дүүргийн хууль, эрх зүйн асуудал хариуцсан нэгжийн дарга;

3.4.5.аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан газар /хэлтэс/-ын дарга;

3.4.6.аймаг, дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга;

3.4.7.аймаг, дүүргийн боловсролын асуудал хариуцсан газар /хэлтэс/-ын дарга;

3.4.8.аймаг, дүүргийн эрүүл мэндийн асуудал хариуцсан газар /хэлтэс/-ын дарга;

3.4.9.аймаг, дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээ хариуцсан газар /хэлтэс/-ын дарга;

3.4.10.аймаг, дүүргийн Цагдаагийн газар /хэлтэс/-ын дарга;

3.4.11.аймаг, дүүргийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар /хэлтэс/-ын дарга;

3.4.12.Хүний эрхийн Үндэсний комиссын орон нутаг дахь ажилтан;

3.4.13.Өмгөөлөгчдийн холбооны аймаг, дүүргийн салбар зөвлөлийн дарга /зөвшилцсөнөөр/;

3.4.14.аймаг, дүүрэгт гэр бүл, хүүхдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын төлөөлөл /зөвшилцсөнөөр/;

3.4.15.аймаг, дүүргийн хүүхдийн элч /зөвшилцсөнөөр/.

3.5. Хууль зүйн хорооны гишүүн хуралдаанд биечлэн оролцох үүрэгтэй.

3.6.Энэ журмын 3.4-т заасан нэгж тухайн аймаг, дүүрэгт байгуулагдаагүй бол тухайн чиг үүргийг хариуцдаг байгууллага /нэгж/-ын дарга хариуцна.

3.7.Хууль зүйн хорооны нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга нь аймаг, дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан газар /хэлтэс/-ын дарга байна.

3.8.Хууль зүйн хорооны дарга дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

3.8.1.Хүүхэд хамгааллын тухай хуулийн 15.1-д заасан ажлыг харьяа нутаг дэвсгэрийн хүрээнд удирдан зохион байгуулах;

3.8.2.Хууль зүйн хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг тодорхойлох, хуралдааныг товллох, хуралдааныг даргалах;

3.8.3.хууль тогтоомж болон энэ журамд заасан бүрэн эрхийн хүрээнд шийдвэр гаргаж, хэрэгжилтэд хяналт тавих;

3.8.4.Хууль зүйн хороо, Ажлын албаны үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөний төслийг Хууль зүйн хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх, үйл ажиллагааны тайланг хэлэлцэж дүгнэх;

3.8.5.Хууль зүйн хороо, Ажлын албаны үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах төсөв, санхүүжилтийг холбогдох байгууллагад танилцуулж шийдвэрлүүлэх;

3.8.6.Хууль зүйн хорооны ажлын тайлан, шаардлагатай тохиолдолд нөхцөл байдлын мэдээллийг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулах;

3.8.7.Хууль зүйн хорооны Ажлын албаны үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, нэгдсэн арга зүй, удирдлагаар хангах;

3.8.8.Хууль зүйн хорооны гишүүдийн ажил үүргийг тогтоож, хэрэгжилтэд хяналт тавих;

3.8.9.Хууль зүйн хорооны гишүүдийн үйл ажиллагааны талаар шаардлагатай бол томилсон дээд албан тушаалтанд мэдээлэл, шаардлага хүргүүлэх;

3.8.10.батлагдсан төсвийг хууль тогтоомжид заасан зориулалтын дагуу захиран зарцуулах;

3.8.11.Хууль зүйн хорооны гишүүд, Ажлын албаны ажилтнуудын мэргэшлийг дээшлүүлэх, давтан сургах, тогтвор суурьшилтай ажиллуулах нөхцөлийг бүрдүүлэх;

3.8.12.Ажлын албанд чиглэл, зөвлөмж өгөх;

3.8.13.хууль тогтоомж болон энэ журамд заасан бусад эрх, үүрэг.

3.9. Хууль зүйн хорооны гишүүн дараах нийтлэг эрх, үүрэгтэй:

3.9.1.Хууль зүйн хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын талаар санал гаргах;

3.9.2.Хууль зүйн хорооны хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгааны улмаас оролцох боломжгүй тохиолдолд саналаа бичгээр Ажлын албанд урьдчилан өгөх;

3.9.3.Хууль зүйн хорооны хуралдаанаар хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан нэмэлт баримт бичиг шаардах буюу гаргуулан авах;

3.9.4.Ажлын албанд Хүүхэд хамгааллын тухай хууль болон энэ журамд заасан чиг үүргийн хүрээнд үүрэг, даалгавар өгч, гүйцэтгэлд нь хяналт тавих;

3.9.5.Ажлын албатай байнга хамтарч ажиллах албан хаагч, албан тушаалтныг байгууллагаасаа томилж, албан тушаалын тодорхойлолтод хариуцах ажлыг тодорхой зааж өгөх;

3.9.6.Хууль зүйн хороо, Ажлын алба үйл ажиллагаа явуулахад шаардлагатай судалгаа, мэдээллийг хууль тогтоомжийн хүрээнд гаргаж өгөх;

3.9.7.Хууль зүйн хорооны хуралдаанаар хэлэлцсэн хувь хүн, байгууллага, төрийн болон албаны нууц, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын нууцлалыг хангах;

3.9.8.Хүүхэд хамгааллын тухай хуулийг өөрийн хариуцсан байгууллагад хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

3.9.9.хууль тогтоомж болон энэ журамд заасан бусад эрх, үүрэг.

3.10.Хууль зүйн хорооны гишүүн энэ журмын 3.9-д заасан нийтлэг эрх, үүргийг хэрэгжүүлэхээс гадна Хууль зүйн хороо, Ажлын албаны үйл ажиллагаанд энэ журмын 3.11-3.22-д зааснаар оролцоно.

3.11.Аймаг, дүүрэг дэх шүүхийн Тамгын газрын дарга Хууль зүйн хороо, Ажлын албаны үйл ажиллагаанд дараах чиг үүрэгтэйгээр оролцож болно:

3.11.1.хүүхэд оролцсон хэргийг дагнан шийдэх шүүгчийг ажиллуулахад дэмжлэг үзүүлэх, хүүхдийн эсрэг гэмт хэргийг шуурхай шийдвэрлэх нөхцөл боломжийг бүрдүүлэх;

3.11.2.хүүхэд оролцсон хэргийг хянан шийдвэрлэх явцад түүний нэр төр, эрхийг хүндэтгэн үздэг харилцаа, ёс зүйг шүүхийн орчинд төлөвшүүлэх, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр шүүгчийг мэргэшүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

3.11.3.хууль тогтоомжид заасан бусад.

3.12.Аймаг, дүүргийн Прокурорын газрын ерөнхий прокурор Хууль зүйн хороо, Ажлын албаны үйл ажиллагаанд дараах чиг үүрэгтэйгээр оролцож болно:

3.12.1.хүүхэд оролцсон хэрэгт хяналт тавих прокурорыг мэргэшүүлж ажиллуулах, хүүхэд оролцсон гэмт хэрэг, зөрчлийг шуурхай шийдвэрлэх боломжийг бүрдүүлэх;

3.12.2.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд энэ журамд заасан хүүхдийн хууль ёсны эрх ашгийг зөрчсөн зөрчил гаргуулахгүй байхад анхаарч, хяналт тавих, Хүүхийн эрхийн конвенцийн 37 дугаар зүйлийн а-д “хүүхдэд эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар, нэр төрийг нь доромжлон харьцах буюу шийтгэхгүй байх, 18 насанд хүрээгүй хүүхдийн үйлдсэн гэмт хэрэгт цаазаар авах буюу суллах боломжгүйгээр бүх насаар нь хорих ял оногдуулахгүй байх”, б-д “хүүхдийн эрх чөлөөг хууль бусаар буюу дүр мэдэн хязгаарлаж болохгүй. Хүүхдийг баривчлах, саатуулах, хорих арга хэмжээг хамгийн богино тохиромжтой хугацаанд эцсийн арга хэмжээ болгон хэрэглэх”, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.9 дүгээр зүйлийн 1-д “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчид эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжлохыг хориглоно.” гэж заасныг баримталж, хүүхдийг эрүү шүүлт, хүнлэг бус харилцаанаас хамгаалах;

3.12.3.хүүхдийн эрхийг хамгаалах, тухайн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг судлах ажилд хууль тогтоомжийн хүрээнд дэмжлэг үзүүлэх;

3.12.4.хууль тогтоомжид заасан бусад.

3.13.Аймаг, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нарийн бичгийн дарга Хууль зүйн хороо, Ажлын албаны үйл ажиллагаанд дараах чиг үүрэгтэйгээр оролцоно:

3.13.1.Хууль зүйн хороо, Ажлын албаны үйл ажиллагааг аймаг, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, орон нутгийн Хүүхдийн төлөө зөвлөлийн үйл ажиллагаатай уялдуулах, хамтран ажиллах боломжоор хангах;

3.13.2.Хууль зүйн хорооны бодлого, чиглэлийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бодлого, шийдвэр, төсөвт тусгах, үйл ажиллагааг нь уялдуулах;

3.13.3.хууль тогтоомжид заасан бусад.

3.14.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга нь Хууль зүйн хороо, Ажлын албаны үйл ажиллагаанд энэ журам болон Гэмт

хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан чиг үүргийн хүрээнд оролцоно.

3.15. Аймаг, дүүргийн боловсролын асуудал хариуцсан газар /хэлтэс/-ын дарга Хууль зүйн хороо, Ажлын албаны үйл ажиллагаанд дараах чиг үүрэгтэй оролцоно:

3.15.1. ерөнхий боловсролын сургуульд сурдаг энэ журамд заасан хүүхдийн талаарх мэдээллийг шаардлагатай тохиолдолд хороонд ирүүлэх;

3.15.2. ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа хүүхдийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын болон хувийн нууцыг хадгалах, сургалтад тасралтгүй хамрагдах, ялгаварлан гадуурхагдахгүй байх нөхцөлийг бүрдүүлэх;

3.15.3. сургуулийн нийгмийн ажилтныг хууль зөрчсөн хүүхэдтэй ажиллах нөхцөл, боломжоор хангах;

3.15.4. сургуулиас гарсан, хасагдсан, завсардсан, бичиг үсэг мэдэхгүй хууль зөрчсөн хүүхдэд боловсрол олгох ажлыг зохион байгуулах;

3.15.5. сургуулийн нийгмийн ажилтан болон багшийн ажлыг дүгнэх, үнэлэх шалгуур үзүүлэлтэд эрх нь зөрчигдсөн болон хууль зөрчсөн хүүхдийг анги хамт олонд нь нэгтгэх, хүмүүжүүлэх, нийгэмшүүлэх арга хэмжээг тусгаж, хяналт тавих;

3.15.6. хууль тогтоомжид заасан бусад.

3.16. Эрүүл мэндийн газар /нэгдэл/-ын дарга Хууль зүйн хороо, Ажлын албаны үйл ажиллагаанд дараах чиг үүрэгтэйгээр оролцоно:

3.16.1. хүүхдэд шаардлагатай эрүүл мэндийн тусламж үйлчилгээг харьяа өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлгээрээ дамжуулан үзүүлж, хяналтад авах ажлыг зохион байгуулах;

3.16.2. хүүхдийн эрүүл мэндийн байдлын талаар шаардлагатай мэдээллийг цагдаагийн байгууллага болон Ажлын албанд шуурхай хүргэх;

3.16.3. хууль тогтоомжид заасан бусад.

3.17. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний асуудал хариуцсан газар /хэлтэс/-ын дарга Хууль зүйн хороо, Ажлын албаны үйл ажиллагаанд дараах чиг үүрэгтэйгээр оролцоно:

3.17.1. хүүхдийг мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад хамруулах;

3.17.2. хууль зөрчсөн хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг нь ажил, мэргэжилтэй болоход дэмжлэг үзүүлэх;

3.17.3. сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагаас суллагдсан орон гэргүй хүүхэд, түүний асран хамгаалагч харгалзан дэмжигчийг нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаанд хамруулах;

3.17.4. хууль тогтоомжид заасан бусад

3.18.Хууль, эрх зүйн асуудал хариуцсан газар /хэлтэс/-ын дарга Хууль зүйн хороо, Ажлын албаны үйл ажиллагаанд Хүүхэд хамгааллын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн бүх талын дэмжлэг, туслалцаа үзүүлж оролцоно.

3.19.Аймаг, нийслэлийн Цагдаагийн газар /хэлтэс/-ын дарга Хууль зүйн хороо, Ажлын албаны үйл ажиллагаанд дараах чиг үүрэгтэйгээр оролцоно:

3.19.1.Хүүхэд хамгааллын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-15.1.7 дахь заалтыг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх;

3.19.2.хүүхэд оролцсон гэмт хэрэг, зөрчил болон эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаарх мэдээллээр хууль тогтоомжийн хүрээнд хангах;

3.19.3.хүүхэд оролцсон хэргийн хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтыг хүүхдэд ээлтэй орчинд явуулах, хэргийг шуурхай шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх;

3.19.4.хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах чиглэлийн мэргэшлийн сургалтад цагдаагийн эрх бүхий ажилтан, мөрдөгч нарыг тогтмол хамруулах, хүүхдийн эрхийг хүндэтгэсэн, ёс зүйтэй харилцааг албан хаагч нарт төлөвшүүлэх ажлыг зохион байгуулах;

3.19.5.хүүхэд дахин гэмт хэрэг үйлдэх, зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх талаар Хууль зүйн хороо, Ажлын албатай хамтран ажиллах;

3.19.6.хууль тогтоомжид заасан бусад.

3.20.Аймаг, нийслэлийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар /хэлтэс/, Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын дарга Хууль зүйн хороо, Ажлын албаны үйл ажиллагаанд дараах чиг үүрэгтэйгээр оролцоно:

3.20.1.Хүүхэд хамгааллын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, 15.1.2, 15.1.4, 15.1.6 дахь заалтыг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх;

3.20.2.гэмт хэрэг үйлдэж шүүхээс ял шийтгүүлсэн, хүмүүжлийн чанартай арга хэмжээ авагдсан хүүхэдтэй холбоотой мэдээллээр хуулийн хүрээнд хангах;

3.20.3.сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хүмүүжиж байгаад суллагдсан хүүхэдтэй холбоотой мэдээллээр хуулийн хүрээнд хангах;

3.20.4.сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хүмүүжиж байгаа хүүхдийн эрхийг хамгаалах, эрх зүйн зөвлөгөө, нийгэм сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх чиглэлээр хамтран ажиллах;

3.20.5.хууль тогтоомжид заасан бусад.

3.21.Монголын өмгөөлөгчдийн холбооны аймаг, дүүргийн салбар зөвлөлийн дарга, гишүүд Хууль зүйн хороо, Ажлын албаны үйл ажиллагаанд дараах чиг үүрэгтэйгээр оролцоно:

3.21.1.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хууль зөрчсөн хүүхдийг төлөөлж, холбогдох байгууллагад санал, хүсэлт, гомдол гаргах, хороог мэдээллээр хангах, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал гаргах;

3.21.2.хүүхэд оролцсон хэргийг шуурхай шийдвэрлэхийн тулд Өмгөөллийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасан арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх;

3.21.3.хууль тогтоомжид заасан бусад.

3.22. Хүүхэд, гэр бүлд үйлчилдэг төрийн бус байгууллагын төлөөлөл нь энэ журамд заасан хүүхдэд шаардлагатай тохиолдолд хүүхэд хамгааллын үйлчилгээ, нийгэм сэтгэл зүйн үйлчилгээг мэргэжлийн түвшинд шуурхай хүргэх, холбон зуучлах чиглэлээр дэмжлэг үзүүлж ажиллана.

Дөрөв. Хууль зүйн хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа

4.1.Хууль зүйн хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр хуралдаан байна.

4.2.Хууль зүйн хорооны дарга хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хуралдаан даргалах боломжгүй бол төрийн захиргааны байгууллагын хууль, эрх зүйн асуудал хариуцсан нэгжийн дарга түүний бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

4.3.Хууль зүйн хорооны дарга, энэ журмын 4.2-т заасан албан тушаалтны эзгүйд Хууль зүйн хорооны хамгийн ахмад гишүүн хуралдааныг даргална.

4.4.Хууль зүйн хорооны хуралдаанаар дараах асуудлыг хэлэлцэж, шийдвэрлэнэ:

4.4.1.Хууль зүйн хорооны хуралдааны дэг;

4.4.2.Хууль зүйн хорооны үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөг хэлэлцэж, холбогдох шатны Хүүхдийн төлөө зөвлөлөөр батлуулах;

4.4.3.Хууль зүйн хорооны ажил, үйлчилгээний зардал, санхүүжилтийг төсөвт тусгах;

4.4.4.энэ журамд заасан хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах боломжийг бүрдүүлэх, сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөө;

4.4.5.гэмт хэрэг, зөрчилд холбогдон шалгагдаж байгаа хүүхдийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны сөрөг нөлөөллөөс хөндийрүүлэх зорилгоор хууль сахиулах байгууллагатай хамтран ажиллах, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө;

4.4.6.сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хүмүүжиж байгаад суллагдсан хүүхдийг нийгэмд хэвийн амьдрахад нь дэмжлэг, туслалцаа үзүүлэх, хууль зөрчсөн хүүхдэд зөв хүмүүжил олгох, хорт зуршлаас ангижрахад чиглэгдсэн боловсрол, мэргэжил, мэргэжлийн чиг баримжаа олгох, амьдрах ухаан, эрх зүйн анхан шатны мэдлэг олгох сургалт зохион байгуулах төлөвлөгөө;

4.4.7.хууль зөрчсөн хүүхдийг хүмүүжүүлж, нийгэмшүүлэх үйл ажиллагаанд бусад байгууллагуудыг татан оролцуулах, гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгах талаар бусад байгууллагуудтай хамтран ажиллах шийдвэр гаргах;

4.4.8.Хууль зүйн хорооны гишүүд болон хамтран ажилладаг байгууллагын албан хаагчдыг чадавхжуулах ажлыг зохион байгуулах хөтөлбөр;

4.4.9.Хууль зүйн хорооноос баталсан хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан;

4.4.10.бусад.

4.5.Хууль зүйн хорооны гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь оролцсоноор хуралдаан хүчин төгөлдөр болно.

4.6.Хууль зүйн хорооны хуралдааны явцыг тэмдэглэлээр баталгаажуулах бөгөөд тэмдэглэлд Хуралдаан даргалагч, нарийн бичгийн дарга гарын үсэг зурна.

4.7.Хууль зүйн хорооны хуралдаанаар хэлэлцэж буй асуудал нь гишүүний гэр бүл, төрөл садангийн хүнд хамаарахаар байгаа бол тус гишүүн хуралдаан эхлэхээс өмнө энэ тухай бичгээр мэдэгдэж, уг асуудлыг хуралдаанаар хэлэлцэх, шийдвэр гаргахад оролцохгүй.

4.8.Хууль зүйн хорооны хуралдаанаас тус хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэр гаргах бөгөөд шийдвэрийг Хууль зүйн хорооны дарга гарын үсэг зурж баталгаажуулна.

4.9.Хууль зүйн хорооны шийдвэр нь зөвлөмж, тэмдэглэл хэлбэртэй байна.

4.10.Хууль зүйн хороо улиралд нэгээс доошгүй удаа хуралдана.

4.11.Хуралдаанд оролцсон гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд асуудлыг хуралдаан даргалагчийн саналаар шийдвэрлэнэ.

4.12.Хууль зүйн хорооны хуралдаанд холбогдох албан тушаалтнаас гадна шаардлагатай тохиолдолд бусад төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөгч, асуудлыг нь хэлэлцэж буй хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч, эсхүл эцэг эх асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хууль ёсны төлөөлөгч зөвшөөрсөн тохиолдолд тухайн хүүхдийг өөрийг нь байлцуулж болно.

4.13.Хууль зүйн хороо үйл ажиллагааны тайланг хагас жил тутам нэг удаа аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж, жилд нэг удаа орон нутгийн Хүүхдийн төлөө зөвлөлд тайлагнана.

4.14.Сумын хүүхдийн эрхийн хууль зүйн хороо нь Хууль зүйн хорооны төлөвлөгөө, даалгасан чиг үүргийн хүрээнд хийж гүйцэтгэсэн үйл ажиллагааны тайланг аймгийн Хууль зүйн хороонд хүргүүлнэ.

4.15.Хууль зүйн хороо тайлангаа аймаг, дүүргийн төрийн захиргаа, удирдлагын асуудал хариуцсан нэгжээр дамжуулж холбогдох байгууллагад хүргүүлнэ.

Тав. Хууль зүйн хорооны Ажлын алба

5.1.Хууль зүйн хорооны өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Ажлын алба нь дараах үүргийг хүлээнэ:

5.1.1.Хууль зүйн хорооны өдөр тутмын үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, шийдвэрийн хэрэгжилтийг хангах;

5.1.2.Хууль зүйн хорооны үйл ажиллагаа болон иргэд байгууллагаас гаргасан өргөдөл, гомдол, санал, хүсэлттэй холбоотой мэдээллийг шийдвэрлүүлэх;

5.1.3.Хууль зүйн хорооны хуралдааны бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулах, холбогдох баримт бичгийн төслийг боловсруулах, албажуулах, сурталчлах, хорооны албан хэрэг хөтлөлт, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих;

5.1.4.Хууль зүйн хорооны гишүүд болон хамтран ажилладаг байгууллагын албан хаагчдыг чадавхижуулах ажлыг зохион байгуулах;

5.1.5.энэ журамд заасан хүүхдэд үйлчилгээ үзүүлэх ажлыг төлөвлөх, өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах, тайлагнах;

5.1.6.хууль тогтоомжид заасан бусад.

5.2.Ажлын алба нь Хууль зүйн хорооны үйл ажиллагаатай холбоотой судалгаа, мэдээллийн сан бүрдүүлнэ.

5.3.Ажлын албаны дарга дараах тохиолдолд Хууль зүйн хорооны гишүүнийг нөхөн томилуулах асуудлыг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ.

5.3.1.өөр ажилд томилогдсон;

5.3.2.үүрэгт ажлаасаа чөлөөлөгдсөн, халагдсан;

5.3.3.гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутайг нь шүүхээр тогтоосон.

5.4.Ажлын алба нь хууль зөрчсөн хүүхдэд дараах туслалцаа, үйлчилгээг үзүүлэх ажлыг зохион байгуулна.

5.4.1.хууль зөрчсөн хүүхдийн мэдээллийг цагдаагийн байгууллага болон бусад этгээдээс хүлээн авсан даруй хууль зөрчсөн хүүхэд эсхүл хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчтэй уулзах уулзалтыг зохион байгуулах;

5.4.2.хүүхэд дахин хохирох, дахин гэмт хэрэг үйлдэж болзошгүй гэж үзвэл нөхцөл байдлын үнэлгээ хийлгэх тухай санал боловсруулах;

5.4.3.өмгөөлөгчөө сонгох боломжгүй, өмгөөлөгч авах төлбөрийн чадваргүй нь тогтоогдвол Өмгөөлөгчдийн холбоо болон бусад холбогдох байгууллагад хандах, өмгөөлөгч томилуулах эсхүл Хууль зүйн туслалцааны төвд хандан улсын өмгөөлөгч авах боломжоор хангах;

5.4.4.Нөхцөл байдлын үнэлгээг үндэслэн хууль зөрчсөн хүүхэд болон түүний эцэг эх, хамтарсан баг, бусад оролцогчидтой ажиллах төлөвлөгөө боловсруулах;

5.4.5.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох хэлмэрч, орчуулагч, багш, сурган хүмүүжүүлэгч, хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагын ажилтан болон бусад ажилтантай холбоо тогтоож оролцуулахад дэмжлэг үзүүлэх;

5.4.6.хууль зөрчсөн хүүхдийн буруу зан үйлийг засах, хичээлийн хоцрогдлоо арилгах, нийгэмших, өөрийгөө хөгжүүлэх, мэргэжлийн чиг баримжаа олгох, эрүүл мэндийн үйлчилгээ авах зэрэг тухайн хүүхдийн сэтгэл зүй, боловсрол, эрүүл мэндийн хэрэгцээ шаардлагад нийцсэн тусламж, үйлчилгээнд хамруулах;

5.4.7.Хүүхэд хамгааллын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-д заасны дагуу хүүхдэд батлан даагч томилуулах тухай саналыг эрх бүхий байгууллагад гаргах;

5.4.8.Хэрэг хянан шийдвэрлэх явцад хууль зөрчсөн хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн тухай гомдол саналыг хүлээн авах, гомдлын мөрөөр эрх ашгийг хамгаалах эрх бүхий этгээдийг томилон, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулж, эрх ашгийг хамгаалах арга хэмжээ авах;

5.4.9.хууль тогтоомжид заасан бусад.

5.5.Ажлын алба нь гэмт хэргийн хохирогч болсон хүүхдэд дараах туслалцаа, үйлчилгээг үзүүлэх ажлыг зохион байгуулна:

5.5.1.хохирогч хүүхдийн мэдээллийг цагдаагийн байгууллагаас авсны дараа хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчтэй уулзах уулзалтыг даруй зохион байгуулах;

5.5.2.хохирогч хүүхдийн талаарх мэдээллийг хүлээн авсан даруй цагдаагийн байгууллагад мэдэгдэх;

5.5.3.сум, хорооны нийгмийн ажилтны хийсэн нөхцөл байдлын үнэлгээнд тулгуурлан хохирогч хүүхэд, түүний эцэг эх, хамтарсан баг, бусад оролцогчтой хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулах, нийгэм сэтгэл зүйн, эрүүл мэндийн, хууль эрх зүйн болон бусад шаардлагатай үйлчилгээ, зөвлөгөө, туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулах;

5.5.4.хохирогч хүүхэдтэй эвлэрэх ажиллагааг ямар хэлбэрээр зохион байгуулах, хэзээ, хэрхэн оролцуулах талаар хохирогч түүний хууль ёсны төлөөлөгч, шаардлагатай гэж үзвэл тэдний хүсэлтээр өмгөөлөгч бусад этгээдүүдийг оролцуулан зөвлөлдөж, шийдвэр гаргахад нь дэмжлэг үзүүлэх;

5.5.5.зөрчил гэмт хэргийн улмаас хохирогч хүүхдэд учруулсан хохирол гэм хорыг хууль зүйн дагуу барагдуулах, зайлшгүй шаардлагатай эмчилгээ, үйлчилгээний төлбөрийг урьдчилан гаргуулах ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;

5.5.6.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч сэтгэл зүйч, хэлмэрч, орчуулагч, сурган хүмүүжүүлэгч, нийгмийн ажилтан, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагын ажилтан болон бусад шаардлагатай ажилтантай холбоо тогтоож, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хүндрэл бэрхшээлгүй шуурхай явуулахад хууль тогтоомжийн хүрээнд дэмжлэг үзүүлэх;

5.5.7.хохирогч хүүхдээс мэдүүлэг авах, хохирогчийг шүүх хуралд оролцуулах тусгай нөхцөл боломжийг бүрдүүлсэн орчныг бий болгох асуудлаар цагдаа, прокурор, шүүх байгууллагатай хамтран ажиллах;

5.5.8.өмгөөлөгч авах хүсэлт гаргасан, төлбөрийн чадваргүй хохирогч хүүхдийн эрхийг хангах асуудлыг холбогдох байгууллагад уламжилж, дэмжлэг үзүүлэх;

5.5.9.гэмт хэргийн гэрч, хохирогч болсон хүүхдэд хамгаалалтын арга хэмжээ шаардлагатай тохиолдолд хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгчийн хүсэлтээр Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх талаар холбогдох туслалцаа, дэмжлэг үзүүлэх;

5.5.10.хэрэг хянан шийдвэрлэх явцад хохирогч хүүхдийн эрх ашиг зөрчигдсөн тухай гомдол саналыг хүлээн авах, гомдлын мөрөөр хүүхдийн эрх ашгийг хамгаалах эрх бүхий этгээдийг томилон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах, эрх ашгийг хамгаалах арга хэмжээ авах;

5.5.11.хууль тогтоомжид заасан бусад.

5.6.Ажлын алба нь гэмт хэргийн гэрч болсон хүүхдэд дараах туслалцаа, үйлчилгээг үзүүлнэ:

5.6.1.гэмт хэргийн гэрч болсон хүүхдийн мэдээллийг цагдаагийн байгууллага болон бусад этгээдээс хүлээн авсны дараа цагдаагийн байгууллагын саналыг харгалзан гэрч болон түүний хууль ёсны төлөөлөгчтэй уулзах уулзалтыг зохион байгуулах;

5.6.2.сум, хорооны цагдаа болон нийгмийн ажилтан нь гэмт хэргийн гэрч болсон хүүхэд, түүний хууль ёсны төлөөлөгчтэй уулзаж, Хууль зүйн хорооноос гэрч хүүхдэд үзүүлж болох үйлчилгээ, зөвлөгөө, туслалцааг танилцуулж, хамтран ажиллах боломжийг санал болгох;

5.6.3.гэмт хэргийн гэрч хүүхэд, түүний хууль ёсны төлөөлөгчид хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа болон гэмт хэргийн гэрч болсон хүүхэд, түүний хууль ёсны төлөөлөгч энэ ажиллагаанд ямар эрх, үүрэг, хариуцлагатай оролцох талаар хууль зүйн зөвлөгөө өгөх;

5.6.4.гэмт хэргийн гэрч болсон хүүхэд, түүний хууль ёсны төлөөлөгч нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүүхдийн эрх, ашиг сонирхол, хувийн халдашгүй байдал зөрчигдсөн, цагдаагийн алба хаагч, прокурор, өмгөөлөгчийн зүгээс ёс зүйн зөрчил гаргасан, эрх ашгийг хохироосон зэрэг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны сөрөг нөлөөллийн талаар Хууль зүйн хороонд гомдол

гаргасан тохиолдолд хүүхдийн эрх ашгийг хамгаалахаар хуульд заасан арга хэмжээг хэрэгжүүлэх;

5.6.5.гэмт хэргийн гэрч болсон хүүхдийн эрх, ашиг сонирхол хууль ёсны төлөөлөгчтэй зөрчилдсөн нь тогтоогдсон тохиолдолд хорооноос хүүхдийн эрх ашгийг төлөөлөн хамгаалах эрх бүхий этгээдийг томилуулах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах ажлыг зохион байгуулах;

5.6.6.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч сэтгэл зүйч, хэлмэрч, орчуулагч, сурган хүмүүжүүлэгч, нийгмийн ажилтан, хүүхдийн эрхийн ажилтантай холбоо тогтоож хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хүүхдэд хүндрэл бэрхшээлгүй шуурхай явуулах ажлыг зохион байгуулах;

5.6.7.гэмт хэргийн гэрч болсон хүүхдээс мэдүүлэг авах, гэрчийг шүүх хуралд оролцуулах тусгай нөхцөл боломжийг бүрдүүлсэн орчныг бий болгох асуудлаар цагдаа, прокурор, шүүхийн байгууллагатай хамтран ажиллах;

5.6.8.хууль, тогтоомжид заасан бусад.

5.7.Ажлын албанаас үйлчилгээ авч буй хүүхдийн оршин суух сум, хорооны хамтарсан баг, бусад талтай хамтран төлөвлөгөө гарган ажиллаж болно.

5.8.Ажлын алба энэ журамд заасан хүүхдийн асран хамгаалагч, харгалзан дэмжигч, гэр бүлийн гишүүд, сургууль, хамт олонд зөвлөгөө өгч, тогтмол хугацаанд уулзалт, ярилцлага зохион байгуулж, үр дүнг тооцно.

5.9.Ажлын алба нь хууль, зөрчсөн хүүхдийн эрүү, зөрчлийн хэрэг, хувийн мэдээлэл, Хууль зүйн хорооноос үзүүлсэн үйлчилгээг агуулсан хувийн хэргийг хүүхэд бүрт нээж баримтжуулан хадгалах ба үйлчилгээ үзүүлж дууссаны дараа Хууль зүйн хорооны бүртгэл мэдээллийн санд шаардлагатай мэдээллийг оруулж, хувийн хэргээс төрийн болон албаны, байгууллагын болон хувь хүний нууцад хамаарахгүй баримт мэдээллийг түүний хууль ёсны төлөөлөгчид хүлээлгэн өгнө.

5.10.Ажлын алба нь хууль зөрчсөн хүүхдийн мэдээллийг бүртгэх, мэдээлэх, гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг тогтоож түүнийг арилгах, дахин гаргахгүй байх арга хэмжээг авах талаар орон нутаг дахь төрийн захиргааны болон хуулийн байгууллагуудтай хамтран ажиллана.

Зургаа. Хууль зүйн хорооны үйл ажиллагааны хяналт

6.1.Хууль зүйн хорооны үйл ажиллагаанд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын болон Хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Хүүхдийн төлөө үндэсний болон орон нутгийн зөвлөл хяналт тавина.

Долоо. Бусад

7.1.Хууль зүйн хорооны үйл ажиллагаанд шаардлагатай төсвийг орон нутгийн төсөвт тусгаж, хэрэгжүүлнэ.

--- оОо ---

2. ХУУЛЬЧИЙН НИЙТЭД ТУСТАЙ МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА БА ПРО БОНО ҮЙЛЧИЛГЭЭ

Сүүлийн үед манай оронд дэлгэрэн хөгжиж буй хуульчдын сайн дурын мэргэжлийн үйлчилгээ болох «Про боно»-г Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны эрх зүйн үйлчилгээнд өргөн ашиглах боломжтой юм.

“Про боно” буюу нийтэд тустай сайн дурын үйл ажиллагаа гэдэг нь Латин хэлний “Pro bono publico” буюу “Олон нийтийн сайн сайхны төлөө” гэсэн үгнээс гаралтай. Олон улсын хуульчдын дунд “Про боно” хөдөлгөөн нь өргөн дэлгэрч байгаа бөгөөд шууд утгаараа хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааг үнэ төлбөргүйгээр сайн дураараа явуулах гэж ойлгодог болоод байна.

Манай улсад Хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааг “Хуульчийн эрх зүйн байдлын тухай” хууль батлагдан гарахаас өмнө “Өмгөөллийн тухай хууль”-д “өмгөөлөгч бүр жилд төлбөрийн чадваргүй хоёр иргэнд өмгөөллийн үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлнэ” гэж зөвхөн төлбөрийн чадваргүй иргэнд л өмгөөллийн үйлчилгээг үзүүлэх тухай зохицуулалт байсан бол 2012 онд батлагдсан “Хуульчийн эрх зүйн байдлын тухай” хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.6 зүйлд “Хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа” гэж «хуульчийн хувьд бусдаас хөлс авахгүйгээр нийтийн тусын тулд болон нийгмийн эмзэг хэсгийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах зорилгоор үзүүлж байгаа хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ, эрх зүйн иргэний боловсролыг дэмжих аливаа үйл ажиллагааг ойлгоно” хэмээн хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааны цар хүрээг нэлээд өргөн хэмжээнд тодорхойлж өгсөн. Хуульчид бидний хувьд дээрх тодорхойлолтод заасан ажлуудыг товчхондоо хуульчийн “Про боно” үйл ажиллагаа гэж нэрлээд нэлээдгүй хугацаа өнгөрсөн байна.

Хуульчийн эрх зүйн байдлын хуульд зааснаар хуульчдын холбоо нь чиг үүргийн болон сайн дурын хороодоор дамжуулан үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд эдгээрийн нэг нь Хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх хороо юм. Энэхүү хороо нь 2013 оны 8 дугаар сард МӨХ-ны гишүүн 20 өмгөөлөгчдийн үүсгэл санаачилгаар байгуулагдан дүрмээ баталж, Монголын Хуульчдын Холбооны анхдугаар их хурлаар баталгаажуулж, улмаар МХХ-ны Зөвлөлийн 2013 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 19 тогтоолын хавсралтаар “Хуульчийн нийтэд тустай үйл ажиллагааны журам”-ыг баталснаар үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн.

«Хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааны журам»-д хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааг дараах 4 чиглэлээр явуулахаар заасан байна. Үүнд:

1. Нийгмийн эмзэг хэсгийн иргэдэд Захиргааны зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагаа, Эрүүгийн байцаан шийтгэх, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд үзүүлэх хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ;
2. Хүмүүнлэгийн, соёл, боловсролын зэрэг чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагын үйл ажиллагааны үндсэн зорилгод нь хамаарах асуудлаар үзүүлэх хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ;
3. Хүний эрхийг хамгаалах зорилготой үйл ажиллагаа явуулдаг хувь хүн, төрийн бус

байгууллага, бүлгийн үйл ажиллагааны үндсэн зорилгод нь хамаарах асуудлаар үзүүлэх хууль зүйн үйлчилгээ;

4. Хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн хууль, нийтээр дагаж мөрдөх бусад хууль тогтоомжийг хүчингүй болгуулах асуудлаар эрх бүхий этгээдэд хандан шийдвэрлүүлэх үйл ажиллагаа явуулах / стратегийн өмгөөллийн/;

Мөн дор дурдсан үйл ажиллагааг хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаанд тооцож болно гэж заасан байна. Үүнд:

1. хуульчаас байгаль орчин, нүүдлийн уламжлалт мал аж ахуй, соёлын өв, нийтийн эрүүл мэнд, боловсрол, дэд бүтэц, хэрэглэгчийн эрх зэрэг нийтийн эрх ашгийг хамгаалах болон тухайн чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг хувь хүн, төрийн бус байгууллага, бүлэгт үзүүлж буй хууль зүйн үйлчилгээ;
2. эрх зүйн иргэний боловсролыг дэмжих зорилгоор иргэд, олон нийтэд зориулан олон нийтийн мэдээллийг хэрэгслээр хууль тогтоомжийг сурталчлах, сургалт зохион байгуулах;
3. хуульч нь хүний эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага, түүнчлэн эрх зүйн шинэтгэл, хууль зүйн боловсрол, шинжлэх ухааны хөгжилд зориулж санхүүгийн болон эд материалын дэмжлэг үзүүлэх;
4. хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны чиглэлээр хууль зүйн сургуулийн оюутнуудад зориулсан төрөл бүрийн арга хэмжээ, сургалт зохион байгуулах өөрөөр хэлбэл хуульч мэргэжлийн нийтэд тустай ажил үйлчилгээ.

Монголын хуульчдын дунд Про боно соёл түгэн дэлгэрч, хөдөлгөөн болон өрнөж байна.

Монголын хуульчдын холбооны хуулиар хүлээсэн чиг үүргүүдийн нэг бол “хуульчийн нийтэд тустай үйл ажиллагааг зохион байгуулах” бөгөөд энэ чиг үүргээ ХНТМҮАЭХ-(Хуульчдын нийтийн тустай мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх хороо)оор дамжуулан хэрэгжүүлж байна.

Монголын хуульчдын дунд “Про боно” соёлыг түгээх, хуульч бүрийн нийгмийн өмнө хүлээх хариуцлага бол хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааг үнэ төлбөргүй сайн дураараа явуулах явдал гэдгийг сурталчлан таниулах зорилгоор 2017 оноос эхлэн “Хуульчийн Про боно” чуулга уулзалтыг жил бүр зохион байгуулж байна. 2018 оны 12 дугаар сард зохион байгуулсан “Хуульчийн нийгмийн хариуцлага-Про боно” чуулга уулзалтаас жил бүрийн 5 дугаар сарын 1-ний өдрийн “Монголын хуульчдын Про боно” өдөр болгох санаачилга гарч улмаар Монголын хуульчдын холбооны Ерөнхийлөгчийн 2019 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн тушаалаар жил бүрийн 5-р сарын 1-ний өдрийг “Монголын хуульчдын Про боно өдөр” болгон зарлаж энэ жил анх удаагаа Нийслэлийн 9 дүүрэг, 21 аймгийн төв талбайд Монголын Хуульчдын Холбоо нь Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын Ерөнхий прокурорын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Хууль зүйн туслалцааны төв, Нотариатчидын танхим, өмгөөллийн нөхөрлөлүүдтэй хамтран анх удаагаа иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн зөвлөгөө, мэдээлэл өгөх, шүүхийн лавлагаа, нотариатын зарим үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлэх зэрэг хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл

ажиллагааг зохион байгуулсан. Мөн Монголын хуульчдын холбоо нь Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөрийн хүрээнд 2018 оны 6 сараас эхлэн Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран нийслэлийн нэг цэгийн үйлчилгээний төвүүд дээр сар бүрийн гурав дахь долоо хоногийн Лхагва гариг бүр иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн зөвлөгөө өгөхөөс “www,Legalaid.mglbar.mn” буюу “Про боно зөвлөгөө” сайтыг ажиллуулж иргэд онлайнаар хуульчтай холбогдон үнэ төлбөргүйгээр, хүссэн хууль зүйн анхан шатны зөвлөгөөг үнэ төлбөргүй авдаг болоод байна.

Мөн Монголын хуульчдын холбооны гишүүн хуульчид тогтмол хүүхдийн эрхийг хамгаалсан нийтэд тустай Про боно үйл хэргийг явуулж ирсэн юм. Про боно үйлстэн хуульчийн нэгэн төлөөлөл болсон хуульч Х.Баасанжаргал нь 2018 онд Итали улсын Ром хотноо зохион байгуулагдсан Олон улсын Барын холбооны хуульчдын нэгдсэн чуулга уулзалтаас “Дэлхийн шилдэг Про боно хуульч”-аар шалгарсан нь бид бүгдийн бахархах зүйл яах аргагүй мөн юм. Тэрээр дэлхийн 190 орны хуульчдыг багтаасан энэ том байгууллагаас дээрх шагналыг авсан гол үндэслэл нь Хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр стратегийн өмгөөлөл хийж “Өвөл хаврын цагт бага насны хүүхдээр хурдан морь унуулж уралдуулах тухай” Засгийн газрын тогтоолыг захиргааны хэргийн шүүхээр хүчингүй болгуулсан явдал юм. Мөн хүүхдийн эрхийг хамгаалахад чиглэсэн стратегийн /Про боно/ өмгөөлөл болон хүүхдийг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх Про боно сургалтуудыг манай хуульчдад байнга зохион байгуулсаар ирсэн билээ.

Про боно олон улсын түвшинд.

Америкийн Нэгдсэн улсын иргэн, хуульч Брюс Ласкигийн санаачилгаар анх Азийн хуульчдын Про боно форумыг анх 2012 он Лаос улсад, хоёр дахь форумыг 2013 онд Вьетнам улсад, 2014 онд Сингапур улсад, 2015 онд Мьянмар улсад, 2016 онд Индонез улсад, 2017 онд Малайз улсад, БНХАУ-ын Засаг захиргааны тусгай нэгж болох Хонг Конгод 2018 онд, 2019 онд Непал улсад тус тус зохион байгуулагдсан юм.Энэ Про боно форумд сүүлийн жилүүдэд Монголын хуульчид тогтмол оролцож, Азийн хуульчдын Про Боно туршлагаас суралцаж, өөрийн орны хуульчдын холбооноос Про Боно үйл ажиллагаанд гүйцэтгэх үүргийн талаар болон хувь хуульчдынхаа Про боно үйл ажиллагааны туршлагын талаар илтгэл тавьж оролцож ирлээ.

Дэлхийн улс орнуудад хуульчийн Про боно үйл хэргийг зохицуулсан доорх журмууд байдаг. Жишээ нь

БНСУ

Өмнөд Солонгост хуульчдыг жилд дор хаяж 20-30 цагийн Про боно ажил хийх үүрэгтэй байдаг. Энэ үүргээ мөнгөн төлбөрөөр биелүүлэх боломжтой бөгөөд оронд нь цагийн 20,000-30,000 вон (17-26 ам.доллар) төлж болдог зохицуулалтай байдаг.

Англи

Умард Ирландын Нэгдсэн Ван улс 2003 оноос хойш Их Британийн олон хуулийн байгууллага, хуулийн сургуулиуд жил бүр Про Боно долоо хоногийг тэмдэглэн өнгөрүүлдэг бөгөөд энэ ажлын хүрээнд оюутнуудад Про боно үйл хэргийг тайлбарлан таниулах мөн дээрх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хуульч нар бусад мэргэжлийн хүмүүсээс туршлага судалдаг байна

АНУ

Америкийн барын холбоо өөрийн гэсэн про боно дүрэм журамтай байдаг бөгөөд мужуудад ч тусгай журмаар Про боно үйл хэргийг зохицуулсан байдаг. АНУ-ын хуульчдыг Америкийн Хуульчдын Холбооны (ABA) ёс зүйн дүрмийн дагуу жилд дор хаяж 50 цагийн Про боно үйлчилгээ үзүүлэхийг зөвлөж ажилладаг байна. Муж бүр өөрийн гэсэн эрх зүйн зохицуулалттай бөгөөд Нью-Йоркт хуульч доод тал нь 50 цагийн үнэ төлбөргүй зөвлөгөө өгөхийг шаарддаг бол Иллинойс мужид заавал үүрэг болгодоггүй бөгөөд харин шилдэг Про боно хуульчийг шалгаруулах замаар зохицуулсан байдаг.

Энэтхэг

Энэтхэгт өмгөөлөгчөөр ажиллаж байгаа хүмүүс шүүгч болоход та про боно үйл хэрэгт хэр оролцож байсан бэ? гэдэг нь шүүгчээр ажиллахад сонгогдох гол шалгуур болдог. Про боно үйл хэрэгт зөвхөн хуульчид оролцоод зогсохгүй мэргэжлийн хуульчаар удирдуулсан сайн дурын иргэдийн эрхийг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх чиглэлээр ажилладаг сайн дурын бүлгэмүүд олон байдаг байна.

Австрали

Австралид хуулийн компаниуд байгаль орчны чиглэлээр дийлэнхдээ Про боно үйл ажиллагаа явуулдаг бөгөөд байгаль орчныг нөхөн сэргээлгэх болон бусад Про боно өмгөөллийн ажил нь амжилттай болсон тохиолдолд тухайн компанийг төлөх ёстой татвараас тодорхой хувиар хөнгөлөлт үзүүлэх буюу чөлөөлдөг хуулийн зохицуулалттай байдаг.

Сингапур, Хонг Конг

Сингапур, Хонконгд Про боно соёл гэдэг ойлголт хуулийн фирмүүдийнх нь дунд аль хэдийн тогтсон бөгөөд тэдгээр хуулийн фирмүүд про боно үйлсээрээ хоорондоо өрсөлддөг болоод нилээн хугацаа өнгөрчээ. Мөн Сингапур, Хонконгд хуулийн сургуулийн оюутнуудын үзэх хичээлд Про боно хичээл ордог бөгөөд оюутнуудыг Про боно үйл хэрэгт оролцох шаардлагыг сургуулийн зүгээс тавьдаг байна. Мөн тэдгээр улсуудын шүүх, прокурор, өмгөөллийн байгууллагууд нь Про боно үйл хэргийг хөгжүүлэх тал дээр нягт хамтран ажилладаг нь Про боно соёл хөгжихөд ихээхэн түлхэц өгдөг байна.

3. ХҮҮХДИЙН ЭРХИЙН ХУУЛЬ ЗҮЙН ХОРООНЫ ТАЛААРХ ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА, ЧИГ ХАНДЛАГА /ХЗҮХ-ИЙН СУДАЛГААНААС/:

Монгол Улсад ажиллаж буй Хүүхдийн Эрхийн Хууль Зүйн хороотой адил зорилго бүхий байгууллага гадаадын зарим улсуудад ямар чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, ямар бүтэц зохион байгуулалтаар ажилладаг болохыг Хууль зүйн үндэсний хүрээлэн⁵² харьцуулан судалсан судалгаанаас толилуулж байна.

52 Хүүхдийн асуудал хариуцах хорооны дүрмийг боловсронгуй болгох, хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах судалгаа. 481-482 лахь тал. ХЗҮХ, 2009 он.

3.1. КАНАДЫН ТУРШЛАГА

Канад улсад энэ чиглэлээр “Канадын 2 дахь боломж хөтөлбөр” нэртэйгээр хэрэгжиж байсан байна. Тус улсад энэхүү хөтөлбөрийн дагуу хүүхдийн гэмт хэргийн асуудлыг Төрийн бус байгууллага хариуцдаг байна. Прокурор гэмт хэрэг үйлдсэн хүүхдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлж, эсхүл шүүхээс хүүхдэд оногдуулсан ялыг хойшлуулж, хүүхдийг дээрх хөтөлбөрт хамруулдаг ажээ. Уг хөтөлбөрийн дагуу дээр дурдсан хүүхдийг дор дурдсан 2 үе шатаар амьдралын ухаанд сургах буюу амьдралд чиглүүлэх үйл ажиллагаа явуулдаг байна. Үүнд: I үе шат: 12 долоо хоногийн сургалтад хамруулж амьдрах ухаан, техник мэдлэг, гар урлал, мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагаанд хамруулах, сургуульд нь буцаан оруулахад бэлтгэх; II үе шат: “9 долоо хоногийн ажлын байр” нэртэй үе шат. Энэ үе шатанд төрийн байгууллагатай хамтран хүүхдийг ажлын байраар хангах, сайр дурын этгээдийн тусламжтайгаар олон нийтийн ажил, тэр дундаа олон нийтийн цэвэрлэгээний ажилд хамруулах үйл ажиллагаа явуулдаг байна.

3.2. ӨМНӨД АФРИКИЙН ТУРШЛАГА

Өмнөд Африкт “Өсвөрчдийг чадваржуулах бүдүүвч” нэртэй хөтөлбөр хэрэгжиж байсан байна. Энэ бүдүүвчийн дагуу дараах үйл ажиллагаа явуулдаг байна. Үүнд:

- Хүүхдийг байцаан шийтгэх ажиллагаанаас хөндийрүүлж, амьдрах ухааны хөтөлбөрт хамруулах;
- Ял хойшлуулагдсан хүүхэдтэй ажиллах ажилтныг томилох, түүнд зориулсан 8 долоо хоногийн сургалтыг 7 хоногт нэг удаа хагас өдрөөр хийх ба энэхүү сургалтаар дараах сэдэв бүхий хичээлийг заадаг байна.
 - Дахин гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэх зорилгоор нийгмийн үнэлэмж, дэг журам;
 - Гэмт хэргийн хор уршиг, учир холбогдол, ухамсар, хувийн хариуцлага, шийдвэр гаргалт гэх зэрэг;
- Эцсийн 7 хоногт хүүхэд, эцэг, эхийг хамтад нь сургалтад оролцуулж, эцэг эх, хүүхдийн хамтын харилцааны талаар сургадаг байна.

3.3. ТАЙЛАНДЫН ТУРШЛАГА

Тайланд улс олон улсын хэмжээнд нэлээд шинэ хандлага загварыг бий болгосон бөгөөд хүч хэрэглэсэн гэмт хэргээс бусад төрлийн гэмт хэрэг үйлдсэн хүүхдийн асуудлыг хариуцаж ажилладаг.

Шүүх хорих ял оногдуулалгүй, олон нийтийн хяналтад тодорхой хугацаагаар байлгахаар шийдвэрлэсэн тохиолдолд хүүхдийг эцэг, эх хариуцна.

Мөн хүүхдийг олон нийтэд тустай ажил хийлгэх, мэргэжил олгох сургалт, ажлын байраар хангах, хүүхдийн оролцооны хөтөлбөр, хүүхдийн зуслан гэх мэтэд хамруулах замаар хүүхдийг засарч хүмүүжүүлэх зорилго бүхий байгууллага байдаг байна.

Үүний эцэст шүүгч хүүхэд, эцэг, эхтэй ярилцаж, хүүхдийн зан үйлийн өөрчлөлтийг хянадаг. Хэрэв хүүхэд засарсан гэж үзвэл ялыг хүчингүй болгох тогтолцоо, эрх зүйн зохицуулалт байдаг ажээ.

3.4. АНУ-ЫН ТУРШЛАГА

АНУ-д хүүхдийн гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг тогтоосны үндсэн дээр хэргийг шийддэг бөгөөд хүүхдийн хэргийг “Холимог салбар” хариуцдаг байна. Холимог салбар нь хувийн төлөвшлийн эрсдэлтэй, гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүйчүүдэд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг. Холимог салбараас сургагдсан нийгмийн ажилтан хүүхдийн гэр бүлтэй нягт ажилладаг ба нэг бүрчилсэн болон бүлгийн зөвлөгөө өгөх арга хэмжээ авдаг байна. Өөр хүний байр сууринаас асуудалд хандах, итгэл үнэмшлийг өөрчлөх, хүсэл сонирхлыг өөрчлөх, хүсэл сонирхол, тэмүүллийг өөрчлөн сайжруулна.

Нийгмийн ажилтан нь хүүхдийг таагүй орчноос хөндийрүүлэх, сөрөг нөлөөгүй арга хэмжээнд хамруулах, сургууль, олон нийтийн арга хэмжээнд хамруулах, нийгэм, хамт олны дунд байлгах зэрэгт анхаарна. Эцэг, эх нь хүүхдээ хараа хяналтдаа байлгах, дэмжих, туслах, таатай нийгмийн бүлэглэл, үйл ажиллагаанд хамруулдаг байна.

3.5. БОСНИЯ ГЕРЦЕГОВИНЫН ТУРШЛАГА

Босния Герцеговинд Чука сурган хүмүүжүүлэх төв ажилладаг. Түр байрлуулах төв нь ял хойшлогдсон хүүхдэд сургалт хүмүүжлийн болон мэргэжил олгох сургалтыг зохион байгуулах, хүүхдийн харилцааны чадвар, эцэг, эхийн чадварыг нэмэгдүүлэх, биеийн тамирын арга хэмжээ, тоглоом, олон нийтийн клуб ажиллуулах, Төрийн бус байгууллагатай хамтран ажилладаг. Уг төвд хүүхэд 6 болон 12 сарын туршид 7 хоногт 4 өдөр хүрэлцэн ирдэг. Орон нутгийн ял хойшлуулахыг хариуцах байгууллага нь өөрийн нэгжээ дээрх төвд байгуулдаг ба 2 ажилтан нь хөтөлбөрт хяналт тавьдаг. 8 сайн дурын ажилтан /сургуулийн оюутан/ ихэвчлэн өдөр тутмын үйл ажиллагааг хариуцдаг.

Хүүхдийн шүүх нь Чукагийн амжилтыг харгалзаж, хугацааг богиносгосон ба хорихын оронд хүмүүжлийн дээрх байгууллагад явуулдаг болсон байна.

4. ХҮҮХДИЙН ЭРХ, ХАМГААЛАЛТАЙ ХОЛБОГДОХ НЭР ТОМЬЁО, УХАГДАХУУНЫ ТАЙЛБАР ТОЛИОС

БАГА НАСНЫ ХҮҮХЭД - 1. Бага насны хүүхдийн эрхийг хангах үүднээс дөнгөж төрсөн нярайгаас эхлэн сургуулийн өмнөх боловсролоос бага сургуульд шилжих үеийг бага нас гэж Хүүхдийн эрхийн хороо үзэж байна. Ийм учраас хороо 8-аас доош насыг бага насны үе гэж тодорхойлох саналыг дэвшүүлж байна(Эх сурвалж: Хүүхдийн Эрхийн Хороо. 2005 он. Бага насны хүүхдийн эрхийг хангах ерөнхий зөвлөмж №7. 4-р заалт).2.“Бага насны хүүхэд” гэж арван дөрвөн насанд хүрээгүй хүнийг ойлгоно./Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/,10.1 дүгээр зүйлийн тайлбар. 2015 он).

БОЛГООМЖГҮЙ ХҮЧИРХИЙЛЭЛ -1. Хөнгөмсгөөр найдсан, эсхүл хайхрамжгүй хандсаны улмаас үүссэн хүчирхийллийн хэлбэр. үз. болгоомжгүй гэмт хэрэг. /Эрүүгийн хууль/ шинэчилсэн найруулга/, 2.3 дугаар зүйлийн 3./ 2.Өөрийн үйлдэл, эс үйлдэхгүйг хууль бус шинжтэй болохыг ухамсарлаж, түүний улмаас хохирол, хор уршиг учрах боломжтойг урьдчилан мэдэж, түүнийг гаргахгүй байж чадна гэж тооцсон боловч хохирол, хор уршиг учирсан, эсхүл хохирол, хор уршиг учрах боломжтойг урьдчилан мэдэх ёстой, мэдэх боломжтой байсан боловч мэдэлгүй үйлдсэний улмаас хохирол, хор уршиг учирсан гэм буруугийн хэлбэр.

БОЛЗОШГҮЙ ХҮЧИРХИЙЛЭЛ - 1. тухайн нөхцөл байдал нь гэр бүлийн хүчирхийлэлд хүргэхээр, эсхүл хүчирхийлэл дахин үйлдэгдэхээр байгааг хэлнэ.

БЭЛГИЙН ЗОРИЛГООР ХҮҮХДИЙГ УРУУТАТАХ -мэдээлэл харилцааны технологиор дамжуулан хүүхдийг бэлгийн харилцаанд оруулах, хүүхдийг садар самуунд уруу татах зорилгоор бэлгийн харилцаанд оруулах хуулийн насанд хүрээгүй хүүхдэд насанд хүрсэн хүний зүгээс санаатайгаар зүй бус санал тавихыг хэлнэ. (Бэлгийн Мөлжлөг болон бэлгийн хүчирхийллээс Хүүхдийг Хамгаалах Европын Консулын Конвенцын 23 дугаар зүйл, 2007 он)

БЭЛГИЙН МӨЛЖЛӨГ - 1. Бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг.(үз. бэлгийн халдашгүй байдал). Хохирогчид хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж; эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан бусадтай бэлгийн харьцаанд албадан оруулсан бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ(Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга. 12.3 дугаар зүйлийн 1, 2015 он).2. Ашиг орлого олох зорилгоор хүүхдийн биеийг нь үнэлүүлэх, хүүхдийг садар самуунд сурталчлах порнографийн бэлгийн үйл ажиллагаанд татан оролцуулахыг хэлнэ. 3. Хувийн ашиг сонирхол шунахайн сэдлийн улмаас хэн нэгнийг хүчээр биеийг нь үнэлүүлэх, хууль бус болон тааламжгүй бэлгийн харьцаанд оруулах зэргээр зүй бусаар харьцаж, хүчирхийлэхийг;(Азийн Хөгжлийн Сан. “Хүүхдийн хөдөлмөртэй холбогдолтой үйл ажиллагаанд хүүхдийн оролцоог сайжруулах талаар менежерүүдэд зориулсан гарын авлага”. УБ.,2014).

БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ -хүнийг /хүүхдийг/ бэлгийн таашаал авахдаа ашиглах, хүчирхийлэх, эдийн засгийн ашиг олохоор биеийг нь үнэлүүлэх үйлдэл.

ГАДУУРХАХ /гадуурхалт/ - үз.ялгаварлан гадуурхах. Бусдыг үл дотночлох, шоовдорлон үзэх дээрэнгүй үзэл. “Хүүхэд өөрийн яс үндэс, арьсны өнгө, нас хүйс, хэл соёл, шашин шүтлэг, үзэл бодол, нийгмийн гарал, эд хөрөнгө байдал, эрүү мэнд төрөлх нутаг, эцэг эх, хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн нөхцөл байдлаас болж ялгаварлан гадуурхагдах ёсгүй” хэмээн Хүүхдийн Эрхийн тухай Конвенцын хоёрдугаар зүйлд заасан байдаг.

цахим гадуурхал - цахим мэдээллийн хэрэгсэл, технологи ашиглан бусдын эсрэг (шоовдорлох, өөнтөглөх, гутаан доромжлох, нэр төрд нь халдах, улмаар хувийн нууцыг задруулах зэргээр) сөрөг мэдээлэл түгээх үйлдлийг;

цахим гэмт хэрэг - цахим мэдээллийн хэрэгсэл, программ хангамж ашиглан бусдыг дарамтлах, айлган сүрдүүлэх, хууран мэхлэх замаар үйлдэгдэх хүний эрх, эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийг;

ГЭРЧ БА ХОХИРОГЧ ХҮҮХЭД - 1. Тодорхой гэмт хэрэг буюу гэмт хэрэгт сэжиглэгдэж байгаа этгээд, эсхүл гэмт хэргийн бүлгийг эрэн сурвалжлах үйл явцад тэдний гүйцэтгэсэн үүргээс үл хамааран гэмт хэргийн гэрч буюу хохирогч болсон хүүхдийг;2.Гэмт хэрэгт ямар үүрэгтэй оролцсон нь хамаагүй сэжигтэн болон бүлэг сэжигтнийг шүүн таслах үйл ажиллагаанд оролцсон гэрч болон гэмт хэргийн хохирогч болсон 18 нас хүртэл хүүхэд болон өсвөр үеийнхнийг(Эх сурвалж:2005 онд гарсан Гэмт хэргийн гэрч, хохирогч хүүхдүүдийг шүүн таслах үйл ажиллагаанд оролцуулах гарын авлага).

ДАРАМТЛАХ -хүүхдийн төлөө хариуцлага хүлээсэн, эрх мэдэл бүхий, улмаар хүүхдийн итгэл хүлээсэн байх ёстой хэн нэгэн тэднийг үл хайхрах, бие махбод, бэлгийн,эсвэл сэтгэл санааны хүчирхийлэл зэрэг хохирлыг хүүхдэд учруулж зүй бусаар харьцахыг.

ЖЕНДЕРИЙН МЭДРЭМЖТЭЙ ТӨЛӨВЛӨЛТ - жендерийн мэдрэмжтэй төлөвлөлтийг өргөн утгаар нь хөтөлбөр, төслийн төлөвлөлт, хэрэгжилт, хяналт, үнэлгээний бүх шатанд жендерийн тэгш байдал ба эмэгтэйчүүдийг чадавхжуулах ажлыг нэгтгэсэн төлөвлөлт хэмээн тодорхойлдог. Жендерийн мэдрэмжтэй төлөвлөлт нь үйл ажиллагааны зорилго, зорилтыг томьёолох, стратеги, шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлох, уг үйл ажиллагаанд жендерийн үзэл баримтлалыг ямар арга замаар нэгтгэхээ сонгох, шаардагдах нөөцийг байршуулах зэрэг олон асуудлыг багтаадаг./Жендерийн нэр томьёо тодорхойлолт, үндсэн ойлголтуудын тайлбар толь. УБ, 2013 он/

ЖЕНДЕРИЙН МЭДРЭМЖТЭЙ ТӨСӨВ - жендерийн мэдрэмжтэй төсөв гэдэг нь жендерийн тэгш байдлыг болон эмэгтэйчүүдийн эрхийн хэрэгжилтийг сайжруулахад хувь нэмэр оруулах Засгийн газрын төлөвлөлт, төсвийн үйл явц юм. Салбарын болон орон нутгийн бодлого, төлөвлөлт, төсөвт байгаа жендерийн гажуудлыг илрүүлэх, түүнийг залруулах арга хэмжээг тусгах нь жендерийн мэдрэмжтэй төсвийн үйл явцын нэгэн хэсэг байдаг. Жендерийн мэдрэмжтэй төсөв нь 1) Нийгэмд жендерийн тэгш байдлыг хангахад чиглэсэн жендерийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлтийг дэмжсэн, тэдгээрийг хэрэгжүүлэх төсөв, 2) Салбар, байгууллагын жендерийн мэдрэмжтэй ажиллах чадавхыг сайжруулахад зориулагдсан тусгайлсан төсөв, 3) Тодорхой нэг тусгай анхаарал шаардаж буй бүлгийн ялгаатай хэрэгцээг хангахад чиглэсэн үйл ажиллагааны төсөв гэсэн хэлбэрүүдээр хэрэгжиж болно. Жендерийн мэдрэмжтэй төсөв нь мөн аливаа бодлого болон нөөц хөрөнгийн хуваарилалт, зарцуулалт нь эмэгтэй эрэгтэй хүмүүст, хөвгүүд охидод хэрхэн ялгаатай байдлаар нөлөөлж байгааг шинжлэх боломж олгодог. /Жендерийн нэр томьёо тодорхойлолт, үндсэн ойлголтуудын тайлбар толь. УБ, 2013 он/

ЖЕНДЕРИЙН ТЭГШ БАЙДАЛ - эмэгтэй, эрэгтэй хүмүүс нийгэмдээ болон хувийн амьдралын хүрээндээ эн тэгш үнэлэгдэж, тэгш эрх мэдэл, оролцоотой байна гэсэн үг юм. Тэгш байдлын тухай ойлголт цаг хугацаанд өөрчлөгдсөөр ирсэн. Тэгш байдлыг анхандаа хүмүүст хувийн болон бүлгийнх нь нөхцөл байдлаас үл шалтгаалан нэгэн адил байдлаар хандах явдал гэж ойлгож байжээ. Тэгш бус нөхцөлд тэгш хандах гэж оролдох нь ялгавартай байдлыг улам ихэсгэдэг болохыг ойлгосноор (үүнийг одоо жендерийн хувьд саармаг хандлага гэж нэрлэх болсон) орчин үед жендерийн тэгш байдлыг эмэгтэй эрэгтэй хүмүүст ялгаагүй хандах бус, харин нөхцөл байдлыг нь адил тэгш болгоход анхаарах явдал гэж ойлгох болсон байна. /Жендерийн нэр томьёо тодорхойлолт, үндсэн ойлголтуудын тайлбар толь. УБ, 2013 он/

ЖЕНДЕРИЙН ТЭГШ ЭРХ - эрэгтэй эмэгтэй хүмүүст тэдний тусгай буюу өвөрмөц хэрэгцээ, сонирхлынх нь дагуу тэгш шударга хандах хууль, эрх зүйн зарчим. Энэ нь тэгш хандлагыг, эсвэл ялгаатай боловч эдлэх эрх, хүртэх ашиг, хүлээх хариуцлага, боломж бололцооны хувьд адил тэгш байхад анхаарсан хандлагыг агуулна. Жендерийн тэгш эрх нь жендерийн тэгш байдлын салшгүй бүрэлдэхүүн хэсэг юм. Жендерийн тэгш эрхийг хангана гэдэг нь хүйс, орлого, арьсны өнгө, гарал угсаа зэрэг шинжээр ялгаварлагдахаас хүмүүсийг хамгаалахын тулд үл ялгаварлан гадуурхлыг хуульчлахаас гадна шударга бус байдлыг залруулах, нөхөн сэргээх арга хэмжээ авах нь хүйсийн тэгш эрхийг хангах арга зам болдог. Эмэгтэйчүүдэд эрэгтэйчүүдийн адил тэгш эрхтэй байр суурийг бүрдүүлэх явдал юм. Өөрөөр хэлбэл, эмэгтэйчүүдэд эрэгтэйчүүдийн нэгэн адил тэгш боломж олгох, тэднийг нийгмийн бүхий л хүрээнд бүрэн оролцуулах, оролцсоныхоо хэрээр тэнцүү ашиг хүртээх ойлголт мөн. /Жендерийн нэр томьёо тодорхойлолт, үндсэн ойлголтуудын тайлбар толь. УБ, 2013 он/

ЖЕНДЕРИЙН ТЭНЦВЭРТ БАЙДАЛ - аливаа үйл ажиллагаанд оролцож буй, эсхүл тодорхой үзүүлэлтэд хүрсэн охид хөвгүүдийн, эмэгтэй эрэгтэй хүмүүсийн тооны харьцааг илэрхийлдэг. Жендерийн тэнцвэр нь жендерийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны амжилтыг хэмжих хамгийн энгийн үзүүлэлт болон ашиглагдах нь элбэг байдаг ч эмэгтэй, эрэгтэй хүний оролцооны чанар, агуулгыг харуулдаггүй. Бичиг үсэгт тайлагдалт, сургуульд хамрагдалт зэрэг охид хөвгүүд, эмэгтэй, эрэгтэй хүний боловсрол эзэмшилтэд гарч буй амжилтыг харьцуулан хэмжих зорилгоор, НҮБ-ын БСШУ-ны байгууллага ЮНЕСКО-гоос Жендерийн тэнцвэрт байдлын хэмжүүр (GPI)-ийг ашигладаг болсон байна.

ЖЕНДЕРИЙН ХЭВШМЭЛ ОЙЛГОЛТ - (стереотип) нь эмэгтэй эрэгтэй хүмүүсийн, тодорхой бүлгүүдийн шинж төрх, ялгаа, гүйцэтгэх үүргийн тухайд нийгэм соёлын нөлөөгөөр төлөвшин тогтсон хялбаршуулсан ерөнхий ойлголт юм. Жендерийн хэвшмэл ойлголт нь эерэг, сөрөг ямар ч байж болох боловч бусдын талаар тодорхой бодитой мэдээлэл болж чаддаггүй бөгөөд шударга бус хандахын, аливаа шударга бус байдлыг зөвтгөхийн үндэс болж байдаг. Жендерийн хэвшмэл ойлголт нийгэм соёл бүрд харилцан адилгүйгээс гадна цаг хугацааны явцад өөрчлөгддөг боловч эмэгтэйчүүдийн захирагдмал, хамааралтай байр суурийг хадгалж бэхжүүлсэн түгээмэл шинжтэй байдаг. Тухайлбал эмэгтэй хүний тухайд гэрлэж, олон хүүхэд төрүүлдэг, үр хүүхдээ өсгөж хүмүүжүүлдэг, гэр бүлийнхээ сайн сайхны төлөө өөрийгөө золиослогч, асран халамжлагч, зөөлөн дуулгавартай, хоол цай хийдэг гол хүн гэх зэрэг, харин эрэгтэй хүний тухайд өрх гэрийг тэжээгч, өмч хөрөнгийг мэдэгч, зориг, тэвчээртэй, уйлдаггүй гэх зэрэг хэвшмэл ойлголт түгээмэл. Ийм маягийн хэвшмэл ойлголтууд нь эмэгтэй, эрэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, эзлэх байр суурийн талаар харилцан адилгүй хэм хэмжээг нийгэмд тогтоон хүлээлт үүсгэж, тодорхой дүрийг хувь хүмүүст тулгаж байдгаараа хувь хүний хөгжил дэвшил, өөрийгөө илэрхийлэхэд ихээхэн садаа болдог. / Жендерийн нэр томъёо тодорхойлолт, үндсэн ойлголтуудын тайлбар толь. УБ, 2013 он/

НАСАНД ХҮРЭЭГҮЙ ГЭМТ ХЭРЭГТЭН - үйлдсэн гэмт хэргийг нь насанд хүрсэн хүний гэмт хэргээс тусдаа арга барилаар холбогдох хууль зүйн тогтолцооны дагуу шийдвэрлэх ёстой хүүхдийг хэлнэ (1985 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 40/33 дугаар тогтоолоор батлагдсан Насанд хүрээгүй хүүхдийг шүүх ажиллагааг зохицуулах стандартын үндсэн зарчмууд).

НАСАНД ХҮРЭЭГҮЙ ГЭРЧ, ХОХИРОГЧ - гэмт хэрэгт ямар үүрэгтэй оролцсон нь хамаагүй сэжигтэн болон бүлэг сэжигтнийг шүүн таслах үйл ажиллагаанд оролцсон гэрч болон гэмт хэргийн хохирогч болсон 18-аас доош настай өсвөр насны хүүхэд(Эх сурвалж:2005 онд гарсан Гэмт хэргийн гэрч, хохирогч хүүхдүүдийг шүүн таслах үйл ажиллагаанд оролцуулах талаарх гарын авлага).

НАСАНД ХҮРЭЭГҮЙ ГЭРЧИЙГ БАЙЦААХ - арван зургаа хүртэл насны гэрчийг байцаахдаа сурган хүмүүжүүлэгчийг оролцуулна.Хэрэв шаардлагатай байвал түүний эцэг, эх буюу хууль ёсны бусад төлөөлөгч, эсхүл ойрын төрөл, садны хүн оролцуулж болно.Байцаалт эхлэхийн өмнө тэдэнд эрх, үүргийг нь тайлбарлан өгч, энэ тухай протоколд тэмдэглэнэ. Дээр дурдсан хүмүүс байцаалтад байлцаж, гэрчид асуулт тавьж болно. Мөрдөн байцаагч буюу хэрэг бүртгэгч дээр дурдсан хүний тавьсан асуултад хариу өгүүлэхгүй байх эрхтэй бөгөөд харин уг асуултыг протоколд тэмдэглэвэл зохино. Байцаалт дуусмагц мэдүүлэг зөв бичигдсэнийг баталж байцаалтад байлцсан хүмүүс гарын үсэг зурна.

НАСАНД ХҮРЭЭГҮЙ ГЭРЧИЙГ ДУУДАХ - насанд хүрээгүй гэрчийг эцэг, эх буюу түүний хууль ёсны төлөөлөгчөөр дамжуулан дуудна. Өөр журмыг гагцхүү хэргийн байдлаас шалтгаалан хэрэглэж болно.

НАСАНД ХҮРЭЭГҮЙ ХҮНД /ӨСВӨР НАСНЫ ХҮНД/ АВАХ ТАСЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

- өсвөр насны яллагдагч, шүүгдэгчид хуульд заасан үндэслэл, журмын дагуу таслан сэргийлэх арга хэмжээ авна. (хувийн баталгаа гаргах, тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх, хязгаарлалт тогтоох, барьцаа авах, цагдан хорих, цэргийн ангийн удирдлагад хянан харгалзуулах)

НАСАНД ХҮРЭЭГҮЙ ХҮНД ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЛГЭХ-1.

Насанд хүрээгүй этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлага нь эрүүгийн хуулийн дагуу хариуцлага (ял оногдуулах) хүлээвэл зохих нийгэмд хор аюултай үйлдлийн (эс үйлдэхүй) үр дагавар мөн(Защита детей. Глоссарий. ЮНИСЕФ. 2000).2. «Гэмт хэрэг үйлдэх үедээ арван дөрвөн насанд хүрсэн ба арван найман насанд хүрээгүй байсан хүнд хуульд заасан үндэслэл, журмын дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Өсвөр насны хүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлага нь түүний нас, биед тохирсон, эрүүл мэнд, ёс суртахуун, сэтгэцийн онцлогийг харгалзсан, нийгэмд өөрийн байр суурийг олоход туслах, боловсрол эзэмшүүлэх, үйлдсэн гэмт хэргийнх нь хор уршгийг ухамсарлуулах, гэмт хэрэг үйлдэхэд хүргэсэн орчин, хүмүүсийн нөлөөнөөс тусгаарлах, шаардлагатай тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнийг хорьж хүмүүжүүлэхэд чиглэсэн байна.

ОНЦГОЙ НӨХЦӨЛ - гэмт хэрэг үйлдээгүй боловч өөрийн амьдарч буй орчинд аюул учруулж болзошгүйн улмаас хүүхэд залуучууд шүүх эрх мэдлийн болон насанд хүрэгчдийн байцаан шийтгэх ажиллагаанд татагдан орж болзошгүй нөхцөл байдал үүссэнийг(Glossary on juvenile justice UNODC and UNICEF). Манай улсад 2008 оны 7 дугаар сарын 1-ний өдөр нийслэлийн Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт бүлэг хүмүүсийн хүч хэрэглэсэн хууль бус үйл ажиллагааны улмаас онцгой нөхцөл бий болж, энэхүү үйл ажиллагаанд олон хүүхэд хамрагдан оролцсон тул шүүхийн болон байцаан шийтгэх ажиллагаанд татагдан орсон билээ.

ОНЦГОЙ НӨХЦӨЛД БАЙГАА ХҮҮХЭД - байгалийн гамшиг, гоц халдварт өвчин, нийтийг хамарсан гэнэтийн осол, зэвсэгт мөргөлдөөнд өртсөн хүүхэд. Хүнд нөхцөлд байгаа хүүхэд-бүтэн өнчин, хөгжлийн бэрхшээлтэй, нэн ядуу, хараа хяналтгүй, хүчирхийлэл, үл хайхрах байдлын улмаас сэтгэл санаа, бие махбодын хохиролд орсон болон ийм байдалд орох өндөр эрсдэлтэй нь тогтоогдсон хүүхэд. Эдгээрийг 2016 оны Хүүхэд хамгааллын хуулиар “эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд” /үз/ гэх болсон.

ӨСВӨР НАСНЫ СЭЖИГТЭН - эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу баривчлагдсан, эсхүл яллагдагчаар татах тогтоолтой танилцуулахаар дуудагдсан өсвөр насны хүнийг сэжигтэн гэнэ.

ӨСВӨР НАСНЫ СЭЖИГТЭН, ЯЛЛАГДАГЧИЙГ ДУУДАН ИРҮҮЛЭХ - өсвөр насны сэжигтэн, яллагдагчийг түүний хууль ёсны төлөөлөгч, асран хамгаалагчаар дамжуулан дуудна.

ӨСВӨР НАСНЫ ХОРИГДОЛ - сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад ял эдэлж буй өсвөр насны хүн;(Х.Б). Хүүхдийн Эрхийн тухай Конвенцын үндсэн зарчмын дагуу насанд хүрээгүй хүнийг хорих тохиолдолд насанд хүрэгчдээс тусад нь байлгана.

ӨСВӨР НАСНЫ ХҮНИЙГ ХОРИХ - Шүүхийн өмнөх шатанд цагдан хорих арга хэмжээг боломжийн хэрээр байнгын хяналт, гэр бүл, сургуулийн орчинд хүмүүжлийн идэвхтэй ажил зохиох, гэр бүл буюу хүмүүжлийн байгууллага буюу газарт байлгах зэрэг өөр сонгох арга хэмжээгээр сольж өөрчилж байна.Шүүхийн өмнөх шатанд цагдан хоригдож байгаа насанд

хүрээгүй хүмүүс нь Хоригдолтой харьцах стандартын НҮБ-ын Журамд заасан бүх эрх, баталгаагаар хангагдана.Шүүхийн өмнөх шатанд цагдан хоригдож байгаа насанд хүрээгүй хүнийг насанд хүрэгчдээс тусад нь хорих бөгөөд тусгай байгууллага, эсхүл насанд хүрэгсэд хоригдож байгаа газрын тусгай хэсэгт байлгавал зохино.Цагдан хоригдож байгаа насанд хүрээгүй этгээдийн нас, хүйс, хувийн байдлыг харгалзан нийгэм, боловсрол, мэргэжил, сэтгэл зүй, эмнэлэг, бие махбодын шаардлагатай бүх туслалцаа, анхаарал халамж, хамгаалалт үзүүлбэл зохино(Насанд хүрээгүй хүмүүсийн талаар шүүн таслах ажиллагаа явуулахтай холбогдуулан НҮБ-аас гаргасан стандартын наад захын журам /Бээжингийн журам/13 дугаар зүйл).

ӨСВӨР НАСНЫ ЯЛЛАГДАГЧ - эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцсан өсвөр насны сэжигтнийг яллагдагч гэнэ. Өсвөр насны хүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлага нь түүний нас, биед тохирсон, эрүүл мэнд, ёс суртахуун, сэтгэцийн онцлогийг харгалзсан, нийгэмд өөрийн байр суурийг олоход туслах, боловсрол эзэмшүүлэх, үйлдсэн гэмт хэргийнх нь хор уршгийг ухамсарлуулах, гэмт хэрэг үйлдэхэд хүргэсэн орчин, хүмүүсийн нөлөөнөөс тусгаарлах, шаардлагатай тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнийг хорьж хүмүүжүүлэхэд чиглэсэн байна.

ӨСВӨР НАСНЫ ЯЛЛАГДАГЧИЙН ХЭРГИЙГ ТУСГААРЛАХ - хэрэв өсвөр насны хүн насанд хүрсэн хүний үйлдсэн гэмт хэрэгт хамтран оролцсон бол боломжийн хэрээр түүнийг мөрдөн байцаалтын шатанд тусгаарлана.Өсвөр насны хүний үйлдсэн хэргийг тусгаарлах явдал нь насанд хүрсэн хүнтэй хамт нэг хэрэгт татагдсан насанд хүрээгүй этгээд холбогдох хэргийг бүх талаас нь бүрэн бодитойгоор илрүүлэхэд ноцтой саад учруулж болзошгүй бол хэргийг тусгаарлахгүй.

ӨСВӨР НАСНЫ ЯЛЛАГДАГЧИЙГ БАЙЦААХАД СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭГЧИЙГ ОРОЛЦУУЛАХ - өсвөр насны сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгчийг оролцуулахаас гадна шаардлагатай гэж үзвэл сурган хүмүүжүүлэгч, эсхүл хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагын ажилтныг байлцуулж болно.Байцаалтад оролцсон сурган хүмүүжүүлэгч нь мөрдөн байцаагчийн зөвшөөрснөөр яллагдагчид асуулт тавих эрхтэй.

ӨСВӨР НАСНЫ ЯЛЛАГДАГЧ, ТҮҮНИЙ ЭЦЭГ ЭХ БУЮУ БУСАД ХУУЛЬ ЁСНЫ ТӨЛӨӨЛӨГЧИЙГ ХЭРГИЙН МАТЕРИАЛТАЙ ТАНИЛЦУУЛАХ - өсвөр насны яллагдагчид хавтаст хэргийн материалыг энэ хуульд заасны дагуу танилцуулахад түүний өмгөөлөгч, хууль ёсны төлөөлөгчийг оролцуулна. Өсвөр насны яллагдагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчиж болзошгүй гэж үзвэл мөрдөгч нь өсвөр насны яллагдагчид хавтаст хэргийн материалыг танилцуулахад түүний хууль ёсны төлөөлөгчийг оролцуулахгүй.

ТӨЛБӨРИЙН ЧАДВАРГҮЙ ӨСВӨР НАСНЫ ЯЛЛАГДАГЧИД ҮЗҮҮЛЭХ ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА - төлбөрийн чадваргүй өсвөр насны яллагдагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, хэрэгжүүлэх зорилгоор улсын өмгөөлөгчөөс үзүүлж байгаа хууль зүйн зөвлөгөө болон өмгөөллийн үйлчилгээг;

ТӨЛБӨРИЙН ЧАДВАРГҮЙ ӨСВӨР НАСНЫ ЯЛЛАГДАГЧ - Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4.1.1-д заасан эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд буюу эрүүл мэнд, амь нас, аюулгүй байдал, хөгжих хэвийн орчин нь алдагдсан, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хууль ёсны төлөөлөгчгүй, эсхүл гамшиг, онцгой байдлын нөхцөлд байгаа хүүхэд.

ТӨЛБӨРИЙН ЧАДВАРГҮЙ ӨСВӨР НАСНЫ ЯЛЛАГДАГЧИД ӨМГӨӨЛЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ - гэмт хэрэгт холбогдсон өсвөр насны яллагдагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахаар мөрдөх ажиллагаа болон гэмт хэргийг шүүхээр хянан шийдвэрлэхэд өмгөөлөгчөөр оролцохыг;

ТӨЛБӨРИЙН ЧАДВАРГҮЙ ӨСВӨР НАСНЫ ЯЛЛАГДАГЧИД ХУУЛЬ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ - хууль зүйн асуудлаар амаар болон бичгээр лавлагаа, мэдээлэл өгөх, хууль зүйн ач холбогдол бүхий баримт бичгийн эх боловсруулж туслахыг;

ҮЕ ТЭНГИЙНХНИЙ ХҮЧИРХИЙЛЭЛ - нэг хүүхэд нөгөө хүүхдээ бие махбодын, эсхүл сэтгэл санааны дарамт үзүүлэх үйлдэл. Мөн бэлгийн хүчирхийлэл энд орно. Энэ нь айлган сүрдүүлэх, зодох, байнга дооглох, тохуурхах, гадуурхах, бүлэглэн гадуурхах, нэр хоч өгөх зэрэг төрөл бүрийн хэлбэрээр илэрч болно. Цахим харилцаагаар дарамтлах, сүрдүүлэх, тохуурхах, нэр төрийг гутаан доромжлох үзэгдэл энэ нэр томъёонд хамаарна.

ҮЛ ХАЙХРАХ /ҮЛ ХАЙХРАХ ХАНДЛАГА - 1. Хүүхдийн эсрэг хүчирхийллийн нэг хэлбэр. 2. Хүүхдэдээ анхаарал халамж тавихгүй, зөнд нь орхих. 3. Хайр халамж хэт их дутсаны туйлын хэлбэр. 4. Хүүхдийн бие махбодын болон сэтгэл зүйн хэрэгцээг хангаж чадахгүй байх, тэднийг аюул, эрсдэлээс хамгаалж чадахгүй байх хүчирхийллийн хэлбэр; 5. Хүүхдийг зөвхөн эд мөнгө хөрөнгөний хэрэглэгч мэт хандах хандлага. Үүнд дараах үйлдэл болон эс үйлдэл багтана:

хүүхдийн аюулгүй байдлыг үл хайхрах - хүүхдийг хаях, төөрүүлэх, хараа хяналтгүй орхих, аюултай нөхцөл байдлыг мэдсээр байж хамгаалах арга хэмжээ авахгүй, эсхүл урьдчилан сэргийлэхгүй байх;

хүүхдийн боловсролыг үйл хайхрах - хүүхдийг сургуульд явуулах болон бусад байдлаар хүүхдийн боловсрол эзэмших нөхцөлийг хангах асран хамгаалагчийн хууль ёсны үүргээ биелүүлэхгүй байх;

хүүхдийн сэтгэл мэдрэмж болон сэтгэл санааг үл хайхрах - хүүхдэд сэтгэл санааны дэмжлэг, хайр халамж үзүүлэхгүй байх, хүүхдийг ноцтойгоор хайхрахгүй байх, асран хамгаалагч нь хүүхдийн өөрийгөө илэрхийлж буй дохио, харилцааг ойлгохгүй байх, ойр тойрны хүмүүс, харгалзан дэмжигчид нь хүчирхийлэл, мансууруулах бодис болон архийг хэтрүүлэн хэрэглэх сөрөг нөлөөлөлд хүүхдийг өртүүлэх;

хүүхдийг бие махбодын хувьд үл хайхрах - хүүхдэд хангалттай хараа хяналт тавихгүй байх зэргээр хүүхдийг аюул, эрсдэлээс хамгаалж чадахгүй байх, зохих хүнс тэжээл, орон байр, хувцас болон эрүүл мэндийн суурь үйлчилгээ зэрэг үндсэн хэрэгцээгээр хүүхдийг хангаж чадахгүй байх;

хүүхдийн бие махбодын болон сэтгэцийн эрүүл мэндийг үл хайхрах - зайлшгүй үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээнд хамруулахгүй байх, хойшлуулах; (Эх сурвалж: Хүүхдийн Эрхийн Хорооны 2011 онд гарсан Хүүхдийг бүх төрлийн хүчирхийллээс ангид байх эрхийн талаар 13 дугаар ерөнхий зөвлөмжийн 20 дугаар заалт).

хүүхдийг эд мөнгө хөрөнгөний хэрэглэгч мэт хандах – өдөр тутмын хэрэглээ, хэрэгцээт зүйлээр нь хангахыг илүүд үзэх хандлага. Энэ нь хүүхдийг зөвхөн хэрэглэгч мэт үзэхэд хүргэдэг. Эд мөнгөний талаар харьцангуй хангалттай гэр бүлүүдэд хүүхэд онцгой анхааралд байдаг ч эцэг эх нь тэдний хайрлуулах, хамт байх, халуун дулаан харилцаатай байх,

сэтгэл хөөрлийн хэрэгцээ, оюун санааны гансралыг нь огт хайхардаггүй. Хүүхдээ хэзээ ч энхрийлдэггүй, хүүхэдтэйгээ дотно сэтгэлээр ярилцдаггүй, тэдний гомдол гутрал, сэтгэлийн зовлон ба ололт амжилтыг нь огт сонирхдоггүй. Энэ нь хүүхдийнхээ сэтгэл хөдлөлийг хэрэгсэхгүй орхиж, өөрсдөө хүүхдээ хайрлахгүйгээр үл барам тэднийг дарамталж, яршиг төвөгтэй байдалд оруулдаг онцлогтой. Зан авираасаа үл шалтгаалан хүүхэд дэмжлэг, сайшаал, магтаалыг үл хүртэн, бүх алдаа зөрчлийг нь үргэлж анзаардгийн улмаас түүн рүү сануулга, сургамж, зэмлэлийн мөндрийг асган заримдаа эцэг эхчүүд хүчирхийлэл буюу зодуурт хүрдэг. (Дэлхийн Зөн Олон Улсын Байгууллага, Норвегийн Тусламжийн байгууллага. “Эрүүл мэндэд Хүүхдийн оролцоо гарын авлага”.УБ.,2013).

ХОРИХ ЯЛ - гэмт хэрэг үйлдсэн хүний эрх чөлөөг тодорхой хугацаагаар, эсхүл бүх насаар нь хязгаарлаж нээлттэй, эсхүл хаалттай хорих байгууллагад байлгахыг;

ХОРИХ ЯЛ ШИЙТГҮҮЛСЭН НАСАНД ХҮРЭЭГҮЙ (ӨСВӨР НАСНЫ) ХҮНИЙ АМРАЛТ ЧӨЛӨӨТ ЦАГ - насанд хүрээгүй хүн бүр хэрэв цаг агаарын нөхцөл боломжтой байгаа бол гадаа өдөр тутмын биеийн тамирын дасгал хийх хангалттай хэмжээний чөлөөт цагтай байх эрхтэй байх ёстой бөгөөд энэ хугацаанд эрүүлжүүлэх буюу биеийн тамирын зохих дасгал хийх боломжоор хангагдана.

ХОРИХ ЯЛ ШИЙТГҮҮЛСЭН НАСАНД ХҮРЭЭГҮЙ (ӨСВӨР НАСНЫ) ХҮНИЙГ НИЙГЭМШҮҮЛЭХ - хоригдож буй насанд хүрээгүй хүн өөрт холбогдох асуудлаар аль ч байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргах;өмгөөллийн болон хууль зүйн туслалцаа авах;холбогдох зардлаа өөрөө хариуцаж хорих байгууллагаас тогтоосон газарт шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээл туурвих;гэр бүлийн гишүүнтэй удаан, бусад хүнтэй түр хугацаагаар уулзах, суурин утас, захидлаар харилцах, илгээмж авах, өөрийн нэрийн дансаар дамжуулж мөнгөн гуйвуулга авах, явуулах;өөрийн зардлаар өдөр тутмын сонин, сэтгүүл захиалах, хорих анги дахь номын санг үнэ төлбөргүй ашиглах; урьд тогтоолгосон тэтгэвэр, тэтгэмжээ үргэлжлүүлэн авах, хуульд заасан болзол шаардлагыг хангасан тохиолдолд хуулиар тогтоосон тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох;өөрийн зардлаар их, дээд сургууль, коллежийн эчнээ сургалтад хамрагдах зэрэг нийгэмших харилцаанд оролцох эрхтэй.

ХОРИХ ЯЛ ШИЙТГҮҮЛСЭН НАСАНД ХҮРЭЭГҮЙ (ӨСВӨР НАСНЫ) ХҮНИЙ ШАШИН ШҮТЛЭГ - хоригдож буй насанд хүрээгүй хүн шашны зан үйл үйлдэх эрхтэй. Насанд хүрээгүй хүн бүрд шашин шүтлэгийн болон оюун санааны амьдралтай холбогдсон өөрийн эрэлт хэрэгцээгээ хангах, тухайлбал, засан хүмүүжүүлэх байгууллагад явагдаж байгаа хурал мөргөлд суух өөрийн шашны зан үйлд нийцүүлсэн мөргөлд оролцох, түүнчлэн шашны ёслолын зайлшгүй шаардлагатай ном, бусад эд зүйлийг ашиглах, өөрийн шашин шүтлэгт нийцсэн сургалт хийхийг зөвшөөрөх ёстой.(Хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй хүнийг хамгаалахтай холбогдуулан НҮБ-аас гаргасан журмын хавсралт. (1990). Зүйл 48).

ХОРИХ ЯЛ ШИЙТГҮҮЛСЭН НАСАНД ХҮРЭЭГҮЙ (ӨСВӨР НАСНЫ) ХҮНД ЯЛ ЭДЛҮҮЛЭХ - хорих ял шийтгүүлсэн өсвөр насны хоригдлын ялыг сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад эдлүүлнэ.(Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль/шинэчилсэн найруулга./ 201 дүгээр зүйл)Хорих ял эдэлж буй насанд хүрээгүй хүмүүс туйлын эмзэг байдаг учраас тэдний эрх ба сайн сайхныг хангах явдлыг хоригдох хугацаанд бататгахад онцгой анхаарал тавих шаардлагатай байгааг хүлээн зөвшөөрч байна.(Хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй хүнийг хамгаалахтай холбогдуулан НҮБ-аас гаргасан журам. /1990/. Зүйл 1).

ХОХИРОГЧИД ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ - хохирогчид хэрэгцээтэй мэдээлэл, эрх зүйн

болон сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, сэтгэл заслын үйлчилгээ, эмчилгээ хийх, нөхөн сэргээх, нийгэмшүүлэх болон аюулгүй байдлыг нь хангах, хамгаалах үйл ажиллагааг.

ХУУЛЬ ЗӨРЧСӨН ХҮҮХЭД - 1. Хууль тогтоомж зөрчсөн, гэмт хэрэг хийсэн нь шүүхээр тогтоогдсон хүүхдийг./Х.Б/. 3. Үйлдсэн хэрэгт нь тухайн улсын эрх зүйн тогтолцоо насанд хүрсэн хүнээс ялгаатай хэлбэрээр хариуцлага хүлээлгэхээр заасан хүүхэд буюу залуу хүнийг хэлнэ. (Насанд хүрээгүй хүмүүсийн талаар шүүн таслах ажиллагаа явуулахтай холбогдуулан НҮБ-аас гаргасан стандартын наад захын журам).

ХҮНИЙ ЭРХЭД (ХҮҮХДИЙН ЭРХЭД) СУУРИЛСАН ХАНДЛАГА - бүхий л үйл ажиллагаа, хөтөлбөр, арга хэмжээ нь хүний эрх, эрх чөлөөний олон улсын зарчим, стандартад суурилсан, хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалахад чиглэсэн байхыг; Эрхэд суурилсан хандлага нь хүний эрхийг дэмжин хамгаалах талаар төрийн үүрэг хариуцлагыг дээшлүүлэхэд чиглэдэг. Хөгжлийн эрхэд суурилсан хандлага нь дараах дөрвөн суурь зарчимд тулгуурладаг. Үүнд: а. Хувь хүн бол хөгжлийн гол объект, идэвхтэй оролцогч, эзэмшигч, манлайлагч бөгөөд хөгжлийн үр шимийг хүртэгч, б. Хөгжил, түүний бүх үе шатууд нь хүний эрхийн зарчмууд дээр үндэслэх, в.Хөгжил, түүний бүх үе шат нь Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын зарчмуудыг эрхэмлэх, г. Хөгжил, түүний бүх үе шат нь хүний эрхийн талаар ялангуяа төрийн хүлээсэн үүрэг хариуцлагын хэрэгжилттэй нийцэж байх.

ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАГЧ - хүний эрхийн зөрчлийн талаар мэдээлэл дамжуулах замаар хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг арилгахад чиглэгдсэн үйл ажиллагаа явуулж байгаа, хүний эрхийг хамгаалж, хөхиүлэн дэмжиж байгаа хүн, бүлэг этгээд, байгууллагыг;

ХҮҮХЭД ХАМГААЛАЛ - 1. Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, мөлжлөг гарахаас урьдчилан сэргийлэх, хариу үйлдэл үзүүлэхэд чиглэсэн санаачилга, үйл ажиллагааг;(Х.Б).

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН АСУУДАЛД ХАНДАХ ХАНДЛАГА - хүүхэд хамгааллын асуудлыг шийдвэрлэхэд баримталдаг уламжлал, шинэчлэлийн хандлага. 2 үндсэн хандлага байдаг. Үүнд:

асуудалд суурилсан хандлага - хүчирхийлэл, асрамж халамж, хүүхдийн тэвчишгүй хөдөлмөр гэх мэт нийгмийн асуудал тус бүрээр нь хүүхдийн бүлгүүдийг салган авч, тухайн бүлэгт чиглэсэн бодлого, үйлчилгээг үзүүлэхийг зорьдог. Энэ хэлбэр манайд нэлээд түгээмэл. Хүүхэд хамгааллын бодлого, үйлчилгээнд буюу урьдчилан сэргийлэх болон хариу үйлчилгээг хүүхдийн байгууллага, ажилтны хариуцах, шийдвэрлэх асуудал гэж ханддаг дутагдалтай. Энэ аргыг гал унтраах арга ч гэж нэрлэдэг.

тогтолцоонд суурилсан хандлага - бүх хүүхдийг аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгааллын зөрчил, эрсдэл гарсан тохиолдолд хариу үйлчилгээ үзүүлэх дэд бүтцийг бүрдүүлж ажилладаг. Үүрэг хүлээсэн хүн, талуудын жигд оролцоо, хууль, ёс зүйн хариуцлагыг нэгдмэл хэлбэрээр шаарддаг. Үр дүнг чухалд харж, хамтран ажилладаг, нэгдмэл ойлголт, стандарт шалгуур тавьж ханддагаараа давуу талтай. Тогтолцооны хандлагаар хандаж ажиллаж эхлэхэд багагүй сорилт бэрхшээл тулгарах ч түүнийг даван туулж, хамтран ажиллах талууд нэгдмэл зарчим, түгээмэл ойлголт, арга барилаа харилцан ойлголцвол хүүхэд, гэр бүлд тустай төдийгүй талуудын үзэл санаа, байр суурь бэхжих зөрчлийг шийдвэрлэж хөгжих боломж бий. Тогтолцоонд суурилсан хандлага нь хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ нь нарийн дэс дарааллаар хийгддэг. Мөн мэдээлэл хүлээн авахаас тухайн хүүхдийн үйлчилгээг

хаах хүртэл хүүхдийн аюулгүй байдалд учрах эрсдэлийн түвшин, үйлчилгээний явц, үр дүн, дүгнэлтээс хамаарч өөр өөр хувилбараар хэрэгждэг онцлогтой.

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН БОДЛОГО - 1. хүүхдэд учрах эрсдэл, хор нөлөөнөөс сэргийлж, хамгаалахын тулд байгууллага бүр анхаарал тавьж байгааг нотолсон баримт бичиг.Түүнд хүүхэд бүрт аюулгүй, эерэг орчин бүрдүүлэхийн тулд байгууллага, ажилтнууд, сайн дурын идэвхтнүүд болон бусад холбогдох хүмүүс юуг анхаарах ёстойг тусгасан байна. 2. хүүхдийн эрх ашиг хөндөгдөхөөс урьдчилан сэргийлсэн харьцангуй тогтвортой үзэл хандлага.

ХҮҮХДИЙГ ТАРЧЛААХ, ХҮНЛЭГ БУСААР ХАРЬЦАХ БОЛОН ШИЙТГЭХ - цагдаа, хууль сахиулах байгууллагын ажилтан албан хаагч, асрамжийн газар болон бусад байгууллага, зэвсэгт мөргөлдөөнд оролцогч нар зэрэг хүүхдийг эрхэндээ байлгаж буй аливаа хүмүүс хууль зөрчсөн болон сэтгэлд нийцээгүй зан байдал гаргасан хүүхдийг шүүхээс гадуур хэргийг нь хүлээлгэх, хүүхдийн хүсэл сонирхолд нийцэхгүй үйл ажиллагаанд албадан оруулах үүднээс хэрэглэж буй, хүүхдийн эсрэг аливаа төрлийн хүчирхийллийг хэлнэ. Хохирогч хүүхэд нь ихэвчлэн цөөнхөд харьяалагддаг, сул дорой, ялгаварлан гадуурхалд өртсөн хүүхэд байдаг бөгөөд тэдний эрх болон дээд эрх ашгийг хамгаалах насанд хүрсэн хүнгүй байдаг.Үүнд хууль зөрчсөн хүүхэд, гудамжинд амьдардаг хүүхэд, үндэсний цөөнх болон уугуул иргэдийн хүүхдүүд болон хараа хяналтгүй хүүхдүүд багтдаг байна.Энэхүү харгис хэрцгий үйлдэл нь насан туршид нь нөлөөлөх хор хөнөөлийг хүүхдийн бие махбод болон сэтгэл санаанд учруулж, нийгмийг стресстэй болгох нөхцөлийг бүрдүүлэх нь элбэг байдаг.(Эх сурвалж: Хүүхдийн Эрхийн Хорооны Хүүхдийг бүх төрлийн хүчирхийллээс ангид байх эрхийн талаар 13 дугаар ерөнхий зөвлөмжийн 26 дугаар заалт, 2011 он).

ХҮҮХДИЙГ ХАЯХ, ТӨӨРҮҮЛЭХ, ТЭНҮҮЧЛЭЛД ХҮРГЭХ - хүүхдийн эсрэг гэмт хэрэг. Хүүхэд хуулиар хүлээсэн асран хамгаалах, харгалзан дэмжих үүргээсээ зайлсхийж, хүүхдийг хаясан, орон гэрээ олох боломжгүй газар зориуд орхисон, хүүхдийг оршин суугаа газраас нь хөөж тэнүүчлэхэд хүргэсэн бол эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

ХҮҮХДЭД ЗОРИУЛСАН ХУУЛЬ ЗҮЙН ХАНДЛАГА - хүүхдийн эрх ашгийг хамгаалсан, тэдэнд бүрэн дүүрэн үйлчилсэн эрх зүйн тогтолцоог бүрдүүлэх чинхүү хүсэл эрмэлзлэлийг; Ялангуяа эрх зүйн тогтолцоонд оролцож байгаа гэрч, хохирогч хүүхэд, яллагдагч хүүхэд, эсхүл шүүхэд оролцоо шаардлагатай бусад шалтгаан бүхий хүүхэд, тухайлбал асран хамгаалал, харгалзан дэмжигч, хамгаалалтын асуудлаар бүх хүүхдэд олон улсын хэм хэмжээ стандартыг бүрэн хэрэглэх явдлыг хангах явдал юм(Хүүхдэд зориулсан хууль зүйн асуудалд НҮБ-аас баримтлах нийтлэг чиг хандлага. 6 дахь тал).

ХҮҮХДИЙН МӨЛЖЛӨГ - хүүхдийн эрүүл мэнд, хөгжил, боловсролд хохирол учруулах хөдөлмөр, түүний тэвчишгүй хэлбэр, биеийг нь үнэлүүлэх буюу бэлгийн хүчирхийллийн шинжтэй бусад үйлдэл үзүүлэх, хүүхдийг албадан ажиллуулах буюу үйлчлүүлэх, боолчлол буюу боолчлолтой төсөөтэй заншил, эрх чөлөөгүй байдалд байлгах, хүүхдийн эд, эрхтнийг нь авах зэргээр ашиг хонжооны хэрэгсэл болгохыг. Үүнд хүүхдийн хөдөлмөр, бэлгийн мөлжлөг, хүүхэд худалдаалах зэрэг хамаарна.

БЭЛГИЙН МӨЛЖЛӨГ - насанд хүрэгчид хүүхэдтэй бэлгийн харилцаанд орж, өөрт нь, эсвэл гуравдагч этгээд, бусад этгээдэд бэлэн мөнгө, эсхүл биет зүйлээр төлбөр төлж байгаа үйлдэл. Хүүхдийн бэлгийн мөлжлөг нь дараах хэлбэртэй: Үүнд:

хүүхдийн биеийг үнэлэх - 1. Шан харамж буюу бусад аливаа төлбөрийн хэлбэрээр хүүхдийг

бэлгийн харилцаанд ашиглахыг; 2.Төлбөр авах болон бусад хэлбэрээр ашиг олох үүднээс хүүхдийг биеэ үнэлэх үйл ажиллагаанд татан оруулж ашиглах;

хүүхдийг садар самуунд ашиглах - бэлгийн амьдралыг ил тод харуулан дүрслэн бичсэн бичлэг, видео бичлэг, зураг бүтээхдээ хүүхдийг оролцуулах үйлдэл;

садар самуунд уруу татах - хүүхдийг бэлгийн хавьталд орж буй байдлаар, эсхүл бэлгийн үйл ажиллагаа илэрхий хийж буй мэтээр дүр, дүрслэлийн бүх аргыг хэрэглэн үзүүлэх, эсхүл зөвхөн бэлгийн зорилгоор хүүхдийн бие, бэлэг эрхтний хэсгийг харуулах, үзүүлэх;

бэлгийн мөлжлөгийн зорилгоор дамжуулан худалдаалах - хүүхдийг албадан буюу хүчээр биеийг нь үнэлүүлэх, эсхүл садар самуунд татан оруулж ашиг олох зорилгоор тухайн орны нутаг дэвсгэр дээр, эсхүл хил дамжуулан зөөвөрлөх;

секс аялал жуулчлалд ашиглах - хүүхэдтэй бэлгийн хавьталд орох зорилгоор гадаадын оронд, ялангуяа буурай хөгжилтэй оронд зорчиж, хүүхдийг садар самуунд ашиглан мөлжих;

эрт гэрлэлт - 18 нас хүрээгүй хүн гэр бүл болох.(Эх сурвалж: Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг Хүүхдийн эрхийн тухай Конвенцод оруулах Нэмэлт протокол).

ХҮҮХДИЙН НАЙМАА - хүүхдийг мөнгөн урамшуулал болон бусад зүйлсээр хэн нэгэн хүн болон бүлэг хүмүүст шилжүүлэх аливаа үйлдлийг хэлнэ. (Эх сурвалж: Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг Хүүхдийн эрхийн тухай Конвенцод оруулах Нэмэлт протоколын 2 дугаар зүйл).

ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ- 1. хүүхдийн эрхийн зөрчил, дарамтаас урьдчилан сэргийлэх, хамгаалах,зөрчигдсөн эрхийг нь сэргээх, хохирлыг арилгах механизмыг бий болгох, боловсронгуй болгох хууль, эрх зүйн цогц арга хэмжээ авахыг; 2. хүүхдийн эрх, эрх чөлөө зөрчигдөхөөс сэргийлсэн, хариу арга хэмжээ авахад чиглэсэн хууль, эрх зүйн болон хариуцлагын нэгдмэл тогтолцоо бий болгож, хэрэгжүүлэхийг.(Х.Б).

ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАНГАХ (хэрэгжүүлэх) - хүүхэд эрхээ эдлэхийг бүх талаар дэмжих, туслах, хангах нөхцөл, боломжийг бүрдүүлэх, баталгааг бий болгох арга хэмжээ авахыг; (Х.Б).

ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХҮНДЭТГЭХ - хүүхдийн аливаа эрхийг ямар ч цаг үед зөрчихгүй байх, зөрчлийг хүлээн зөвшөөрөхгүй, дэмжихгүй байх, зөрчил гарсан тохиолдолд зохих арга хэмжээг нэн даруй авах чин хүсэл бүхий хүүхдийн эрхийг эрхэмлэх зан үйл, соёлын хандлага юм. (Х.Б).

ХҮҮХДИЙН ЭРХИЙН ЗӨРЧИЛ - 1. хүүхдийн эрхийн талаарх хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг ;(Х.Б). 2. хүүхэд жам ёсны болон хууль ёсны эрхээ эдлэх боломжгүй нөхцөл байдал үүссэнийг(Х.Б).

ХҮҮХДИЙН ЭРХИЙН ХАМГААЛАЛТ - Арилжааны шинжтэй болон бэлгийн мөлжлөг, хүүхэд худалдаалах, хүүхдийн хөдөлмөр, эрүүл мэндэд хор хохирол учруулах уламжлалт ёс ёслол зэргийг оролцуулаад мөлжих, хэрцгий догшин харьцах, хүч хэрэглэхээс урьдчилан сэргийлэх, «хариуцах» гэж ойлгоно. Хүүхдийн эрхийн хамгаалалт нь юуны түрүүнд гэр бүлийн асрамжаа алдсан, хуультай сөргөлдсөн, түүнчлэн зэвсэгт мөргөлдөөний нөхцөлд амьдарч байгаа хүүхдэд хамаарна. (Хүүхдийн эрхийг хамгаалах тухай нэр томъёоны толь. ЮНИСЕФ. Казакстан. 2007).

ХҮҮХДИЙН ЭСРЭГ ХҮЧИРХИЙЛЭЛ - 1. Аливаа хэлбэрийн хүчирхийллийн улмаас хүүхдийн бие махбод, сэтгэл санааны халдашгүй дархан байдлыг алдагдуулах үйлдэл, эс үйлдэл. 2. бие махбодын болон сэтгэл зүйн харгис хандлага, бэлгийн хүчирхийлэл, хараа хяналтгүй байдал болон эцэг эх байх үүргээ биелүүлэхээс татгалзах, хүүхдийн амьдрах, эрүүл байх, хөгжих, нэр төр, итгэлд шууд буюу далд гэм хор учруулсан арилжааны болон бусад мөлжлөгийн бүхий л хэлбэр (Хүүхдийн эрхийг хамгаалах тухай нэр томьёоны толь. ЮНИСЕФ. Казакстан.2007). 3.18 нас хүрээгүй хүүхдийг гомдоох, гадуурхах явдал юм. Үүнд бие махбодын, сэтгэл санааны, бэлгийн дарамт, гадуурхалт, арилжааны буюу өөр хэлбэрийн хүчирхийлэл зэрэг хүүхдийн эрүүл мэнд, амьдрал, хөгжил, хувь хүний эрхэм зан чанарт хор учруулах хэлбэрүүд багтана (INSPIRE: Seven Strategies for Ending Violence Against Children, WHO.,2016). Хүүхдийн эрхийн 13 дугаар Ерөнхий зөвлөмжид “хүчирхийлэл” гэдэг нь ХЭК-ийн 19 дүгээр зүйлийн нэгт заасанчлан хүүхдийн эсрэг аливаа төрлийн хор хөнөөлтэй үйлдлийг нэрлэх бөгөөд уг нэр томьёо нь 2006 оны НҮБ-ын хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаарх судалгааны нэр томьёотой нийцэж байдаг. Хэдий тийм ч гэсэн хор хөнөөл гэдгийг нэрлэсэн өөр үг хэллэгүүд (гэмтэл учруулах, дарамт, үл хайхрах, үл хайхарсан үйлдэл, зүй бус харилцаа болон мөлжлөг зэрэг) нь мөн ижил утга санааг илтгэж байдаг (Эх сурвалж: Хүүхдийн Эрхийн Хорооны Хүүхдийг бүх төрлийн хүчирхийллээс ангид байх эрхийн талаар 13 дугаар ерөнхий зөвлөмжийн 17 дугаар заалт, 2011 он). Хүүхдийн эсрэг хүчирхийллийг үйлдэл, үр дагаврын шинж байдлаас нь хамааруулан дөрвөн хэлбэрт хуваадаг байна. Үүнд:

хүүхдийн эсрэг бие махбодын хүчирхийлэл: - хүүхдийн бие махбодид ямар нэг хэмжээгээр халдах, бие махбодид хохирол амсаж болзошгүй нөхцөлд оруулах үйлдэл эс үйлдлийг; Үүнд ноцтой болон ноцтой бус бие мах бодын хүчирхийлэл багтана. Үүнд дараах үйлдэл багтана: бүхий л төрлийн бие махбодын шийтгэл болон тарчлаах, хэрцгий, хүнлэг бус зохисгүй харилцаа, шийтгэлийн бусад бүхий л хэлбэрүүд; насанд хүрэгчид болон бусад хүүхдүүдийн зүгээс зодох, дээрэлхэх, тэднийг шоглож тохуурхах (Эх сурвалж: Хүүхдийн Эрхийн Хорооны 2011 онд гарсан Хүүхдийг бүх төрлийн хүчирхийллээс ангид байх эрхийн талаар 13 дугаар ерөнхий зөвлөмжийн 22 дугаар заалт).

хүүхдийн эсрэг бие махбодын шийтгэл - биеийн хүч ашиглан хүнд, хөнгөн хэлбэрийн өвдөлт эсвэл таагүй байдал мэдрүүлэхийг чармайсан аливаа хэлбэрийн шийтгэлийг бие махбодын шийтгэл гэнэ. Гараараа юм уу ташуур, саваа, бүс, гутал, гулууз гэх мэт хэрэгслээр цохих, алгадах, гуядах, ташуурдах, саваадах нь хамгийн түгээмэл хэлбэр юм. Түүнчлэн өшиглөх, сэгсрэх, шидэх, самардах, чимхэх, хазах, үсийг нь зулгаах, чихийг нь татах, эвгүй байдлаар зогсоох, суулгах, түлэх, шалзлах, хүчээр ямар нэг юм залгиулах зэрэг багтана. Бие махбодын хүчирхийллийн аль ч хэлбэр хүүхдэд сөрөг нөлөөтэй гэж Хороо үздэг (Эх сурвалж: 2006 оны Хүүхдийн эрхийн конвенцын 8-р ерөнхий зөвлөмж. 12-р зүйл- Бие махбодын шийтгэл болон гутаан доромжилсон бусад хэлбэрийн шийтгэлээс хамгаалагдах хүүхдийн эрх).

сэтгэл санааны дарамт(хүчирхийлэл) - хүүхдийн сэтгэл санааны хувьд амар амгалан, тайван байдлыг эвдэж буй аливаа төрлийн үйлдэл, эс үйлдэхүйг; Хүүхдийн Эрхийн тухай Конвенцод заасанчлан сэтгэл санааны хүчирхийлэл гэдэгт сэтгэл хямруулсан зүй бус харилцаа, сэтгэл санааны дарамт хүчирхийлэл, үг хэлээр дарамтлах, үл хайхрах зэргийг оруулж ойлгох бөгөөд дараах үйлдлүүд багтана: Үүнд: хүүхдэд өөрийг нь үнэ цэнгүй, хэн ч түүнийг хайрладаггүй, хүсээгүй, аюултай, бусдын хэрэгцээг хангахад л ашигтай зүйл мэтээр ойлгуулах зэрэг хүүхдэд хор хөнөөлтэй урт хугацаанд давтагдах харилцааны аливаа хэлбэрүүд; айлгах, заналхийлэх, сүрдүүлэх; хүүхдийг мөлжих, сөргөөр нөлөөлөх, тэднийг

хажиглаж, тээршээх, тусгаарлаж, тоохгүй байх, нэгнийг нь нөгөөгөөс нь илүүд үзэх; сэтгэлийн хариу үйлдэл үзүүлэхгүй байх; сэтгэцийн эрүүл мэнд, эрүүл мэнд боловсролын хэрэгцээг нь үл хайхрах; доромжлох, хочлох, гутаан доромжлох, басамжлах, дооглох, хүүхдийн сэтгэлд сэв суулгах; хүүхдийн хажууд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх; ганцаарчлан хорих, хүүхдийн хорих газарт тэднийг гутаан доромжилсон, ганцаардуулсан байдалтай байлгах; гар утас, интернэт зэрэг мэдээлэл харилцааны технологиор дамжуулан насанд хүрэгчид болон бусад хүүхдүүд хүүхдийг сэтгэл санаагаар дарамтлах (*Эх сурвалж: Хүүхдийн Эрхийн Хорооны Хүүхдийг бүх төрлийн хүчирхийллээс ангид байх эрхийн талаар 13 дугаар ерөнхий зөвлөмжийн 21 дугаар заалт, 2011 он*).

бэлгийн хүчирхийлэл - хэн нэгэн хүүхдийг бэлгийн сонирхлоор илж таалах, үнсэх зэргээр хүчиндэх хүртэлх үйлдлийг; үндэсний хууль тогтоомжид заагдсан бэлгийн харилцаанд орохыг зөвшөөрсөн хуулийн насанд хүрээгүй хүүхэдтэй ийм харилцаанд орохыг эсхүл айлган сүрдүүлэх, хүч хэрэглэх; гэр бүлийн гишүүн гэх мэт хүүхдэд нөлөөтэй, эрх мэдэлтэй, итгэл хүлээсэн хүн нь энэ давуу байдлаараа түрүү барих; хүүхдийн бие махбод, оюуны бэрхшээлтэй байдал гэх мэт эмзэг байдалд байгаа, хүчирхийлэгчээс хамааралтай зэрэг нөхцөл байдлыг нь далимдуулах замаар хүүхдийг бэлгийн харилцаанд оруулахыг (*Эх сурвалж: 2007 онд батлагдаж 2010 онд хүчин төгөлдөр болсон Хүүхдийн бэлгийн мөлжлөг, бэлгийн хүчирхийллийн эсрэг хүүхэд хамгааллын Европын конвенцын 18-23-р заалт*).

бэлгийн мөлжлөг - үндэсний хууль тогтоомжид заагдсан бэлгийн харилцаанд орохыг зөвшөөрсөн хуулийн насанд хүрээгүй хүүхдийг зориудаар бэлгийн харилцаанд уруу татах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг порнограф, садар самуун сурталчилгаа, тоглолтод элсүүлэх, албадах, хүүхдийг садар самуунд оролцох шалтгааныг тавих, ийм маягийн тоглолтоор орлого олох, хүүхдийг ийм зорилгоор мөлжих, хүүхэд оролцсоныг нь мэдсээр байж ийм тоглолтод очих, хүүхдийг оролцуулаагүй ч гэсэн бэлгийн хүчирхийлэл, бэлгийн харилцааны гэрч болгох зэрэг үйлдлүүд (*Эх сурвалж: 2007 онд батлагдаж 2010 онд хүчин төгөлдөр болсон Хүүхдийн бэлгийн мөлжлөг, бэлгийн хүчирхийллийн эсрэг хүүхэд хамгааллын Европын конвенцын 18-23-р заалт*).

үл хайхрах - 1.асран халамжлах үүрэг хүлээсэн хэн нэгэн этгээд хүүхдийн суурь хэрэгцээг нь гачигдуулсны улмаас хүүхдэд гэм хор учруулсан эсвэл учруулахаар завдсан үйлдэл, эс үйлдлийг; (НХХЯ, ХХХТ, НҮБХС, Хүүхдийн эсрэг хүчирхийлэл: сургагч багш нарт зориулсан гарын авлага. УБ., 2008. 37 дахь тал). 2. хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчид хүүхдийг үл тоон, анхаарал халамж хангалтгүй үзүүлсэн, хэрэгцээт зүйлсээр гачигдуулсны улмаас хүүхдийн бие махбод, сэтгэл санаа, эрүүл мэндэд нь хохирол учрахыг үл хайхрах гэнэ. Үл хайхрах явдал гэдэг нь хүүхдийг хангалтай хооллохгүй байх, орон байраар хангахгүй байх, эрүүл мэндийн суурь үйлчилгээнд хамруулахгүй байх, эрсдэлтэй нөхцөл байдлаас хамгаалахгүй байх, хүүхдийг эрүүл мэнд, хөгжил, аюулгүй байдлын эрсдэлд оруулах үйлдэл, эс үйлдлүүд багтана.

хүүхэд хоорондын хүчирхийлэл - ихэвчлэн дээрэлхэх байдлаар хэсэг бүлэг хүүхэд нийлж үйлддэг, богино хугацаанд хүүхдийн бие мах бодь болон сэтгэл зүйн байдалд хөр хөнөөл учруулдаг хэдий ч дунд болон урт хугацаандаа хүүхдийн өсөлт хөгжил боловсрол, нийгмийн оролцоонд ноцтой нөлөө үзүүлдэг, хүүхдүүд бусад хүүхдийн эсрэг үйлддэг бие махбод, сэтгэл санаа болон бэлгийн хүчирхийлэл юм. Мөн өсвөр насны хүүхдүүдийн бүлэглэн үйлдсэн хүчирхийлэл нь хохирогч болон оролцогч хүүхдүүдэд ноцтой хор уршигтай байдаг.

Хэдийгээр уг үйлдлийг хүүхдүүд өөрсдөө үйлдэж байгаа ч гэсэн уг хүчирхийлэлд зохих хариу үйлдэл үзүүлэх, сэргийлэх, хүчирхийллийг шийтгэл, хүчирхийллээр шийдэхгүй байх алхмуудыг бүрдүүлэхэд насанд хүрэгчид үүрэг хүлээх ёстой (*Эх сурвалж: Хүүхдийн Эрхийн Хорооны Хүүхдийг бүх төрлийн хүчирхийллээс ангид байх эрхийн талаар 13 дугаар ерөнхий зөвлөмжийн 2 дугаар заалт*).

ХҮЧИРХИЙЛЛИЙН ХОХИРОГЧ ХҮҮХЭД - Гэр бүл, боловсролын байгууллага, асран хамгаалалтад байхдаа хүчирхийлэлд (биеийн, бэлгийн, сэтгэл зүйн хүчирхийлэл, доромжлол болон урвуулан ашиглалт, анхаарал халамж дутсан буюу хайхрамжгүй, хэрцгий хандалт болон мөлжлөгт) өртсөн буюу өртөж байгаа хүүхэд. (*Хүүхдийн эрхийг хамгаалах тухай нэр томъёоны толь.ЮНИСЕФ.Казакстан.2007*).

ХЭРЦГИЙ, ХҮНЛЭГ БУС, НЭР ТӨРИЙГ ДОРОМЖЛОН ХАРЬЦАХ БУЮУ ШИЙТГЭХЭЭС АНГИД БАЙХ ЭРХ - аливаа хүнийг хийсэн эрүүгийн гэмт хэргийн төлөө залхаан цээрлүүлэх, хүнлэг бусаар хандах, шийтгэх, бие махбод, сэтгэл санааг нь шаналган зовоох, нэр төрийг нь доромжлон харьцах зэргээр төрийн зүгээс хийж буй үйлдлээс хамгаалуулах эрх.»Хэнд ч эрүү шүүлт тулган эсхүл хэнтэй ч хэрцгийгээр, хүний ёсноос гадуур буюу нэр төрийг нь доромжлон харьцах, шийтгэх ёсгүй.»(Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын 5 дугаар зүйл). «Хэнд ч эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар, нэр төрийг нь доромжлон харьцах буюу шийтгэхийг хориглоно»(Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 7 дугаар зүйл). «хүүхдэд эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар, нэр төрийг нь доромжлон харьцах буюу шийтгэхгүй байх.»(Хүүхдийн Эрхийн тухай Конвенцын 37 дугаар зүйлийн (а)заалт). «Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй (*МУ-ын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь заалт*).

бие махбод, сэтгэл санааг шаналгах - тамлан зовоох, айлган сүрдүүлэх, дарамтлах хэлбэрийн харгис үйлдлийг;

нэр төрийг доромжлон харьцах, шийтгэх - хүнийг айлган сүрдүүлэх, тарчлаах, эрхшээлдээ оруулах зорилгоор хүний эрхэм чанар, үнэлэмжийг үл ойшоон доромжлох, бие махбод, сэтгэл санааг нь хүчтэй шаналган зовоож, шийтгэхийг;

хүнлэг бусаар хандах - аливаа хүнд хийсэн гэмт хэрэг зөрчилтэй нь холбоогүйгээр хүнлэг бусаар хандахыг;

хүнлэг бусаар шийтгэх - өмнө нь хийсэн гэмт хэрэг, зөрчилтэй нь холбогдуулан шийтгэх зорилгоор хийсэн хүнлэг бус үйлдлийг;

хэрцгийгээр хандах - төрийн зүгээс аливаа хүнд хүнлэг бусаар гэмтэл, шаналал учруулахыг;

хэрцгийгээр шийтгэх - аливаа хүнийг хийсэн эрүүгийн хэргийн төлөө залхаан цээрлүүлэх зорилгоор төрийн зүгээс хийж буй үйлдлийг;

ЦАХИМ ГАДУУРХАЛ - цахим мэдээллийн хэрэгсэл, технологи ашиглан бусдын эсрэг (шоовдорлох, өөнтөглөх, гутаан доромжлох, нэр төрд нь халдах, улмаар хувийн нууцыг задруулах зэргээр) сөрөг мэдээлэл түгээх үйлдлийг;(Х.Б).

ЦАХИМ ГЭМТ ХЭРЭГ - цахим мэдээллийн хэрэгсэл, программ хангамж ашиглан бусдыг дарамтлах, айлган сүрдүүлэх, хууран мэхлэх замаар үйлдэгдэх хүний эрх, эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийг;(Х.Б).

ШҮҮХИЙН ӨМНӨХ ШАТАНД ХОРЬЖ СААТУУЛАХААС ЗАЙЛСХИЙХ -тодорхой хэргийг мөрдөн шалгах хийгээд нийгэм, хохирогчийг хамгаалах зорилгоор шүүхийн өмнөх шатанд хорьж саатуулах явдлыг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны онцгой арга хэмжээ болгож хэрэглэх ёстой.Шүүхийн өмнөх шатанд хорьж саатуулахыг орлох бусад арга хэмжээг боломжийн хэрээр аль болох эхэлж хэрэглэнэ. Шүүхийн хэлэлцүүлгээс өмнө хорьж саатуулах арга хэмжээ нь нийгэм, хохирогчийг хамгаалах зорилгоор хорьж саатуулах хэмжээнээс хэтрэх ёсгүй бөгөөд хүний нэр төрийг нь хүндэтгэж энэрэнгүй байдлаар хэрэглэгдэнэ.Эрх зүйн зөрчил гаргагч шүүхийн өмнөх шатанд хоригдож саатуулагдсан тохиолдолд шүүх болон бусад хараат бус эрх бүхий байгууллагад давж заалдах эрхтэй(Нэгдсэн Үндэсний Байгууллагын хорихоос өөр төрлийн арга хэмжээнд холбогдох наад захын жишиг дүрэм/Токиогийн дүрэм).

ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭХ НАС - насанд хүрээгүй хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх насны ойлголтыг аливаа эрх зүйн тогтолцоонд хүлээн зөвшөөрөхдөө насны доод хязгаар нь сэтгэл хөдлөл, оюун санаа, ухаан санааны хөгжлийг харгалзан хэт бага насаар тогтоож болохгүй(Насанд хүрээгүй хүмүүсийн талаар шүүн таслах ажиллагаа явуулахтай холбогдуулан НҮБ-аас гаргасан стандартын наад захын журам /Бээжингийн журам).

ЭРҮҮШҮҮЛТ - 1. “Эрүүдэн шүүх” гэж хэн нэг хүн буюу гурав дахь этгээдээс мэдээ сэлт, мэдүүлэг авах, тухайн хүн буюу гурав дахь этгээдийн үйлдсэн буюу сэрдэгдсэн хэрэгт шийтгэх, айлган сүрдүүлэх, шахалт үзүүлэх, аливаа байдлаар алагчлах зорилгоор төрийн албан тушаалтан, албан үүрэг гүйцэтгэж буй бусад хүний өдөөн хатгалт, ил, далд зөвшөөрлөөр тухайн хүн буюу гурав дахь этгээдийн бие махбод, сэтгэл санааг хүчтэй шаналган зовоох аливаа санаатай үйлдлийг;(Хүнийг эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу нэр төрийг нь доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын 1 дүгээр зүйл, 1984 он).2.Гэмт хэрэг үйлдсэн, эсвэл үйлдсэн гэж сэжиглэгдэж байгаа хүнээс мэдээлэл авах, хэрэг хүлээлгэх, шийтгэх, айлгах, албадах зорилгоор эсвэл ялгаварлан гадуурхлын улмаас бие махбод, сэтгэл санаанд нь санаатайгаар ноцтой өвдөлт, зовоолт мэдрүүлэх аливаа үйлдлийг эрх бүхий байгууллага, ажилтны зөвшөөрлөөр өөрөө эсвэл гуравдагч этгээдээр дамжуулан үзүүлэхийг хэлнэ.(Эх сурвалж: 1984 онд батлагдаж, 1987 онд хүчин төгөлдөр болсон Эрүү шүүлт болон бусад хэрцгий, хүнлэг бус, зүй бус харьцаа болон шийтгэлийн эсрэг конвенц, 1 дүгээр зүйл).

ЭРХ ЗҮЙН ЗӨРЧИЛ ГАРГАГЧ - хорихоос өөр төрлийн арга хэмжээнд холбогдох наад захын жишиг дүрмийн хамаарах заалтууд нь мөрдөн байцаалтад шүүхийн хэлэлцүүлэг болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх зэрэг байцаан шийтгэх эрүүгийн бүх шатны сэжигтэн, яллагч, шүүгдэгч хэн байхаас үл хамааран бүх этгээдэд хэрэглэнэ. Эдгээр этгээдийг эрхийн зөрчил гаргагч этгээд гэнэ.(Нэгдсэн Үндэсний Байгууллагын хорихоос өөр төрлийн арга хэмжээнд холбогдох наад захын жишиг дүрэм/Токиогийн дүрэм / 2 зүйлийн 2.1 дэх хэсэг).

ЯЛ ШИЙТГЭЛГҮЙ БОЛСОН ГЭЖ ҮЗЭХ - насанд хүрээгүй этгээд хорих ял оногдуулсан таслан шийдвэрлэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд гэмт хэрэг шинээр үйлдээгүй бөгөөд таслан шийдвэрлэх тогтоолыг тогтоосон журмаар биелүүлээгүй бол ял шийтгэлгүй болсон гэж үзнэ.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Монгол Улсын хууль

1. Бага, дунд боловсролын тухай хууль (2002)
2. Боловсролын тухай хууль (2002)
3. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль (2016)
4. Гэр бүлийн тухай хууль (1999)
5. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль (2013)
6. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль (2019)
7. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль (2011)
8. Засгийн газрын тусгай сангийн тухай хууль (2019)
9. Монгол Улсын үндсэн хууль (1992)
10. Нийгмийн халамжийн тухай хууль (2012)
11. Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль (1999)
12. Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль (2013)
13. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль (2011)
14. Хүүхэд хамгааллын тухай хууль (2016)
15. Хүүхдийн эрхийн тухай хууль (2016)
16. Цагдаагийн албаны тухай хууль (2017)
17. Эрүүгийн хууль (2015)
18. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хууль (2017)

Монгол Улсын олон улсын гэрээ

19. Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын конвенц (1989)
20. Хүний эрхийн түгээмэл тунхаглал (1945)
21. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (1976)
22. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт (1976)
23. Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг хориглох, нэн даруй устгах тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 182 дугаар конвенц (1999)
24. Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг хүүхдийн эрхийн тухай конвенцод оруулах нэмэлт протокол (2000)
25. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц (1987)
26. Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэм (2002)
27. Хүүхдийн эрхийн тухай конвенцын “мэдээлэл хүргүүлэх журмын тухай” нэмэлт протокол (2014)
28. Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц (1981)

Олон улсын стандарт баримт бичгүүд

29. Насанд хүрээгүй хүнийг гэмт явдлаас урьдчилан сэргийлэх НҮБ-ын зарчим (1990)
30. Гэмт хэргийн гэрч, хохирогч хүүхдийн асуудалтай холбогдох шүүх эрх зүйн үйл ажиллагааны журам (2005)

31. Насанд хүрээгүй хүний холбогдсон хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь хүүхдийн эрх НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооны ерөнхий зөвлөмж №10 (2007)
32. Гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн асуудлаар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүүхэдтэй ажиллах заавар НЭЗЗ-ийн 30 дугаар тогтоол (1997)
33. Хорихоос өөр төрлийн арга хэмжээнд НҮБ-аас баримтлах дүрэм (1990)
34. Эрх чөлөөгөө хязгаарлуулсан насанд хүрээгүй хүнийг хамгаалахтай холбогдуулан гаргасан НҮБ-ын журам/дүрэм (1990)
35. Насанд хүрээгүй хүмүүсийн талаар шүүн таслах ажиллагаа явуулахтай холбогдуулан
36. НҮБ - аас гаргасан стандартын наад захын журам /Бээжингийн дүрэм/ (1985)
37. Насанд хүрээгүй хүмүүсийг гэмт явдлаас урьдчилан сэргийлэх талаар НҮБ-аас гаргасан
38. үндсэн зарчим(Эр-Риадын үндсэн зарчим) (1990)

Бусад эх сурвалжууд:

39. <https://www.legalinfo.mn/law>. Хуулийн нэгдсэн портал сайт.
40. Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр. УБ, 2017 он.
41. ХЭХЗХ-ны журмын хэрэгжилтэд хийсэн үнэлгээний тайлан. ХЭССХ. УБ, 2021 он.
42. Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийн үнэлгээ.. Корам Интернейшнл, 2020 он.
43. НҮБ-ын Хүүхдийн Сан, ХЗДХЯ, МУИС-ийн ХЗС. Хүүхдийн эрх, хүүхэд хамгаалал. УБ., 2011 он.
44. ХЭК ийн хэрэгжилтийн талаарх МУЗГ-ын Ү тайланд НҮБХЭХ- ны өгсөн дүгнэлт, зөвлөмж , УБ, 2017 он.
45. ХЗҮХ, Хүүхдийн асуудал хариуцах хорооны дүрмийг боловсронгуй болгох, хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах судалгаа. УБ., 2009 он.
46. Баавгай Х, Энхбаатар А. Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны гишүүдэд зориулсан гарын авлага. ХЗДХЯ, ГБХЗХГ, МУГХУСАЗЗ. УБ., 2019 он.
47. Баавгай Х. Хүүхдийн эрх, хамгаалалтай холбогдох нэр томьёо, ухагдахууны тайлбар толь. УБ., 2018 он
48. Батзориг Б, Баавгай Х, Жавзанхүү Б нар, Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн гарын авлага. Гүүд Нейборс ОУТББ, ГБХЗХГ. УБ., 2017 он.
49. Жавзанхүү Б, Ганбадрах Г. Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооноос хүүхдэд үзүүлэх үйлчилгээний арга зүй. УБ., 2021 он.
50. Оюунболд Г. Шоронгоос суллагдсан хүмүүст нийгэмд дасан зохицоход дэмжлэг үзүүлэх бодлого боловсруулах нь. Бодлогын судалгааны тайлан, 2011 он.
51. Статистик мэдээллийн нэгдсэн сан-1212. ҮСХ, 2021 он.
52. Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт жендэрийн талаар баримтлах бодлого. 2018 он.
53. Жендэрийн нэр томьёо тодорхойлолт, үндсэн ойлголтуудын тайлбар толь. УБ, 2013 он
54. “Жендэрт суурилсан хүчирхийллээс сэргийлэх” сургалтын модуль. НҮБХАС, МУБИС. 2014 он.\